

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
12 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-28
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	29-94
	1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	29-94

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 18-ны өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 38 гишүүн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 38 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Жавхлан, Д.Мурат, З.Нарантуяа, Д.Сарангэрэл, Н.Цэрэнбат, Л.Энхболд, М.Энхболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Ганболд, Ц.Гарамжав, Л.Мөнхбаатар;

Тасалсан: Ж.Мөнхбат, Б.Наранхүү, Н.Номтойбаяр;

Хоцорсон: О.Баасанхүү- 1 цаг 09 минут, С.Батболд- 30 минут, Б.Баттөмөр-1 цаг 08 минут, М.Билэгт- 17 минут, Б.Дэлгэрсайхан- 17 минут, Б.Жавхлан- 18 минут, Ц.Мөнх-Оргил- 23 минут, Н.Оюундарь-10 минут, Б.Саранчимэг- 2 цаг, Д.Сумъяабазар- 56 минут, Ч.Хүрэлбаатар- 1 цаг 10 минут, Д.Цогтбаатар- 1 цаг 50 минут, Б.Чойжилсүрэн- 28 минут, Б.Энх-Амгалан- 28 минут, Ж.Энхбаяр- 2 цаг 25 минут, С.Эрдэнэ- 1 цаг 03 минут.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг**/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, мөн хорооны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Мэдээлэл, судалгаа арга зүйн хэлтсийн дарга Б.Оюумаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ, Мэдээлэл, технологийн төвийн захирал Ж.Эрдэнэбат, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, дэд дарга Д.Дэлгэрсайхан, мөн газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Нармандах, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн Ц.Жавхлант, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал С.Энхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа, мөн газрын Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга Ч.Чинбат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Интернэтэд суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Т.Батболд, хуульч, өмгөөлөгч Ж.Эрхэмбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх А.Солонго, Б.Хатантуул, референт Б.Золбоо нар байлцав.

Хэлэлцэх асуудлын талаар Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.3.Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 16
Бүгд: 52
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Сонгуулийн нутаг дэвсгэр нь тойрогт хуваагдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 16
Бүгд: 52
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар, Д.Эрдэнэбат нарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир дэмжсэн саналд оруулж тооцохыг хэлэв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслөөс 18 дугаар зүйл, 22 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.2, 9 дүгээр зүйлийн 9.3, 11 дүгээр зүйлийн 11.3, 21 дүгээр зүйлийн 21.11, 60 дугаар зүйлийн 60.2, 60.5, 63 дугаар зүйлийн 63.2, 63.4, 66 дугаар зүйлийн 66.16, 66.17, 66.18, 68 дугаар зүйлийн 68.15, 68.16, 68.17, 68.18, 72 дугаар зүйлийн 72.19, 72.20, 72.21, 76 дугаар зүйлийн 76.6, 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.4.3 дахь заалтын “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойргоос сонгогдсон” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсгийн “энэ хуулийн 11.3-т заасан” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.18 дахь хэсгийн “болон төв комиссын дарга” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийн “22” гэснийг, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “энэ хуулийн 11.2-т заасан сонгуулийн тойрогт” гэснийг, 76 дугаар зүйлийн 76.7 дахь хэсгийн “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж” гэснийг, 78 дугаар зүйлийн гарчгийн

“Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудлыг нөхөх,” гэснийг, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 15

Бүгд: 49

69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.4 дэх заалтын “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж” гэснийг “нэр дэвшигчийг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4, 14.5 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад” гэснийг “Сонгуулийн хороодод” гэж, 14 дүгээр зүйлийн 14.18 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага” гэснийг “Сонгуулийн хороод” гэж, 20 дугаар зүйлийн 20.19 дэх хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагын” гэснийг “Сонгуулийн хороодын” гэж, 20 дугаар зүйлийн 20.20 дахь хэсгийн “байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад” гэснийг “сонгуулийн хороонд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 13

Бүгд: 49

73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн доор дурдсан зүйл, хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах:

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсэг:

“14.1.Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн ерөнхий хороо удирдан зохион байгуулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн хороог нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

14.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон хэсгийн хороо нь байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага /цаашид “сонгуулийн хороод” гэх/ бөгөөд хэсгийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд хамаарна.”

Төслийн 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг:

“30.6.Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно.”

Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг:

“31.1.Нам, эвсэл Монгол Улсын Их Хурлын сонгуульд 76-аас илүүгүй хүнийг нэр дэвшүүлнэ.”

Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг:

“32.1.Энэ хуульд заасан шаардлагыг хангасан иргэн бие даан нэр дэвшиж болно.”

Төслийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг:

“67.2.Сонгогч саналын хуудаст бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө.”

Төслийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг:

“73.1.Тойрогт ногдсон мандатын тооноос илүү эсхүл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.”

Төслийн 75 дугаар зүйл:

“75.1.Сонгуулийн ерөнхий хороо нь санал хураалтын дүнг үндэслэн тухайн тойрогт нийт нэр дэвшигчийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана.

75.2.Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

75.3.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу тойрогт хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Монгол Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ.

75.4.Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хуралд, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.”

Төслийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг:

“78.1.Энэ хуулийн 4.3.3-т заасан үндэслэлээр нөхөн сонгууль явагдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	37
Татгалзсан:	13
Бүгд:	50

74.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, С.Бямбацогт нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.“18 нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн, он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;”

3.1.2.“25 нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	36
Татгалзсан:	13
Бүгд:	49

73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “иргэний улсын бүртгэлийн биеийн давхцалгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэлд бүртгүүлж, иргэний бүртгэлийн дугаар авсан 18 нас хүрсэн эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг;” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	37
Татгалзсан:	11
Бүгд:	48

77.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8 дахь заалт нэмэх, хуулийн нэр томъёоны дарааллыг цагаан толгойн дараалалд оруулах:

“3.1.8.“Цахим хуудас” гэж бүх төрлийн контентийг интернетийн домэйн нэр болон цахим орчин дахь олон нийтийн сүлжээг ашиглан хэрэглэгчид хүргэдэг программ хангамжийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	32
Татгалзсан:	16
Бүгд:	48

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.9 дэх заалт нэмэх, хуулийн нэр томъёоны дарааллыг цагаан толгойн дараалалд оруулах:

“3.1.9.“Ял эдэлж байгаа” гэж Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд заасан үндсэн болон нэмэгдэл ялыг эдэлж дуусаагүй, эсхүл торгох ялыг биелүүлээгүй байхыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт

явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 18
Бүгд: 49

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “аймгийн төвд 3000-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 4000-аас” гэснийг “аймгийн төв болон дүүрэгт 3000-аас дээшгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 11
Бүгд: 49

77.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсгийн “талаар” гэсний ард “байр сууриа илэрхийлэх,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 14
Бүгд: 49

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “хороог” гэсний дараа “тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “өмнө” гэсний дараа “тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 15
Бүгд: 49

69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсгийн “бөгөөд” гэсний дараа “нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 19
Бүгд: 49

61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.16 дахь хэсгийн “журмыг” гэснийг, “сонгогч шилжих журам болон маягт, загварыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 14

Бүгд: 48
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийн “энэ хуулийн 23.2-т заасны дагуу цахим хуудаст байрлуулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 12
Бүгд: 46
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 26, 27 дугаар зүйл болгох:

“26 дугаар зүйл.Сонгогч шилжих

26.1.Сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж буй цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шийдвэрлэнэ.

26.2.Нэр дэвшигч болон энэ хуулийн 38.3-т заасан менежер, шадар туслагч сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих бол санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг хийлгэж болно.

26.3.Энэ хуулийн 26.1, 26.2-т заасан сонгогч санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг бүртгүүлнэ.

27 дугаар зүйл.Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох

27.1.Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 2 дугаар сарын 1-ний өдрөөс, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол уг шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн өдрийн дараах ажлын өдрөөс эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох, сэргээх тухай шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.

27.3.Нэмэлт болон дахин санал хураалт явагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ хуулийн 27.1, 27.2-т заасан иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг түр зогсоох хугацааг тухайн нэмэлт болон дахин санал хураалт явагдаж дуустал үргэлжлүүлж, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.

27.4.Ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулахаар товлон зарласан эрх бүхий байгууллага тухайн шийдвэрийг ажлын 3 өдрийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 16
Бүгд: 47
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Д.Дамба-Очир нар үг хэлэв.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийн “дараах” гэсний дараа “асуудлыг олонхиороо шийдвэрлэх” гэснийг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 13
Бүгд: 48
72.9 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Улсын Их Хурлын гишүүн Л.Болдын гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.10.Эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглоно. Эвсэлд нэгдсэн нам эвслээс гарсан хэдий ч 51 хувиас дээш тооны гишүүд тухайн эвсэлд үлдсэн тохиолдолд уг эвсэл хэвээр хадгалагдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 24
Бүгд: 45
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, С.Чинзориг, Ц.Мөнх-Оргил, Л.Болд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.1 дэх заалтын “шүүхийн” гэснийг “шүүх болон арбитрын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 23
Бүгд: 42
45.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.3, 30.4.4 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.2.6, 33.3.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.7.Гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, О.Баасанхүү нарын гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.8 дахь хэсгийг нэмэх:

“30.8.Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, О.Баасанхүү, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “маягтад” гэсний дараа “тухайн сонгуулийн тойргийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.2.9, 33.3.11 дэх заалтын “эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх талаарх Цагдаагийн ерөнхий газрын” гэснийг “ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 19
Бүгд: 47
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Баасанхүү, Ч.Хүрэлбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “600” гэснийг “200” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 16
Бүгд: 47
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 40.2.8 дахь заалт нэмэх:

“40.2.8.Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 40
Бүгд: 46
13.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураах тухай хэлэв.

Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 40.2.8 дахь заалт нэмэх:

“40.2.8.Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 19
Бүгд: 48
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “хоёроос” гэснийг “дөрвөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 16
Бүгд: 48
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.3.Ухуулах хуудас болон зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт үнэ төлбөргүйгээр байрлуулах байршлыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 17
Бүгд: 48
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийг “Энэ хуулийн 42.3-т заасны дагуу тогтоосон байршлаас өөр газарт зурагт самбар болон ухуулах хуудас байршуулахыг хориглоно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 15
Бүгд: 48
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар үг хэлэв.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсгийн “Ухуулах” гэснийг “Нэр дэвшигч нь ухуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 15
Бүгд: 48
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 42.14 дэх хэсэг нэмэх:

“42.14.Энэ хуулийн 40.2.8-д заасан сонин, сэтгүүл нь сүүлийн 12 сарын турш тогтмол гарсан байх бөгөөд түүнд нийтлүүлэх сурталчилгааны төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн үнийн дунджаас хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 14
Бүгд: 48
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.8, 43.9 дэх хэсгийн “самбарыг” гэснийг “самбар, дэлгэцийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 13
Бүгд: 48
72.9 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “ухуулах байр,” гэсний дараа “сонгогчидтой хийх уулзалт, хурал цуглааны танхимд,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 14
Бүгд: 48
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.6 дахь хэсэг нэмэх:

“45.6.Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт, арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 19
Бүгд: 49
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.8.Сурталчилгааны нэвтрүүлгийн төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна. Үүнтэй холбогдуулан төслийн 47 дугаар зүйлийн 47.9.2 дахь заалтын “сүүлийн зургаан сарын” гэснийг “ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 15

Бүгд: 49
69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 25 дахь хэсгийн “47.2, 47.5-47.8, 47.11-47.19-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 17
Бүгд: 49
65.3 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“48.5.Энэ хуулийн 48.1.3-т заасан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 12
Бүгд: 49
75.5 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.7.Энэ хуулийн 36.3, 48.4-т заасныг зөрчсөн талаарх гомдлын дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн дараах арга хэмжээг нэн даруй авна:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 11
Бүгд: 48
77.1 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн 48.8 дахь хэсгийн “Интернетийн” гэсний өмнө “Үүрэн холбооны болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 12
Бүгд: 48
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн 48.9 дэх хэсгийн “хороо” гэснийг “хорооны саналыг үндэслэн Сонгуулийн Ерөнхий хороо” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 14
Бүгд: 48
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 11 дэх хэсэг нэмэх:

“48.11.Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл авч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 16
Бүгд: 48
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “аливаа этгээд” гэсний дараа “өөрөө болон бусдаар дамжуулж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 15
Бүгд: 46
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “гурван сая” гэснийг “таван сая” гэж, “арван таван сая” гэснийг “хорин сая” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 15
Бүгд: 47
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“55.2.Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан энэ хуулийн 55.1-т заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хандив өгч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 14

Бүгд: 47
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 13
Бүгд: 46
71.7 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.1.Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 15
Бүгд: 45
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан 17 цаг 59 минутаас хуралдааныг даргалав.

Л.Энх-Амгалан: 47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 63 дугаар зүйлийн 63.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“63.13.Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байруудад хяналтын камер байрлуулж болно. Хяналтын камерыг сонгогчийн саналаа нууцаар гаргах эрхэд саад учруулахгүйгээр байрлуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 13
Бүгд: 45
71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн нар хариулж, тайлбар хийв.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 64 дүгээр зүйлийн 64.1.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 17
Бүгд: 45
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 67 дугаар зүйлийн 67.9 дэх хэсгийн “Бие эрхтэний согог, хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдал,” гэснийг “Эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 16

Бүгд: 45

64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийн “гурав хүртэл” гэснийг “дөрөв хүртэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 12

Бүгд: 46

73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 69 дүгээр зүйлийн 69.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“69.2.5.сонгогчийн саналаа нууцаар гаргах эрх болон сонгуулийн хорооны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 13

Бүгд: 46

71.7 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсгийн “сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.” гэсний дараа “Мэдээлэл, технологийн багийн гишүүн, даамал нь санал авах, тоолох төхөөрөмжөөс дөрвөн метрээс багагүй зайд байрлаж, төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хянаж ажиллана.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 17

Бүгд: 46

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 72 дугаар зүйлийн 72.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“72.11.Энэ хуулийн 72.5.3-т заасны дагуу саналын хуудсыг дахин тоолоход сонгогчдын саналыг тоолохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 20
Бүгд: 46
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 79 дугаар зүйлийн 79.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“79.3.Энэ хуулийн 9.11-т заасны дагуу дахин сонгууль явуулахад улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээс ээлжит, ээлжит бус, нөхөн сонгуулиар гаргаж хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг ашиглана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 17
Бүгд: 49
65.3 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн дараа доор дурдсан агуулга бүхий хэсэг нэмэх, үүнтэй холбоотойгоор 80.3 дахь хэсгийг “ирцийг” гэснийг “ирц, саналын тоог” гэж, “ирц” гэснийг “ирц, саналын тоо” гэж, 4 дүгээр зүйлийн 4.5.1 дэх хэсгийг “Нэмэлт санал хураалт гэж энэ хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу явагдах санал хураалтыг;” гэж тус тус өөрчлөх:

“Сонгуулийн тойрогт хамаарах сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын тавь буюу түүнээс дээш хувь нь санал хураалтад оролцоогүй бол тавин хувь нь оролцоогүй хэсэг тус бүрт нэмэлт санал хураалт явуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 19
Бүгд: 51
62.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 81 дүгээр зүйлийн 81.5 дахь хэсгийн “81.5.” гэснийг “Тайлбар:” гэж, “их” гэснийг “илүү” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 20

Бүгд: 51
60.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын санал:

Найруулгын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

Л.Энх-Амгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “заасны” гэсний дараа “дагуу” гэж, “хангасан” гэсний дараа “Монгол Улсын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 15
Бүгд: 49
69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурлын /цаашид “Улсын Их Хурлын” гэх/ сонгууль нь” гэснийг “Монгол Улсын Их Хурлын сонгууль нь /цаашид “сонгууль” гэх/” гэж, мөн зүйлийн 4.2 дахь хэсгийн “Улсын Их Хуралд” гэснийг “Монгол Улсын Их Хурал /цаашид Улсын Их Хурал гэх/-д” гэж, мөн зүйлийн “4.4.1, 4.4.2, 4.4.3, 4.4.4” гэснийг “4.5, 4.6, 4.7, 4.8” гэж, мөн заалтуудын “сонгуулийг,” гэснийг “сонгуулийг ойлгоно.” гэж, 21 дүгээр зүйлийн 21.9.2 дахь заалтын “26.6” гэснийг “26.3” гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “24.1” гэснийг “24.2” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “21.1” гэснийг “25.1” гэж, мөн зүйлийн 25.6 дахь хэсгийн “21.5” гэснийг “25.5” гэж, 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн “нь” гэснийг “тус бүр” гэж, 72 дугаар зүйлийн 72.1.2 дахь заалтын “78.5” гэснийг “72.5” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “холбогдох” гэснийг хасах.

4.Төсөлд зүйл, хэсэг, заалт нэмж, хассантай холбогдуулан төслийн дугаар, ишлэлийг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 13
Бүгд: 47
72.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Л.Энх-Амгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 63 дугаар зүйлийн 63.1, 66 дугаар зүйлийн 66.15 дахь хэсгийн “22:00” гэснийг “21:00” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 18
Бүгд: 47

61.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан дээрх саналыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгов.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 21.7 дахь хэсгийг нэмж, дугаар өөрчлөх:

“21.7.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчийн эцэг(эх)-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг бүхий хэсгийг зөвхөн цахим хэлбэрээр нэг удаа олгоно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 20

Бүгд: 50

60.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Б.Пүрэвдорж, Х.Нямбаатар, Н.Энхболд нар үг хэлэв.

3.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн “аль нэг хүйсийнх” гэсний дараа “2-оос доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 25

Бүгд: 49

49.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир дээрх санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

4.Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатарын гаргасан дээрх санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 19

Бүгд: 48

60.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн “аль нэг хүйсийнх” гэсний дараа “2-оос доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн дахин санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 19

Бүгд: 47

59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, М.Билэгт, Ц.Гарамжав, Г.Мөнхцэцэг, Н.Оюундарь, М.Оюунчимэг, Д.Оюунхорол, Б.Саранчимэг, Ц.Цогзолмаа, Б.Ундармаа, Б.Ундраа, Д.Сарангэрэл нарын гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн “20-оос доошгүй” гэснийг “30-аас доошгүй” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 21

Бүгд: 44

52.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, М.Билэгт, Б.Пүрэвдорж, Д.Оюунхорол, Ж.Энхбаяр нар үг хэлэв.

7.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Л.Болд нарын гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн “аль нэг хүйсийнх” гэсний дараа “5-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 16

Бүгд: 45

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан үг хэлэв.

8.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлд 34.10 дахь хэсгийг нэмэх:

“34.10.Эрүүгийн хуульд заасан охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, хүнийг алах, тагнуулын, эх орноосоо урвах, авлига, албан тушаалын эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүнийг нэр дэвшүүлэхийг хориглоно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 22

Бүгд: 45

51.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, О.Баасанхүү нар үг хэлэв.

9.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлд 34.1.10 дахь хэсгийг нэмж, дугаарыг өөрчлөх:

“34.1.10.Бүх шатны сонгуульд оролцоход өөрөө болон тухайн үед

сонгуулийн штабд ажиллаж байсан этгээд нь Сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн талаарх шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч байсан бол.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 37

Бүгд: 44

15.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураах тухай хэлэв.

10.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлд 34.1.10 дахь хэсгийг нэмж, дугаарыг өөрчлөх:

“34.1.10.Бүх шатны сонгуульд оролцоход өөрөө болон тухайн үед сонгуулийн штабд ажиллаж байсан этгээд нь сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн талаарх шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч байсан бол.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 17

Бүгд: 44

61.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

11.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлд 34.10 дахь хэсгийг нэмж, дугаарыг өөрчлөх:

“34.10.Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар яллагдагчаар тогтоогдсон нөхцөл байдал нь Улсын ерөнхий прокурорын зүгээс сонгуульд нэр дэвшихэд саад учруулна гэсэн албан бичиг Сонгуулийн Ерөнхий хороонд ирсэн бол.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 13

Бүгд: 44

70.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсгийн “хийсний дараа” гэсний дараа “баруун долоовор хуруун дээр санал өгсөн гэсэн тэмдэглэгээ хийлгэх” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 12

Бүгд: 44
72.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Энх-Амгалан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “гэж”, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2.1 дэх заалтын “сонгуулийн тухай” гэсний дараа “болон Улсын Их Хурлын сонгуулийн тухай” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 12
Бүгд: 44
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Энх-Амгалан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “8.3.8.Сонгууль” гэснийг “ээлжит бус, дахин, нөхөн сонгууль,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 11
Бүгд: 43
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Энх-Амгалан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 46.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.4.Төрийн жинхэнэ албан хаагч нь Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн, дахин сонгуулийн тухайд энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө төрийн албанаас чөлөөлөгдсөн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 11
Бүгд: 44

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Авлигын эсрэг хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Энх-Амгалан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлээс “11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална.” гэж, мөн зүйлийн” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулга бүхий 3 дугаар зүйл нэмэх:

3 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	16
Бүгд:	44

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Энх-Амгалан: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд “Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “заасан хэмжээгээр” гэсний дараа “шүүх,” гэж нэмэх.” гэсэн агуулга бүхий заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	32
Татгалзсан:	12
Бүгд:	44

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 1, 6, 11 дэх хэсгийн “учруулсан” гэсний дараа, 4 дэх хэсгийн “явуулсан” гэсний дараа, 15, 16 дахь хэсгийн “оруулсан” гэсний дараа, 23 дахь хэсгийн “тараасан” гэсний дараа, 31 дэх хэсгийн “устгасан” гэсний дараа, 47 дахь хэсгийн “хийсэн” гэсний дараа, 74 дэх хэсгийн “хэрэглэсэн” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй” гэж, 30, 31, 32 дахь хэсгийн “бол” гэсний дараа “учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	33
Татгалзсан:	10
Бүгд:	43

76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлд заасан зөрчилд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээг Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон зөрчлийн хуулийн шийтгэлийн бодлогыг зарчмын хүрээнд нийцүүлэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн харьцаанд нийцүүлэн хэмжээг өөрчлөх:

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хоёр зуун” гэснийг “хоёр мянган” гэж, 3, 7, 8, 9, 51, 53, 59, 60, 61, 62, 67 дахь хэсэгт “арван” гэснийг “дөрвөн” гэж, 5, 15 дахь хэсэгт “дөчин” гэснийг “нэг зуун” гэж, 6, 16, 50, 52, 78.3, 79, 80 дахь хэсэгт “дөчин” гэснийг “нэг зуун” гэж, 14 дэх хэсэгт “таван” гэснийг “нэг мянган” гэж, “дөчин” гэснийг “арван” гэж, 18, 27, 28, 31, 32, 33, 36 дахь хэсэгт “хорин” гэснийг “тавин” гэж, 19 дэх хэсгийн “таван” гэснийг “арван” гэж, “хорин” гэснийг “нэг зуун” гэж, 10, 11, 12, 13, 20, 21, 22, 72, 73, 74, 75, 76 дахь хэсгийн “дөчин” гэснийг “тавин” гэж, 23 дахь хэсгийн “хоёр” гэснийг “таван” гэж, “хорин” гэснийг “тавин” гэж, 29, 30, 34, 35 дахь хэсгийн “таван” гэснийг “хоёр” гэж, 37 дахь хэсгийн “хорин” гэснийг “нэг зуун” гэж, 41.7, 43.6, 44, 45, 46, 47 дахь хэсгийн “нэг” гэснийг “хоёр” гэж, 42 дахь хэсгийн “хорин” гэснийг “арван” гэж, 49 дэх хэсгийн “хорин” гэснийг “дөчин” гэж, 64, 69 дэх хэсгийн “арван” гэснийг “таван” гэж, 68 дахь хэсгийн “арван” гэснийг “хоёр” гэж, 71 дэх хэсгийн “тавин” гэснийг “нэг зуун” гэж, 81 дэх хэсгийн “гучин” гэснийг “нэг зуун” гэж, 82 дахь хэсгийн “дөчин” гэснийг “хоёр зуун” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 15

Бүгд: 41

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 43.4 дэх заалтын “энэ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 14

Бүгд: 41

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 38 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.Нэр дэвшигч нь сонгуулийн хуульд заасан цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлээгүй, бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 37
Бүгд: 41
9.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураах тухай хэлэв.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 38 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.Нэр дэвшигч нь сонгуулийн хуульд заасан цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлээгүй, бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 48 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг банканд нээлгэсэн сонгуулийн зардлын дансанд хуульд заасны дагуу төвлөрүүлж, зарцуулах талаар тогтоосон журмыг зөрчсөн хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 49 дэх хэсгийн “цуглуулах” гэснийг “цуглуулсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 39 дэх хэсгийн “нийтэлсэн” гэсний дараа цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн” гэж, 40 дэх хэсгийн “Интернетиин” гэсний өмнө “Үүрэн холбооны болон” гэж, 50 дахь хэсгийн “бол” гэсний дараа “хууль бусаар зарцуулсан хөрөнгө, орлогыг хурааж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 54, 55, 56, 58 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“54.Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан сонгуулийн тухай хуульд заасан хэмжээнээс хэтрүүлсэн хандив өгсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

55.Эвсэлд нэгдсэн намд сонгуульд зориулж хандив өгсөн бол тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгөхийг хориглох бөгөөд зөрчвөл хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж зөрчсөн хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

56.Хандив өгөхийг хориглосон этгээд хандив өгсөн, авсан, хандив өгөхийг хориглосон этгээд болон эрх зүйн байдал нь тодорхойгүй этгээдээс өгсөн хандивыг буцаан шилжүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

58.Мөнгөн бус хандив өгөх талаар хуулиар тогтоосон журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41

68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Энх-Амгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “мөн

зүйлийн 6.6” гэснийг “мөн зүйлийн 6.8” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд “1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт 17.1 дүгээр” гэж, төслийн 2 дугаар зүйлийн 17.1 дүгээр зүйлийн 42 дахь хэсгийг хасаж, төслийн 1 дүгээр зүйлийн “41” гэсний ард “42,” гэснийг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд дараах агуулгатай 3 дугаар зүйлийг нэмэх:

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1.8.9.Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу шүүгч харьяалан шийдвэрлэх Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 8.6, 8.7, 10.5 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.3, 15.4, 15.5, 15.7, 15.12 дугаар зүйлд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаагийн байгууллага, 17.1 дүгээр зүйлд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаа, тагнуул, шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын эрх бүхий албан тушаалтан, улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, татварын улсын байцаагч гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 12
Бүгд: 42
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Энх-Амгалан: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 12
Бүгд: 42
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 19 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа.
/19:52/

Улсын Их Хурал дахь ШИНЭ намын зөвлөлийн гишүүд “Ялгаварлалыг зогсооё” гэсэн үгтэй лоозонг ширээн дээрээ байрлуулсан байв.

Бусад: Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбатын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын малчид, уяачдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхоролын урилгаар “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон эмэгтэйчүүдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга З.Нямцогт, мөн хэлтсийн шинжээч Р.Дэлгэрмаа, М.Номиндулам нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 15 минут үргэлжилж, 75 гишүүнээс 42 гишүүн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр, 19 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ 12 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
2. Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу. За, Аюурсайхан гишүүн.

Т.Аюурсайхан: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Энэ хэлэлцэх асуудал дээр Эрүүгийн хуулийн өөрчлөлтийн асуудал явж байгаа юм байна гэж ойлголоо. Энэ бол хөөн хэлэлцэх хугацааны нугалааг засаж залруулах асуудал явж байгаа байх аа гэж бодож байна. Тэгэхдээ энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад асуух асуулт байна.

Хөөн хэлэлцэх хугацаа дээр үнэхээр Эрүүгийн хуульд маш тодорхой нугалаа үүсгэсэн, маш олон хүмүүс ял завшиж байна. Сар гаруйн өмнө гэхэд л 400 гаруй хүн байсан, өнөөдөр хэд болчихсон юм. Тэгээд энэ томоохон хэргүүд нийгмийн анхааралд байсан энэ эдийн засгийн хүндрүүлэх, төр нийгэмд шударга бус нөхцөл байдлыг дэвэргэх дээр маш их нөхцөл байдал үүсгэсэн хэргүүд байна.

Энэ ЖАСТ-ын Батхүүгийн хэрэг нь хэрэгсэхгүй болж байна гэдэг мэдээллийг бид авч байна. Хөгжлийн банк, бондуудын зарцуулалттай холбогдуулж улсад хохирол учруулсан гэх Гарамгайбаатар, Нямжавын Батбаяр гээд нөхрүүд чинь хөөн хэлэлцэх хугацаагаар шүүхээс ялаас мултарч байна.

Дорлигжав дарамталж 4 сая доллар авсан асуудал, Дэнзэн 17 тэрбум төгрөгөөр улсыг хохироосон гэдэг асуудал бүгдээрээ ялаас чөлөөлөгдөж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр шүүхээс бол тэр хүмүүсийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг тооцчихож байгаа юм. Тооцож гэдгээ тэмдэглээд гэхдээ энэ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 72 дугаар зүйлийн 72.1.2-т заасныг журамлан холбогдох хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул эрүүгийн хариуцлагаас чөлөөлж

шийдвэрлэсүгэй гээд тогтоосон гэхдээ хариуцлагаас нь чөлөөлөөд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ Эрүүгийн хуулийн өөрчлөлт, хөөн хэлэлцэх хугацаагаа засахдаа хөөн хэлэлцэх хугацаагаар ял завшсан хүмүүсийг эргэж яаж хэргийг нь сэргээх асуудал үүсэх юм бэ. Энэ дээр ярьж байгаа, хэлж байгаа, төлөвлөж байгаа зүйл байна уу.

2 дугаарт мөнгө угаах гэмт хэрэгтэй холбогдуулан ФАТФ-ын саарал жагсаалтад орсон. Үүнийг хэлэлцэх асуудалд орж байна уу. Энэ ямар сүлжээ явж байна вэ. Яаж хариуцлага тооцож байна вэ. Монгол банк, Санхүүгийн зохицуулах хорооны дарга нарт хариуцлага тооцсон, дараагийн томилгоонууд нь яаж явж байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Төрийн банк, Хөгжлийн банк, Монгол банк үүнийг тойрсон, хөрөнгийн биржийг тойрсон энэ сүлжээ байна уу. Энд яаж салхи оруулах вэ, яаж цэгцлэх вэ, үүнийг хэзээ ярих вэ.

Г.Занданшатар: Хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал хэлэхэд дэгээрээ зөвхөн хэлэлцэх асуудлын дарааллын талаар хасах, нэмэх асуудлаар л санал хэлдэг дэгтэй. Доторх байгаа агуулгын асуудлыг тухайн хууль дээрээ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөлтэй хамт ярина.

Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би маш товчхон юм хэлье. Сонгуулийн хууль бол ингээд батлагдах хуультай, номтой, цагтай, хугацаатай учраас ингээд батлагдах нь дамжиггүй. Энд нэлээн олон зарчмын зөрүүтэй саналууд хураагдах юм байна. 70 гаран санал хураагдах юм байна. Тэгэхээр одоо 3 өнгөрсөн, 4 болж байгаад хурал эхэлж байгаа учраас энэ хэлэлцэх асуудлынхаа дарааллыг нь өөрчлөөд тэр Эрүүгийн хуультай холбоотой юмыг нь 1 дээр нь хэлэлцүүлээд энэ асуудлаа нэг талд нь гаргахгүй бол сая Аюурсайхан гишүүн хэлээд байгаа бол маш зөв асуудлыг тавиад байгаа байхгүй юу.

Энэ үнэхээр одоо хөөн хэлэлцэх хугацааг будилуулсантай холбоотой, маш олон авлига, албан тушаал, энэ төсвийн, зээл бондын хөрөнгийг зувчуулсан улсууд цагаадаад гарчихсан, гадна дотно өчнөөн байшин шилтгээн оффшороор өчнөөн тэрбум, их наядаар нь хөрөнгө мөнгө зувчуулсан улсуудыг сугараад гарчхаад байна шүү дээ.

Ард иргэд бол асар их бухимдалтай байна. Би бас хөдөө орон нутагт, тойргийн сумуудаар явлаа. Энэ оффшортой холбоотой хөрөнгө мөнгийг оруулж ирнэ гэсэн яасан, энэ улсын хөрөнгө мөнгийг хулгайлсан энэ хүмүүсийн асуудлыг шийднэ гэсэн яасан, энэ хөөн хэлэлцэх хугацаагаар бүгдийг нь тавиад суллаад явуулчихлаа гэдэг асуудлыг их тавьж байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ асуудлыг яаралтай авч үзэх хэрэгтэй. Энэ авлигатай холбоотой, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн энэ улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой үндэслэлгүйгээр төрийн эрх байгууллагууд хууль бодлого гаргуулж, өөрийнхөө компани, пүүсийг хөрөнгөжүүлсэнтэй холбоотой энэ асуудлыг нэг талд нь гарга аа. Та нар яагаад энгийн асуудлыг шийддэггүй юм бэ.

Энэ хэрэглээн дээр нь л хяналтыг тавиач ээ. Наад авлигатай холбоотой асуудал чинь тэгээд бүх юм нь тодорхой болно шүү дээ гэдэг ийм асуудлыг тавиад байгаа байхгүй юу.

Нөгөө талд нь зүй ёсны шаардлага тавьж байна. Яагаад бид нар шинэ Монгол Улсыг байгуулсан хэдэн ахмадууд байна. Нийтдээ 300 гаруй мянган ахмадууд байна. Тэр хүмүүсийн зээлсэн зээлийнх нь нөгөө тэтгэврээр нь арилжааны банкууд ашиг олох гээд зээлийн нэг бүтээгдэхүүн болоод зээл тавиад өгчихсөн. Тэр зээлийн барьцаанд орсон нийтдээ 250 орчим тэрбум төгрөгийн зээл тавьсан энэ зээлийн асуудлыг төр тэглэж өгөөч ээ. Та нар нэг том авлигачны хөрөнгөтэй холбоотой асуудлыг тэр оффшорт нуусан байдаг юм уу, гадаадын байшин хаусыг нь байдаг юм уу, тэр зувчуулсан хөрөнгө мөнгийг нь оруулаад ир гэхэд л одоо энэ асуудлыг шийдэхээр байна шүү дээ гэж ийм зүй ёсны, зарчмын зөв шаардлага гэж үзэж байгаа юм.

Ийм асуудлууд тавиад байна аа. Тийм учраас Эрүүгийн хуультай холбоотой, хөөн хэлэлцэхтэй холбоотой асуудлаа нэг талд нь гаргаад өнөөдрийн үдээс хойших хурлыг энэ рүү бүхэлд нь чиглүүлээд ингээд хэлэлцвэл яасан юм бэ гэсэн ийм санал байна аа, надад.

Г.Занданшатар: Хэлэлцэх асуудалтай холбогдуулан гишүүд санал хэлж, танилцуулж дууслаа. Хэлэлцэх асуудалдаа орно.

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их хурлын гишүүн, Улсын Их хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна. Тогтохсүрэн даргыг индэрт урьж байна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ. Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүнээс 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн нэгдсэн чуулганаараа хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 244 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэнгээр ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Баасанхүү, Болд, Мөнх-Оргил, Нямбаатар, Оюунхорол, Содбаатар, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын бүрэлдэхүүнтэйгээр чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээлэл хангах чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулан нийт 3 удаа хуралдаж, Байнгын хорооны хуралдаанд оруулахаар Байнгын хорооны хуралдаанд оруулсан томьёоллыг бэлтгэсэн болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны анхны хэлэлцүүлэг хийх үед Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгож, сонгуулийн нутаг дэвсгэр нь тойрогт хуваагдах, иргэний шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зогсоох, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээх, сонгуулийн сурталчилгаанд сонин, сэтгүүл, радио, телевиз, цахим орчин ашиглахдаа төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааг баримталсан зар сурталчилгааны тухай хууль зөрчсөн, баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байх, сонгуулийн тухай хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлж, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг саналуудыг дэмжсэн болно.

Мөн ажлын хэсэгт Улсын Их Хуралд суудалтай болон Улсын Их Хуралд суудалгүй намуудаас ирүүлсэн саналуудыг Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжсэн саналуудыг хуулийн төсөлд тусгахыг дэмжлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү бүх шатны сонгуульд оролцохдоо өөртөө болон тухайн үед сонгуулийн штабт ажиллаж байсан этгээд нь сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн талаарх шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч байсан бол мөн 2-оос доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна гэсэн зарчмын зөрүүтэй саналуудыг гаргасан боловч гишүүдийн олонхын дэмжлэг аваагүй бөгөөд дээрх 2 асуултаар цөөнх болохоо илэрхийлсэн.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Оюун-Эрдэнэ төрт ёс зүйтэй хүмүүс ажилладаг байх, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж сонгогчдын нэрсийн жагсаалтыг нам, эвсэлд өгөх асуудал болон хуруун дээр тэмдэглэгээ хийх талаар анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Батзандан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуульд нэр дэвших квотын талаар хуулийн төсөлд оруулах, тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг нэр дэвшүүлэхгүй байх, Бямбацогт сонгуулийн хуулийн төслөөр удаа дараа хэлэлцүүлэг хийсэн, мөн холбогдох байгууллагуудтай уулзаж, сонгуулийг аливаа зөрчилгүй, хуулийн дагуу зохион байгуулахад анхаарах асуудлын талаар албан бичгээр тодорхой санал авч ажлын хэсэгт хүргүүлэхэд анхаарч ажилласан. Цаашид аливаа улс төрчдөөс олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлан сонгуулийн талаар олныг төөрөгдүүлсэн худал мэдээ, мэдээлэл хийхгүй байх талаар байр сууриа илэрхийлсэн болно.

Тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: За ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны

Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн захирал Ж.Эрдэнэбат, Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Нармандах, УБЕГ-ын мэргэжилтэн Дэлгэрмөрөн, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа Л.Нямдаваа, ЦЕГ-ын Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа Ч.Чинбат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга А.Лувсан-Очир, Харилцаа холбооны зохицуулах хорооны Интернэтэд суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Т.Батболд, хуульч, өмгөөлөгч Ж.Эрхэмбаатар.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их хурлын гишүүн байна уу.

Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Нэр тасаллаа. Янгүгийн Содбаатар гишүүн асуулт асууна. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асууна.

Я.Содбаатар: Энэ хуулийн төслийг ерөнхийд нь зарчмын хувьд дэмжиж байна. Энэ хэлэлцүүлгийн үеэр энэ бол сонгуулийн хууль бол бид нар гаргахдаа нэг юмыг гол бодох ёстой. Энэ бол иргэдийн сонгох, сонгогдох үндсэн эрхийг хангах. Энэ хуульд орж байгаа залаат болгон иргэдийн сонгох, сонгогдох эрхэд ямар нэгэн зөрчил үүсгэхгүй байх ёстой. Иргэдийн өгч байгаа санал бас бодитойгоор тусдаг, санал гээгддэггүй байх зарчимтай байх ёстой. Нөгөө талдаа иргэдийн сонгох сонгогдох эрхэд хөндлөнгийн нөлөөлөл байгаа байх ёстой. Мөнгөний нөлөөлөл, манай гишүүд яриад байдаг, мөнгөний сонгууль болчихлоо гээд манай иргэд шүүмжлээд байдаг.

Хууль хүч, эрх мэдэлтнүүдийн нөлөөлөл, хэвлэл мэдээллийн хөндлөнгөөс сошиал нийгмийн сүлжээний нөлөөлөл гээд эд нарыг аль болох багасгах чиглэлд анхаарах ёстой гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлээр ямар заалтууд оров оо. Мөнгөний нөлөөллийг багасгах чиглэлээр ямар заалтууд оров оо гэж, нэгд.

Хоёрт, сонгууль явагдаад дуусдаг аа. Энэ 30 жилийн хугацаанд Монголчууд бид нар муу сайн хэлүүлж байгаад ч гэсэн ардчиллыг тогтоож, энэ хүрээндээ ямар ч байсан төр засгийн эрхийг сонгуулиар хуулийн хүрээнд шилжүүлдэг. Тэгэхээр сонгуулийн хуулийн 1 чухал зүйл бол иргэдийн санал өгсөн, сонгогчдын саналаар гарч ирж байгаа парламентаа хүлээн зөвшөөрч төр засгийг хэрүүл уруулгүй, цаг алдахгүй байгуулах асуудал байдаг. Тийм учраас түүний нэг гол юм нь бол энэ гишүүдийн эрхийг сонгогдсон тухай тэр нэр дэвшигчийн эрхийг баталгаажуулах асуудал байдаг. Хэдэн жил сар дамжаад хууль хүчний байгууллагаар явчихдаг. Үүнийг хэр хааж өгсөн бэ. Өмнөх сонгуулиар бол 2012-2016 оны сонгуулиар манай Өвөрхангайд тухайлбал 2 гишүүний эрх сүүлдээ ард түмний сонгосон эрхээр гарч ирчхээд баталгаажиж чадахгүй байсаар байгаад дууссан шүү дээ. Тэгэхээр энэ хууль хүчний байгууллагуудаар яваад шүүх цагдаагаар явдаг. Эргээд нөгөө иргэдийн өгсөн санал 1 шүүгчийн ширээн дээр байхгүй болдог. Энэ асуудал хэр орсон бэ.

Явж байгаа хуулийн хэлэлцүүлгийг харахаар дандаа өөрсдийнхөө талаас улс төрч нар яриад байна аа. Эсвэл намынхаа талаас яриад байна аа. Энэ бол намын хууль биш ээ, энэ бол улс төрчдийн хууль биш. Энэ бол сонгогчдын хууль

аа. Тийм учраас сонгуулийн хуулийг хийхдээ энэ талд нь илүү түлхүү анхаарч ажилласан байх аа гэдгийг дахиж хэлье, баярлалаа.

Г.Занданшатар: Тогтохсүрэн дарга асуултад хариулна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Бид үндсэндээ сүүлийн 30 жил сонгууль хийж байгаа ийм хүмүүс. Ерөнхийдөө иргэд ч тэр, нэр дэвшигч ч тэр ер нь сонгуулийн талаар мэдлэг мэдээлэл их сайтай болсон.

Энэ сая Содбаатар гишүүний асууж байгаа асуултад бол нөлөөллийн тухай асуугаад байна. Мөнгөний нөлөөлөл, хэвлэл мэдээллийн нөлөөлөл болон бусад нөлөөллийг. Тэгээд Их Хурлын гишүүд ажлын хэсгийнхэн ярилцаж байгаад энэ нөлөөллийг багасгахад л бид нар гол нь анхаарч байгаа юм. Энэ нөлөөллийг багасгах зорилгоор олон мандат бүхий мажоритар том тойргийг санал болгож байгаа юм аа. Энэ бол аль болохоор энэ нөлөөллүүдийг багасгах чиглэлээр орж байгаа хамгийн том өөрчлөлт өө гэж ингэж бодож байгаа юм. Аймаг, дүүрэг болбол тойрог байна гэдэг бол нөлөөллийн хувьд эрс багасна гэж үзэж байгаа юм.

Хоёр дугаарт нь сонгуулийн хуулийг өргөн барьсан, хууль санаачлагч ч гэсэн хуулийн хариуцлагуудыг их тодорхой болгож чангатгаж өгсөн. Сонгуулийн хуулийн зүйл заалт бүр Зөрчлийн хуулийн хариуцлагатай байгаа. Энэ хариуцлагуудыг нэлээн тодорхой болгоод өгчихсөн байгаа. Тийм учраас би хариуцлагыг чангатгаж өгсөн гэж бодож байгаа юм.

Г.Занданшатар: Анхдугаар хэлэлцүүлэг дээр хууль санаачлагч асуултад хариулахгүй ээ. Байнгын хороо л хариулна. Хэлэлцэх эсэх дээр хууль санаачлагчийн эрх. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууна. Одоо хариулбал Бямбацогт дарга өргөн барьсан хуулиас асуухгүй. Одоо бол анхдугаар хэлэлцүүлэг.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ сонгуулийн хуулийг хуулийн хугацаанд нь Их Хурал хэлэлцэх гээд сууцгааж байна л даа. Тэгээд энэ оруулж ирж байгаа энэ сонгуулиар ч бид нар, юу сонгуулийн хуулиар чинь бид нар 2008 онд ижил төстэй ийм хувилбараар сонгуулийг явуулсан байх. Ямар ч байсан алдаа оноо гэдэг юм уу, энд гарсан юмнуудаа хэлэлцүүлгийн явцад та бүхэн маань нэлээн нягталж үзсэн үү. Олон асуудлууд энэ дээр чинь гарсан шүү дээ. Тухайлахын бол 1 тодорхой асуудал бол тойрогт ногдсон мандатын тоотой ижил санал дугуйлах юм уу, эсвэл дутуу дугуйлах юм уу. Манай Хэнтий аймагт ийм зүйл гараагүй. Өөр бусад аймгуудад өөр тойргуудад зөндөө олон асуудлууд гарсан гэж байгаа шүү дээ. Зөвхөн ганцхан намайг дугуйлаарай гээд л бусдыг нь бүгдийг нь орхичихно. 1 хүн дугуйлуулаад яваад байдаг. Эсхүл ерөөсөө нэг намаас нэр дэвшээд зөвхөн намайг дугуйл, нөгөө талаас нь тэр бие даагч, бусад жижиг намын хүмүүсийг дугуйл аа гээд. Ийм мэтийн юмнууд зөндөө явдаг байсан. Тэгээд энэ нь цаашаа юунд хүрсэн гэхээр 2008 оны оны сонгуулийн дараа 7 сарын 1-ний үйл явдал гэж эмгэнэлтэй үйл явдал болсон шүү дээ.

Тийм учраас энэ сонгуулийнхаа хууль, яагаад гэвэл яг энэ хувилбараар явуулсан сонгууль дараа нь гарсан муу үр дагаврыг би хэлээд байгаа учраас энэ бүхнийг та бүхэн маань тооцож үзсэн үү гэж.

2 дугаарт улс төрийн намууд, сонгуулийг мөнгөн дээр тулгуурладаг. Энд чинь булиа булиа пүүс компанийн эзэд, их мөнгөтэй улсууд байж байх юм. Тэгээд энэ чинь цаашаа муу үр дагавартай байна. Энэ улс төрийн нам төлөвшихгүй, Монголын төр төлөвшихгүй байгаа шалтгаан бол энэ мөнгөнд толгойгоо мэдүүлсэнтэй холбоотой байна шүү дээ. Бид парламентын чиглэлээр Европын холбооны улс, ХБНГУ-ын Бундестагт бид ажиллаж байсан. Тэндхийн парламентын гишүүд бол бид нараас асуугаад, та нар ер нь сонгуулиар 1 тойрогт хэчнээн хэмжээний нэр дэвшсэн хүн хэдий хэмжээний хөрөнгө мөнгө зардаг юм бэ гэж. Тэгээд бид бол 60 орчим мянган доллар зардаг юм гэхэд ямар их мөнгө зардаг юм бэ, тийм их мөнгө зарах ямар шаардлага байгаа юм бэ гэж хэлж байсан байхгүй юу. Тэгэхээр чинь нэг сонин ойлголт байгаа биз. Бид нар арай буруу замаар будаа тээгээд яваад байгаа юм байна лээ шүү. Энэ мөнгөтэй холбоотой. Ийм асуудлууд. Тэрийг нь одоо зохицуулсан хаасан ийм зүйлүүд байна уу үгүй юу гэж.

3 дугаарт нэг асуух гээд байгаа юм бол бид нар нийгмийн социал энэ ертөнц юманд их эмзэг хандах юм аа. Улс төрчид хүмүүс бол. Тэгээд мэр сэр санаа цухалзаад байсан. Энэ сонгуулийн үеэр, ер нь сонгуулийн хуулиараа бол энэ социалыг нэлээн хязгаарлаж өгнө өө хаана аа гэсэн. Ийм балай юм эгээ энэ хууль дотор ороогүй юм байгаа биз дээ. Ингэж болохгүй шүү. Тэр чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлдэг, орчин үеийн чиг хандлага, дэлхийн нийтийн амьдрал болчихоод байгаа ийм юмыг нэг сонгууль явуулах энэ хүрээндээ сонгуулийн хуулиар хязгаарлана гэх юм бол энэ төвөгтэй асуудал болно оо гэж.

За 3 дугаарт бол энэ Улсын Их хуралд нэр дэвшиж байгаа, сонгуульд оролцож байгаа хүмүүсийнхээ хандлага, ёс зүйтэй холбоотой юмыг яаж авч үзэж байгаа юм бэ. Би сая тодорхой хэлсэн шүү дээ. Энэ хөрөнгөжсөн, авлигатай холбоотой элдвийн хүмүүсийн асуудлыг ерөөсөө хэрэглээн дээр нь л очоод хяналтыг нь тавьчихаач ээ. Тэгээд тодорхой гараад ирнэ шүү дээ. Яагаад хэчнээн тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байранд сууж байна

Г.Занданшатар: Тогтохсүрэн дарга асуултад хариулна.

Д.Тогтохсүрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ олон мандат бүхий томсгосон тойрогтоо мажоритар системээр 1992 он, 2008 он, 2012 онуудад явуулсан юм байна лээ. 2012 он холимог байсан ч гэсэн 48 суудал буюу мажоритар нь олон мандаттай том тойргоор явсан. Ажлын хэсэг дээр ярилцаж байгаад саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигч нарт мандатын тоотой тэнцүү нэр дэвшигчид санал өгнө. Мандатын тооноос илүү юм уу дутуу санал өгөх юм бол саналын хуудас хүчингүй болно гэж тогтож оруулж ирж байгаа.

2008 онд явуулсан энэ системийг авахаар хүмүүс яриад байгаа юм. 7 сарын 1-ний үйл явдал гээд яриад байгаа юм. Би бол 7 дугаар сарын 1-ний үйл явдлыг бол сонгуулийнхаа системтэй холбоогүй байсан, холбоотой асуудал байгаагүй гэж ингэж боддог юм. 7 сарын 1-ний үйл явдал бол үндсэндээ 2 зүйлтэй холбоотой юм бана лээ.

1 дүгээрт нь сонгуулийн дүн удаан тоологдсон. Янз бүрийн зөрчлүүд их гарсан. Үүнтэй л холоотой асуудал байгаа юм. Тийм учраас одоо бол сонгуулийн автоматжуулсан системээр санал тоолох ажил хар машинаар тоолж байгаа. Сүүлийн 2012, 2013, 2016, 2017 оны сонгуулиуд хар машинаар тоолсон. Хяналтын тооллогоор ямар нэгэн зөрүүтэй зүйл байхгүй байгаад байгаа юм.

2 дахь нь бол хууль зөрчсөн үйлдлүүд. Үйлдэл тус бүр дээр нь хариуцлагыг зааж өгсөн байгаа.

Мөнгөний нөлөөллийг багасгах зорилгоор, мөнгөний нөлөөллийг багасгах зорилгоор л энэ том тойргийг аймаг дүүргийн том тойргийг л сонгож аваад байгаа юм.

Сошиалтай холбоотой асуудал дээр сошиалыг огт хаагаагүй. Зөвхөн сошиал дээр сурталчилгаа хийж байгаа хүн хаягаараа л орох ёстой гэдэг шаардлагыг тавьж байгаа. Өөрөөр хэлбэл буух эзэнтэй буцах хаягтай байна аа л гэсэн үг.

Өөр ямар нэгэн хязгаарлалт тавиагүй байж байгаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбатын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын малчид, уяачдын төлөөлөл Улсын Их хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Уяачдадаа эрүүл энх, аз жаргал, сайн сайхан, хурд хүч сайн сайхан бүхний хүсэн ерөөе.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 1 минут тодруулж асууна.

Б.Бат-Эрдэнэ: Цаг багтаагүй учраас би 1 зүйл нэмж асууя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн квоттой холбоотой. Баасанхүү гишүүн бол 2 хувь гээд санал оруулаад тэр нь дэмжигдээгүй юм байна. Энэ мэргэжлийн холбоодын зүгээс хүмүүсийн хандаад байгаагаар бол 5 хувиар квотыг тогтоож өгөөч ээ гэсэн ийм санал өгөөд байгаа юм, энэ хаана байна вэ гэж.

2 дугаарт бол эмэгтэйчүүдийн квоттой холбоотой ерөөсөө энэ утсанд багтахгүй мессеж ирсэн байж байгаа. Та бүхнийхэд ч бас мессеж ирсэн байх. Энэ эмэгтэйчүүдийнхээ квотыг. Би бодохдоо үнэхээр ёс зүйтэй, шударга ийм мэдлэг чадвартай, ийм эмэгтэйчүүд бол юун 30 байтугай одоо 60, 70 хувь сууцгааж байхад болохгүй юм байхгүй гэж ингэж бодож байгаа хүн. За нэг.

Хоёр дугаарт цаг нь багтахгүй юм даа. Дараа асууя даа. Ёс зүйтэй холбоотой юмыг тодруулах

Г.Занданшатар: Тогтохсүрэн дарга асуултад хариулна.

Д.Тогтохсүрэн: Сонгуулийн хуульд л баахан квотууд тавиулдаг хэлбэр рүү л явах гээд байгаа юм л даа. Одоо орж ирсэн хуулийн төслөөр аль нэг хүйсийн төлөөлөл нь 20-оос доошгүй хувь байна гэсэн ийм хуулийн заалт орж ирсэн. Энэ заавал эмэгтэй ч гэсэн юм байхгүй. Аль нэг төлөөлөл. Аль нэг хүйс нь.

1995 онд батлагдаж 1996 онд сонгууль явуулсан хууль дээр, одоо бидний мөрдөж байгаа сонгуулийн хууль дээр энэ хувь 20 хувь л байгаа. Тийм учраас ажлын хэсэг энэ хувийг хөндөөгүй. Өмнө нь явж байгаа хуулийнхаа дагуу л энэ асуудал явж байгаа. Түүнийг бууруулсан зүйл огт байхгүй. Хувь хэмжээг. Дээшээ гэвэл хэд ч байж болно. Манай сумдад бол зарим нь 50 хувь, 60 хувь байгаа шүү дээ. Тэр нь нээлттэй байгаа.

Г.Занданшатар: Лувсанвандангийн Болд гишүүн асуулт асууна. Байнгын хорооноос.

Л.Болд: Баярлалаа. Тэгэхээр одоо бид Их Хурлын сонгуулийн хууль гэдэг бол үнэхээр Монголын хувь заяаг шийддэг хууль болчихоод байгаа юм л даа. Уул нь анхнаасаа нэг зөв хууль хийчхээд л түүнийгээ бараг мартчихдаг. Сонгуулийн үеэр л нэг санаж гаргаж ирээд л сонгуулиа зохион байгуулдаг бол одоо уул нь хамгийн зөв. Бүх ардчилсан оронд тийм л байдаг. Манайх болохоор хууль болгоныг сонгууль болгоноор өөрчилж, тухайн үед эрх баригчид өөр өөртөө зориулсан хууль гаргаж, тэр нь хэзээ ч амжилтад хүрч байгаагүй, ийм л бодит түүх байгаа юм.

Энэ удаагийн хуулийн нэг онцлог, ард иргэд, түүх давтагддаг гэж ярьдаг. Түүнтэй адилхан бид 2008 оны сонгуулийн хуулийг олон жилийн дараа яг тэр чигээрээ дахиж орж ирж байгаа юм. Энэ хууль ингээд батлагдаад хэрэгжихэд үнэхээр бид сургамжаасаа сургамж хичээл заалгаж түүнийгээ засах арга хэмжээ авахгүй бол ямар ноцтой зүйлээр ямар ноцтой үнэ цэнэ төлдөг юм бэ. Түүнээс биш Монгол Улс хөгжил нь олон арван жилээр хойш хаягдаж ямар айхтар хор хохирлыг ард түмэндээ авчирдаг юм бэ гэдгийг бол 2008 оны сонгууль бэлхнээ харуулж байгаа.

Тийм учраас нэг талаасаа үнэхээр Монголчууд бид асуудлаа засаж сайжруулж чадсан гэдгээ үзүүлэхийн тулд өнөөдөр энэ хууль магадгүй дахиж нэг хэрэгжүүлэхдээ зөв байж магадгүй. Гэтэл алдаагаа засахгүй болохоор бүх асуудал буцаад 2008 он шигээ болох юм бол дахиад тийм үр дүн 7 сарын 1-тэй дуусах юм бол байж болохгүй болчихоод байгаа юм л даа.

Тогтохсүрэн дарга бол тэр 2008 оны гол оношийг их зөв тогтоогоод байгаа юм. Үнэхээр тэр тогтолцоондоо бол биш байсан юм аа. Тэр бол магадгүй гол асуудал нь байгаагүй байх. Үнэхээр сонгуулийн дүнд хэн ч итгээгүй. Хүмүүсийн сонголт луйвардагдсан. Энэ бүхэн одоо бол түүнээс хойш хар машиныг орууллаа. Ингээд сайхан болж байна гээд байдаг. Гэтэл сүүлийн ялангуяа 2 сонгууль дээр энэ хар машин гэдэг чинь өөрөө бол маш асуудалтай гэдгийг бүгд харж байгаа шүү дээ. Энэ чинь ажлын хэсэг дээр бүх 20 хэдэн намууд нийлээд, яршиг бүх хар машинаа 100 хяналтын тооллого хийчхээсэй гэхэд 50-аас дээшээ гаргахгүй л гээд зүтгээд байгаа байхгүй юу.

Үнэхээр 10 хувьд нь байна уу, 50 хувьд нь байна уу, 100 хувьд нь байна уу тэр чинь адилхан цаг орох байхгүй юу. Бүх хэсгүүд дээр хийгдэх учраас. Заавал тал хэсэг дээр тэр сонгуулийн дүнг арай хурцална гэж байхгүй л дээ. Энэ талаар нэг тодруулаад өгөөч. Яагаад 100 хувь хяналтын тооллого хийчхэж болдоггүй юм бэ. Бүх машин нь хийхгүй л бол хийгдээгүй машин дээр л хүн итгэхгүй асуудал үүснэ шүү дээ. Энэ талаар тайлбар авмаар байх юм.

Г.Занданшатар: Тогтохсүрэн дарга асуултад хариулна. Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Болд гишүүн бас сонгуулийн хар машинтай холбоотой асуудлыг хөндөж байна. Тэгэхээр 2008 оны сонгуулиар саналын хуудсыг гараар тоолдог байсан. Гараар тоолохдоо Болд гэсэн нэрийг Батболд гээд уншаад юм уу асуудлууд гарсан гэж эргэлздэг, ярьдаг. Сонгогчид маань бас саналаа өгөхдөө 2, 3 давхар саналаа өгөх бололцоо боломж байсан гэдэг асуудал яригддаг. Үүнтэй

холбоотой асуудлыг үндсэндээ 2012 оны сонгуулиар шийдсэн. Одоо сонгогч бол бие нь өгөгдөл хурууны хээ ашиглаж, саналаа өгдөг иргэний ухаалаг үнэмлэхтэй болсон. Хэзээ ч хаана ч сонгуулийг 1 иргэн 2 дахин саналаа өгөх бололцоо боломжгүй болсон.

2 дугаарт нь сонгуулийн хар машин ашигласнаараа саналын хуудсыг үнэн зөв тоолдог болсон. Үнэн зөв тоолдог болсон. Өөрөөр хэлэх юм бол хэн нэгэн хүнд юм уу сонгуулийн хуудсыг засварлах, дүнг уруу тоолох ийм боломжгүй болсон. Үүний баталгаа нь бид 2012 оны сонгуульд Та сонгогдсон, 2013 оны Ерөнхийлөгчийн сонгууль, 2012 оны орон нутгийн сонгууль, 2016 оны Улсын Их Хурлын сонгууль, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль, 2016 оны орон нутгийн сонгууль энэ бүгдээр харагдсан.

Та одоо яг энэ хар машинаар 2 удаа сонгогдоод ороод ирсэн байж байгаа. Энэ баталгаа нь байх гэж бодож байна. Та сонгуульд ямар нэгэн будилаан луйвар гаргаагүй байх. Тийм. Нэг дүгээрт. Тийм болохоор сонгуулийн хар машинд эргэлзэх шаардлага байхгүй байх.

2 дугаарт нь мэдээж эргэлзээ байж магадгүй гээд бид нар 50 хүртэл хувьд нь тийм үү, гараар тоолох хяналтын тооллого хийнэ ээ гэж одоо 2012 оны сонгуулиас хойш байнга тоолж байгаа. Энэ тоолж байгаа тохиолдол бүрийд ямар нэгэн маргаан асуудал үүсэж байгаагүй. Үүсэж байгаагүй. Тэгээд тооллогыг би нар санал хураалт дууссаны дараа санамсаргүй аргаар буюу сугалаагаар сугалж тооллогын дүн гарсан машинууд дээрээ аль машиныг тоолох уу гэдэг санамсаргүй арга сугалж байгаад ажиглагч нар намуудын төлөөлөл оролцоод сонгож тоолж байгаа. Тийм болохоор дүнг гарсных нь дараа тэр хайрцгийг задлаад тоолоход дүн хэрвээ асуудалтай бол өөр л гарна.

Яагаад гэвэл урьдчилаад тэрийг тоолно гэдэг товлосон тохирсон юм байхгүй учраас санал хураалтын дүн хар машин гаргасных нь дараа алийг тоолох вэ гэдгээ хэсгийн хороодоо сугалж тоолж байгаа. Иймэрхүү зохицуулалтууд орсон учраас ийм одоо юу гэдгийн сонгуулийн хар машинтай холбоотой будилаан маргаан гарахгүй байх аа. Олон удаагийн сонгуулиас гараагүй учраас цаашдаа гарахгүй байх аа. Энд эргэлзэх шаардлагагүй ээ.

Харин 100 хувь гараар тоолно гэххээд хар машины дүнг 100 хувь гараар тоолохдоо будилаантуулаад эндээс хар машин худлаа тоолдог юм байна гээд эргээд сонгуулийг будилаантуулах элдэв үймээн самуун гаргах ийм эх үндэс болчих вий. Тийм учраас урд 5, 6 сонгууль ингээд тоолоод ирлээ, асуудалгүй байгаа учраас үүгээр явах нь зөв өө гэж хуулийн төслийг хууль санаачлагчид өргөн барьсан. Ажлын хэсэг энэ дээр бас ийм байдлаар ярилцаад шийдээд явж байгаа гэдгийг хэлье ээ.

Г.Занданшатар: Зочид танилцуулна. Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хорооны дарга Дуламсүрэнгийн Оюунхоролын урилгаар “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон эмэгтэйчүүдийн төлөөлөл Улсын Их хурлын чуулганы үйл ажиллагаа, Улсын Их Хурлаар Сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа явц болон Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Эмэгтэйчүүддээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Саналаа өргөөд байгааг нь гишүүд харгалзан үзнэ биз ээ. Үүнтэй холбогдуулан Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлнэ.

М.Оюунчимэг: Баярлалаа. Тэгэхээр бид нар маш чухал хууль хэлэлцэж байна. Сонгуулийн тухай хууль. Тэгээд би бас хэлж байна л даа. Энэ Улсын Их Хуралд ёс зүйтэй, хариуцлагатай, боловсролтой, улс орноо, хүнээ, ард иргэдээ боддог тийм хүмүүс олноороо орж ирээсэй, энд залуучууд эмэгтэйчүүд, ахмадууд бүгд л байна. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор хууль өнөөдөр хэлэлцэж байна. Дэлхийн бусад орнуудын парламентын жишгээс харахад эмэгтэйчүүдийн квот нь өөрөө тэр жендерийн балансыг барьсан тохиолдолд улс орны хөгжил бол үнэхээр өөр түвшинд хүрдэг юм аа гэдгийг бид олон орны жишээгээс харж байгаа. Гэтэл бусад улс оронтой харьцуулахад манай улсынх энэ парламентын дундаж эмэгтэйчүүдийн эзлэх хувь нь 29 хувиар доогуур байгаа нь Африкийн Риондо гэдэг улстай бараг адилхан түвшинд очоод байгаа юм аа.

Өнөөдөр та бүхэн мэдэх байх. Сүүлийн 3 жилд Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Ардын намын дарга Хүрэлсүх хэлж байна лээ. Эмэгтэй гишүүд олноороо орж ирснээрээ сургууль, цэцэрлэгийн хүртээмж өмнөхөөсөө өнөөдөр 3 дахин нэмэгдэж байна гээд. Би судалгаа хийж үзсэн. Яг сүүлийн 3 жилд цэцэрлэг, сургууль, эмнэлгийн хүртээмж асар их нэмэгдсэн. Манай эрэгтэй гишүүд ч мэддэг. Хүүхдийн асуудлууд, сургууль, Цэцэрлэгийн асуудал эмэгтэйчүүдийн эрхийн суудал ярихаар л эмэгтэй гишүүд та нар үүнийгээ хийгээрэй, эмэгтэй гишүүдээс очоод асуу гэдэг. Гэтэл өнөөдөр энэ асуудал өөрөө Монголын нийгмийн 51 хувь нь эмэгтэйчүүд байгаа. Өнөөдөр хүүхдийн эрх хамгааллын асуудал ямар өндөр түвшинд хүрч, 800 саяхан төгрөгийн төсөвтэй байсан өртгийг бид 8 тэрбум болгож өсгөсөн байгаа. Өнөөдөр сургууль, цэцэрлэгийн хүртээмж гээд аваад үзэхэд улсын хэмжээнд сургууль 46, нийслэлд 20, орон нутагт 26, цэцэрлэг шинээр 31 цэцэрлэг сүүлийн 3 жилд сүндэрлэн бослоо. Ингэснээрээ 3 ээлжээр хичээллэдэг сургууль байхгүй болж байна.

Өөрөөр хэлбэл цэцэрлэгт хүүхдээ оруулах гэж өглөөний үүрийн 4 цагаас очерлодог очер байхгүй болсон. Өчигдөрхөн манай Чингэлтэйд гэхэд Нийслэлийн жишиг 43, 240 хүүхдийн цэцэрлэг нээлтээ хийж ашиглалтад орж байгаа. Өнөөдөр эрхийн эмнэлгүүдийн байдал яаж өөрчлөгдөв. Тэгэхээр энэ бүхэн нь өөрөө юу хэлж байна гэхээр хатуу зөөлөн бодлогыг хослуулж байж улс орон зөв хөгждөг юм байна аа гэдгийг Сингапур, Скандиновын орнууд өнөөдөр харуулж байгаа юм. Тиймээс зүгээр нэг Их Хуралд олон эмэгтэй гишүүд гарч ирж юм уу албан тушаалын тухай бид яриагүй байна. Энэ өөрөө хүн рүүгээ улс ооныхоо хөгжил рүү чиглэсэн тэгш бодлогыг бий болгохын тулд жендерийн тэгш байдлыг, жендерийн балансыг барья гэдэг асуудлыг хөндөж байгаа юм аа. Тэгэхээр энд манай эрэгтэй гишүүд ухамсартай хандаач ээ гэж хүсмээр байна.

Өнөөдөр айл гэрт ч гэсэн эхнэр нь аав нь ижил үүрэгтэй балансаа барьж байж тэр гэр бүл өөдтэй өнгөтэй явдаг. Ер нь ажил сайн гүйцэтгүүлье гэвэл эмэгтэй хүнээр гүйцэтгүүлье гэсэн үг ч байдаг. Тэгэхээр энэ утгаараа бид нар өнөөдөр Улсын Их Хуралд сууж байгаа эмэгтэйчүүд ч гэсэн гаргасан хууль тогтоомж, энэ чуулганы ирц бүрдүүлэх нэр цэвэр байх тал дээр ч гэсэн маш хариуцлагатай байгаа. Тийм учраас олон эмэгтэйчүүдийн үүдийг нээхийн үүднээс бас сайхан залуучууд энэ шударга хүмүүс орж ирэхийн энэ жендерийн квотын асуудал дээр эргэж хараач ээ гэж уриалмаар байна.

Өнөөдөр манай нам эрх барьж байгаа. Намын дүрмийн 5.3.1 дээр эмэгтэйчүүдийн квотыг 30 хувиас доошгүй байлгана аа гээд заачихсан байгаа. Эрх барьж байгаа нам ч гэсэн энэ дүрэмдээ заасан заалтаа барих ёстой гэдгийг уриалж байна.

Тиймээс өнөөдөр энд цугларсан эмэгтэйчүүд маань чуулганд ордонд бас хэлэлцүүлэг ч болсон. Бүх эмэгтэй гишүүд маань энэ нөхөдтэйгөө нийлээд энэ бүх намын төлөөлөл байгаа, бүх төрийн бус байгууллагууд байгаа. Эрчүүдийг хамгаалах байгууллагын төлөөлөгч хүртэл орж ирээд сууж байна шүү, энэ дотор.

Энэ нь өөрөө юу хэлж байна гэхээр Монголын нийгмийг бодож байгаа, хүнээ бодож байгаа, хүүхдээ бодож байгаа асуудал учраас би энэ дээр квоттой холбоотой асуудал дээр эрчүүдээ ухамсартай хандаж дэмжээгүй саналыг дэмжихгүй байх дээр нь бүгдээрээ

Г.Занданшатар: Үг хэллээ. За эмэгтэйчүүдийн төлөөлөлдөө баярлалаа. Дараагийн ээлжээ оруулаарай. Одоо Оюунхорол гишүүн үг хэлнэ ээ.

Д.Оюунхорол: За, өнөөдөр шийдвэр гаргах түвшин эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сэдвээр Нийгмийн бодлогын байнгын хороо, Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн бүлэг хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэ хэлэлцүүлэгт өнөөдөр Монгол Улсын улс төрийн намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага, иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжиж олон жил ажилласан туршлагатай манай эмэгтэйчүүд энэ арга хэмжээнд оролцсон.

Мөн НҮБ-ын Хүн амын сан, хөгжлийн хөтөлбөр гээд олон байгууллагууд оролцсон. Зарим Элчин сайдын яамд оролцсон. НҮБ-ын Хүн амын сангаас илтгэл тавьж оролцсон. Өнөөдөр энэ олон арга хэмжээнүүдийн үеэр яригдсан зарим нэг сэдвийг бас та бүхэндээ хөндөж танилцуулъя.

Эмэгтэйчүүд эрх мэдлээ нэмэгдүүлэх гэж улс төрийн оролцоогоо нэмэгдүүлэх гэж 30 хувийн квотын тухай асуудлыг яриагүй ээ. Монгол Улсад өнөөдөр хүн амын 51,3 хувь, хөдөлмөрийн насны хүн амын 52,8 хувь нийт ажиллагсдын 49,6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа. Нийгмийн амьдралд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэйгээ яг адил түвшинд оролцож байгааг харуулсан ийм судалгааны дүн, тоо, статистикууд харагдаж байгаа юм.

Нөгөө талаас энэ дэлхийн улс орнуудын адил эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог Монгол Улс дэмждэг байхаар олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн үүрэг, конвенцод нэгдэн орсон эрх зүйн баримт бичгүүд маш олон байдаг юм. Нөгөө талаас Монгол Улсын Их Хурлаар баталсан жендерийн эрх, тэгш байдлыг хангах тухай хууль, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт гэрээ бусад хуулиудад тусгалаа олсон энэ шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд үгэндээ хүрээсэй, хэлсэндээ ярьсандаа байгаасай, шийдвэр гаргагчид маань 83 хувь нь эрэгтэйчүүд байгаа учраас энэ баталсан шийдвэрүүдээ хэрэгжүүлээсэй гэдэг ийм зорилтыг тавьж байгаа юм.

Хамгийн наад зорилт бол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” гэсэн баримт бичгийг бид Улсын Их Хурлаар баталсан. Нийгмийн

хөгжил дэвшил, жендерийн эрх тэгш оролцоог хангах замаар нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчныг бүрдүүлнэ ээ гэж баталсан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ гэсэн ийм зорилтууд байгаа юм. Гэтэл бид өнөөдөр дэлхийн 149 улсаас 58 дугаар байрт орж байгаа. Нөгөө талаас 2017 оны тайланд улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээрээ Монгол Улс дэлхийн 144 орноос 107 дугаар байрт эрэмбэлэгдсэн. Өөрөөр хэлбэл манай шийдвэр гаргах бодлого боловсруулах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн оролцоо бол ийм доогуур байна аа гэсэн үзүүлэлттэй явж байгаа юм.

Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг жендерийн эрх тэгш байдлыг хангах үзүүлэлтээрээ манай улс 2018 оны байдлаар 149 улсаас 58 дугаар байрт орсон. Азийн бүс нутгийн түвшинд бид нар харьцангуй гайгүй гэсэн судалгааны дүнгүүд явж байгаа.

Тэгэхээр бид нар 144 орноос 107-д эрэмбэлэгдэж байгаа энэ асуудалдаа дүгнэлт хийж, манай улс төрд оролцож байгаа, шийдвэр гаргаж байгаа эрчүүд маань энд уян хатан хандаасай гэсэн байдлаар өнөөдөр эмэгтэйчүүд маань та бүхэнд дуу хоолойгоо хүргэж энд алга дарам цаасан дээр 30 хувийн квотыг дэмжиж өгөөсэй гэсэн саналаа, хүслээ, бодлоо тээж оруулж ирж байгаа. Өнөөдөр та нар нэгэнт цаана чинь та нарын сонгуульд олон эмэгтэйчүүд гар бие оролцож, гутлынхаа улмыг эргэтэл явж та нарыг сонгуульд оролцуулдаг.

Өнөөдөр нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд эмэгтэйчүүдийн оролцоо ямар их байдаг. Ер нь Улсын Их Хурлаар батлуулж байгаа нийгмийн хамгаалал, нийгмийн бодлогын чиглэлийн бүх хуулиудыг

Г.Занданшатар: 20 минутын дараа асуулт хариултын цаг дуусаж санал хураалт эхлэх тул гишүүд 20 минутын дараа чуулганы танхимдаа бүрэн цуглана шүү. Оюунхорол гишүүн үг хэллээ. Одоо асуугаад хариулт аваад, хариулт хангалтгүй гэж үзэх л юм бол нэмэлт тодруулж асууна. Одоо ингээд цаг дууссан бол. Ундармаа гишүүн.

Б.Ундармаа: Сонгуулийн хуулийн 31.2 дээр нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна гэж заасан. Энэ заалт маань Төрийн байгуулалтын байнгын хороо дээр манай Амарзаяа гишүүн бол 30 хувь байлгахгаар санал оруулсан. Тэгээд энэ дээр 3 саналаар унасан байна. Ер нь энэ удаагийн 2016 оны сонгуулийн үр дүнгээр 13 эмэгтэй гарч ирснээр олон асуудлууд хийгдсэн. Үүний хамгийн 1 дүгээрт хүчирхийлэл, 2 дугаарт хүүхдийн эрх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах бүх асуудлууд, дээр нь эрүүл мэнд, боловсрол, ажлын байрыг нэмэгдүүлэх тал дээр маш их ахиц дэвшлүүд гарч байгаа. Тийм учраас эмэгтэйчүүдийн квотыг 30 хувь байлгаач ээ гэж манай нийт 13 эмэгтэй, мөн улс төрийн намуудын дэргэдэх эмэгтэйчүүд, олон нийтийн байгууллагууд бүгд дэмжиж байгаа. Үүнийг эрэгтэй гишүүд маань анхаарч өгөөч ээ. Ер нь эрчүүдийн маань ард хамгийн найдвартай, ухуулагч болон бүх зүйл дээр хамгийн сайн менежерээр нь ажилладаг хүмүүс бол эмэгтэйчүүд байдаг. Гэтэл эмэгтэйчүүдийн маань асуудал шийдвэр гаргах түвшинд тэгээд улс төрийн намуудын сонгуулийн хууль дээрээ бага хувиар орж ирж байна. Үүнийг дэмжиж өгөөч ээ гэдгийг уриалж байна.

Г.Занданшатар: Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн. Асуулт асууна.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Өнөөдөр сонгуулийн хуулийг дахин өөрчилж байна. 4 жилд 1 удаа өөрчилдөг жишиг бол Монгол Улсад тогтоод удаж байгаа. Энэ бол Их Хурал өөрөө төлөвшөөгүй байгаагийн нэг нотолгоо л доо. Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар үүнийг олон дахин яриад зарчмын санал оруулаад харамсалтай нь энэ дэмжигдээгүй, одоо ингээд дахиад л бантан, бидний зовлон давтагдаж эхэлж байгаа юм. Бүгдээрээ анзаарч байгаа байх.

Томсгосон мажоритар гэдэг бол үндсэндээ тэр жижиг мажоритараас зарчмын ялгаа байхгүй юм л даа. Аймагт 3 тойрог байсан бол аймаг 1 тойрог болж байгаагаараа ялгаатай байгаагаас биш яг улс төрийнх нь онцлог, хариуцлага, парламентын төлөвшилд бол их том өөрчлөлт орохгүй ээ. Бид ингэж өөрийгөө хуурч болохгүй. Өнөөдрийг хүртэл Ардчилсан нам холимог тогтолцоог буюу бас нэг пропорционалийг энэ хуульд оруулчихвал энэ улс орны ирээдүйн хөгжилд хэрэгтэй байсан юм даа гэж зүтгэсэн боловч талаар өнгөрч байгаа.

Ардын нам анх оруулж ирэхдээ 26 улс нэг тойрог гээд бүр хачин юм оруулж ирсэн чинь одоо нөгөө тал руугаа савчихсан. Уг нь бид нар ухаалаг харилцан ярилцаад ойлгож шийддэг байсан бол үүнийгээ харин хувь тэнцүүлэнгээ аймаг, бүсчилсэн байдлаар жоохон хийсэн болбол илүү ухаалаг сонголт байсан боломжийг өнөөдөр бид нар алдаж байгаа. Тэгээд 2008 оныхоо сонгуулийн хуулийг дахиж ярьж байдаг. 2008 оны сонгуулийн хуулийн томсгосон мажоритар гэдгийг Ардын нам эрх баригч байхдаа л гаргасан ийм хувилбар. Энэ гашуун үр дүн авчирсан юм бэ гэдгийг Монголын ард түмэн бүгдээрээ мэдэж байгаа. Бослого жагсаал болсон. 5 хүний амь нас сүйдсэн. Монгол Ардын Хувьсгалт намынх нь байр нь хүртэл шатсан шүү дээ. Ийм хэл маргаантай энэ тогтолцоог дахин сонгож байгаа нь бид буруу гэж харж байгаа.

Өнөөдөр Ардчилсан нам холимог тогтолцооны байр сууриндаа хэвээрээ байгаа. Энэ тогтолцоо жижиг намуудыг жийсэн, намын дотоод зөрчилдөөнийг өдөөсөн, олон сөрөг үр дагаврыг авчирна гэдэг нь эргэлзээгүй. 27, 28 тойрогт таньдгаа гаргачхаад бүгдээрээ ялна гэдэг магадлал байгаа бол түүн шиг худлаа юм байхгүй. Ард түмэн тэнэг биш. Сонголтоо харж байгаад зөв хийнэ гэж би бодож байгаа. Тийм учраас энэ тогтолцоог бид нар дэмжихгүй байгаа.

Бид ажлын хэсэг дээр зарчмын санал гаргаад хуучин сонгогчдын жагсаалтыг улс төрийн нам эвсэлд өгдөг байсныг үүгээр хаасныг буруу гэж үзэж байгаа. Яагаад энэ жагсаалтыг оруулж ирсэн юм бэ гэвэл 2008 оны тогтолцооны гажуудал чинь энэ нэрсийн жагсаалтыг буруу гаргадаг, олон тойрог дээр очиж санал өгдөг, үүнээсээ болж гараар тооллого хийгээд бузар булай булхайг гаргадаг энэ бүх зүйлийг хийсэн учраас үүнийг бид энэ гашуун туршлагаасаа авч энэ жагсаалтыг нийтэд ил байх ёстой гэдэг шаардлагыг тавсан шүү дээ. Энэ ил байснаараа нийгэмд сөрөг юм юу ч авчраагүй. Тэгтэл өнөөдөр үүнийг хүчээр хааж байгаа. Сонгууль өгсний нотолгоог хүчээр байхгүй болгож байгаа, хурууны тэмдэглэгээг. Тэгэхээр ирэх сонгууль луйваргүй болно гэсэн баталгаа байхгүй болж байгаа гэдгийг бүгдээрээ санах хэрэгтэй.

Би тэгээд үүнийг яагаад ингэж хийсэн юм бэ гээд асуухаар битүү тойруу хариулт өгдөг. Би гишүүддээ уриалах гэж байгаа юм. Энэ асуудлыг энэ зарчмын зөрүүтэй саналууд орж ирэхэд үүнийг дэмжээрэй. Бид гашуун туршлага дээрээ хийсэн засвараа буцаагаад нурааж болохгүй шүү гэдгийг би та бүхэнд зориуд

хэлмээр байгаа юм. Энэ чинь сонгогчдын эрх ашиг. Монголчуудын. Нэр дэвшигчдийн эрх ашгийн тухай асуудал байгаа.

Г.Занданшатар: Тогтохсүрэн дарга асуултад хариулна.

Д.Тогтохсүрэн: Сонгуулийн хууль, Үндсэн хуульдаа л захирагдана. Үндсэн хуульд бол холимог тогтолцоо дэмжигдээгүй. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр. Энх-Амгалан нарын гишүүдийн өргөн барьсан төсөлд 50, 26-ийн төсөл орж ирсэн. 26 нь бол пропорционалийн элемент байгаа учраас Үндсэн хууль зөрчигдөж болзошгүй юм аа гэдэг үүднээс мажоритар болгож авч үзэж байгаа юм. Тэгээд л мажоритар чинь том жижиг тойрог л байгаа юм. Янз бүрийн нөлөөллөөс арай байгаа, улс орныхоо цаашдын нийгэм, эдийн засагт голлох нөлөөтэй том тойрог байх нь зүйтэй юм аа гэж үзэж л энэ аймаг, дүүрэг тойрог байх системийг л сонгож авч байгаа юм. Бид өнөөдөр Үндсэн хуулийнхаа хүрээнд л хийж байгаа ажил. Үүнээс өөр гарц өнөөдрийн Үндсэн хуулийн хүрээнд байхгүй байгаад байгаа юм.

Сонгогчдын нэрсийн жагсаалтыг 2016 оны хууль дээр сонгогчдын нэрсийн жагсаалтыг хувилж улс төрийн намуудад өгнө гэсэн хуулийн заалт байсан. Энэ заалт хууль санаачлагчдаас орж ирэхдээ ч хасагдсан. Ажлын хэсэг дээр яриад ч хасагдсан. Хасагдах 2 үндэслэл байгаад байгаа юм.

1 дүгээрт нь сонгогчдын нэрсийн жагсаалтыг 2018 онд баталсан улсын бүртгэлийн багц хууль буюу иргэний бүртгэлийн хуулиар нь нууцад хамаараад байгаа юм. Хувь хүний нууцтай холбоотой асуудал байгаа юм. Хувь хүний регистр, хувь хүний гэрийн хаяг эд нар чинь бүгд хувь хүний нууцын асуудал аа. Гэтэл үүнийг жагсаалтаар нь өгч байна аа гэдэг бол болохгүй гээд байгаа юм аа.

Нөгөө талаас нь бол энэ асуудалтай холбогдуулж би Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргыг нэлээн тодорхой тайлбар өгөх болов уу гэж бодож байна.

Сонгогчдыг тэмдэгтэй холбоотой асуудал байгаа юм. Долоовор хуруун дээр нь бид нар хумс дээр нь хар бэхээр тэмдэглэж басан асуудал байгаа. Одоо бол улсын бүртгэлээс юу гэж байна гэхээр Монгол Улсын бүх иргэн бүгдээрээ гарын хурууны хээтэй болсон. Иргэн энэ гарын хурууны хээ бол огт давхцахгүй. 1 иргэн 2 өөр газар очиж санал өгөх ямар ч боломжгүй. Тийм учраас гарын хурууны хээтэй учраас иргэн давхацсан дахин санал өгнө гэдэг ойлголт огт байхгүй юм. Тийм учраас хар бэх хэрэглэх, иргэний үнэмлэх дээр дардас дарах шаардлагагүй гэж үзээд байгаа юм.

Нөгөө талаас энэ хар бэх гэдэг юм нь өөрөө үйлдвэрлэхээ больчихсон. Тээвэрлэхэд хүндрэлтэй. Бэхээ түрхсэний дараа харшил үүсгэдэг гээд олон байдлын үүднээс үүнийг хэрэглэх боломжгүй гэж Сонгуулийн байгууллага үзээд байгаа юм. Би энэ улсын бүртгэлийн байгууллага, сонгуулийн байгууллага 2 энэ 2 асуудалд бас нэмэлт тайлбар өгөх болов уу гэж бодож байна.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. За, Баасандорж 80 дугаар микрофон. Содномцэрэн дарга дараа нь 84 дүгээр микрофон. Асуултад хариулна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар Баасандорж, Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой асуулт асууж байна. Төсөл санаачлагч гишүүд маань хуулийн төслөө өргөн барихдаа бол энэ сонгогчдын нэрийн жагсаалтыг улс төрийн намуудад 1 удаа хувилж өгөх хуулийн заалтыг хасаж өргөн мэдүүлсэн байгаа. Энэ нь Сонгуулийн ерөнхий хороонд бол 2 үндэслэл байгаа.

Нэг дэх үндэслэл нь бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Сонгуулийн тухай хууль дээр 61.17 дээр санал авах байрны албан ажлын хэрэгцээнээс бусад тохиолдолд сонгогчийн нэрийн жагсаалтыг хувилж олшруулах, тараахыг хориглоно гэсэн нэг заалт байдаг.

61.18 дээрээ улс төрийн намуудад цахим хэлбэрээр 1 удаа олгоно гэсэн ийм заалт байдаг. Энэ 2 заалт маань хоорондоо зөрчилтэй заалт байдаг. Яг энэ заалтыг үндэслээд Сонгуулийн ерөнхий хороон дээр иргэдээс маш их гомдол ирлэг байсан. Хувь хүний нууцтай холбоотой мэдээллүүдийг хувилж олшруулж улс төрийн намуудад тараалаа, энэ байдлаа зогсоогооч гэдэг судалгаа гарсан юм байна лээ. Нэг дэх үндэслэл нь.

2 дахь үндэслэл нь бол улсын бүртгэлийн багц 4 хууль 2018 оны 6 сарын 21-ний өдөр хууль тогтоогчид баталж өгсөн байгаа. Энэ хууль дээр иргэдийн ямар мэдээлэл нь нээлттэй байх юм. Иргэдийн ямар мэдээлэл нь хаалттай, хязгаартай байх юм гэдгийг хуульчилж өгсөн байгаа. Тухайлбал иргэний оршин суугаа хаяг, овог, эцэг эхийн нэр, регистрийн дугаар бол хязгаартай мэдээлэл шүү гэж улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.6-д зааж өгсөн байгаа. Гагцхүү Шүүхийн шийдвэрээр тухайн иргэн хэрэг маргаанд холбогдвол прокурорын зөвшөөрлөөр мөрдөгчийн өгсөн саналын дагуу УБЕГ тухайн иргэнтэй холбоотой, хувь хүнтэй холбоотой мэдээллийг хууль, хяналтын байгууллагад өгнө гэсэн заалтыг хийж өгсөн байгаа юм.

Өргөн мэдүүлсэн төслийн 21.15 дээр сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж олшруулахыг, тараахыг хориглоно гэсэн заалт байгаа. Ийм үндэслэлүүд байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 84 Содномцэрэн дарга. 83 дугаар микрофон. 83.

Ч.Содномцэрэн: Асуултад хариулъя. Энэ сонгогчийн хуруун дээр бэхээр тэмдэглэгээ хийдэг ажиллагаа бол 2008 оноос хойш зогссон байсан. 2012 оны сонгууль, 2013, 2012 он 2 сонгууль, 2013 оны Ерөнхийлөгчийн сонгууль, 2016 оны 2 сонгуульд хэрэглээгүй явсан. Яагаад хэрэглээгүй гэхээр 2012 оноос эхлээд сонгогчийн бие нь давхцахгүй өгөгдөл хурууны хээгээр бүртгэж эхэлснээс хойш бэхэн тэмдэглэгээг зогсоосон байсан. Гэвч 2017 онд зарим намуудын шаардлагаар үүнийг бүх хэсэгт хэрэглэж чадаагүй, бэхний хүрэлцээ байхгүй. Зарим хэсгүүдэд хэрэглэсэн.

Яагаад үүнийг хэрэглэх боломжгүй гэж үзэж байгаа гэхээр үйлдвэрлэдэг үйлдвэр нь 1 дүгээр хаагдсан гэсэн мэдээллийг бид Элчин сайдын яамнаас авсан, тухайн үед.

2 дугаарт энэ бэхийг олон улсын тээврийн хэрэгслээр энэ төрлийн бодисыг тээвэрлэхийг хориглосон олон улсын гэрээтэй байдаг юм байна. Ийм 2 үндсэн шалтгаанаар бид 2008 оноос хойш энэ бэхийг хэрэглээгүй. Бие нь давхцахгүй өгөгдөл хурууны хээгээр нь бүртгэж явсан.

Түүнээс гадна 2017 онд хэрэглэж байхад энэ бэх дээр гомдол гарсан. ГСҮТ-өөс манайд ийм мэдээлэл ирсэн. Танай энэ бэхнээс болж хүний арьс гэмтсэн, түлэгдсэн байна. Тэгээд үүний дагуу иргэн бол хүсэлт тавьсан. Эмнэлгийн зардал, нөхөн олговрыг олгож өг өө гээд. Үүний дагуу СЕХ хуралдаад СХД-ийн 22 дугаар хэсэг дээр ажиллаж байсан энэ хордсон хүнд нөхөн олговрыг тухайн үед олгож байсан. Ер нь цаашдаа энэ бэхийг нэг дүгээрт үйлдвэрлэдэг газар нь хаагдсан, 23 дугаарт тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг олон улсын хэмжээнд хориглосон, 3 дугаарт эмнэлгийн байгууллагаас бид нарт зөвлөмж өгсөн. Үүнийг цаашдаа хэрэглэхгүй байхыг зөвлөсөн. Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна гэдэг. Тийм учраас энэ саналыг дэмжихгүй байгаа.

Г.Занданшатар: Хурууны хээ хүршгүй гээд бэхнээс найдвартай гээд байх юм. Уул нь СЕХ-ны дарга Содномцэрэн дарга тайлбарлаад байгаа. Бэх ерөөсөө ашиглахаа больсон гээд яриад байгаа. Хурууны хээгээр авч байгаа юм чинь гээд. Тэгээд ийм асуудал байдаг бол үүнийг сайн судалж үзнэ биз. Тэр нэрсийн жагсаалт заавал авах гээд зүтгээд байдаг юм. Тэр хувь хүний нэр бүртгэл, хаяг, овог нэр шаардлагагүй бол овог нэрийг нь авдаг юм байгаа биз, тэр хүний хаяг, гэр бүлийн юм эд нарыг хэдэн хүнтэй байдаг, үр хүүхэд чинь хувь хүний нууц мэдээлэлд хамаарагдаад байна шүү дээ. За ингээд асуулт асууж, үг хэлж дууслаа. Гишүүд.

Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Нэг. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.3.Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Баасанхүү, Л.Болд, Мөнх-Оргил, Нямбаатар, Оюунхорол, Содбаатар, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. Цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт явуулна.

Санал хураалтад 52 гишүүн оролцож 36 гишүүн дэмжиж, 69,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Сонгуулийн нутаг дэвсгэр нь тойрогт хуваагдана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 52 гишүүн оролцож, 36 гишүүн дэмжиж, 69,2 хувийн саналаар дэмжигдлээ.

Санал гаргасан ажлын хэсгийн гишүүн Дондогдоржийн Эрдэнэбат, Янгүгийн Содбаатар нарын санал эсрэг гараад байх юм. Дэмжсэнээр тооцох уу, эсрэгээр явах юм уу.

Протоколд дэмжсэнээр тусгалаа. Ажлын хэсгийн гишүүдийн гаргасан саналаар.

Цаашаа явна аа. Энэ 2 санал дэмжигдсэн учраас дараагийн санал хураалт явна.

3.Ажлын хэсгийн гаргасан, 3.Төслөөс 18 дугаар зүйл, 22 дугаар зүйл,5 дугаар зүйлийн 5.2, 9 дүгээр зүйлийн 9.3, 11 дүгээр зүйлийн 11.3, 21 дүгээр зүйлийн 21.11, 60 дугаар зүйлийн 60.2, 60.5, 63 дугаар зүйлийн 63.2, 63.4, 66 дугаар зүйлийн 66.16, 66.17, 66.18, 68 дугаар зүйлийн 68.15, 68.16, 68.17, 68.18, 72 дугаар зүйлийн 72.19, 72.20, 72.21, 76 дугаар зүйлийн 76.6, 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.4.3 дахь заалтын “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойргоос сонгогдсон” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсгийн “энэ хуулийн11.3-т заасан” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.18 дахь хэсгийн “болон төв комиссын дарга” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийн “22” гэснийг, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “энэ хуулийн 11.2-т заасан сонгуулийн тойрогт” гэснийг, 76 дугаар зүйлийн 76.7 дахь хэсгийн “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж” гэснийг, 78 дугаар зүйлийн гарчгийн “Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудлыг нөхөх,” гэснийг, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад 49 гишүүн оролцож, 34 гишүүн дэмжиж, 69,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Яагаад 4 гишүүний карт сугарчхав. Зөвшөөрөлгүй хүний карт сугалахгүй шүү.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.4 дэх заалтын “энэ хуулийн 11.3-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж” гэснийг “нэр дэвшигчийг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4, 14.5 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад” гэснийг “Сонгуулийн хороодод” гэж, 14 дүгээр зүйлийн 14.18 дахь хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага” гэснийг “Сонгуулийн хороод” гэж, 20 дугаар зүйлийн 20.19 дэх хэсгийн “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагын” гэснийг “Сонгуулийн хороодын” гэж, 20 дугаар зүйлийн 20.20 дахь хэсгийн “байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад” гэснийг “сонгуулийн хороонд” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

73,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн доор дурдсан зүйл, хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах:

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсэг:

“14.1.Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн ерөнхий хороо удирдан зохион байгуулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн хороог нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

14.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон хэсгийн хороо нь байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага /цаашид “сонгуулийн

хороод” гэх/ бөгөөд хэсгийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд хамаарна.”

Төслийн 30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг:

“30.6.Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно.”

Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг:

“31.1.Нам, эвсэл Монгол Улсын Их Хурлын сонгуульд 76-аас илүүгүй хүнийг нэр дэвшүүлнэ.”

Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг:

“32.1.Энэ хуульд заасан шаардлагыг хангасан иргэн бие даан нэр дэвшиж болно.”

Төслийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг:

“67.2.Сонгогч саналын хуудаст бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө.”

Төслийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг:

“Тойрогт ногдсон мандатын тооноос илүү эсхүл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.”

Төслийн 75 дугаар зүйл:

“75.1.Сонгуулийн ерөнхий хороо нь санал хураалтын дүнг үндэслэн тухайн тойрогт нийт нэр дэвшигчийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана.

75.2.Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

75.3.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу тойрогт хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Монгол Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ.

75.4.Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хуралд, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.”

Төслийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг:

“78.1.Энэ хуулийн 4.3.3-т заасан үндэслэлээр нөхөн сонгууль явагдана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

Чинзориг гишүүн үг хэлнэ.

С.Чинзориг: Сонгуулийн ерөнхий хороо зохион байгуулна гээд байгаа юм. Би бол энэ Сонгуулийн ерөнхий хороонд итгэхгүй байгаа юм. 2012 онд ард түмний сонголтыг эрх барьж байгаа улс төрийн хүчинд үйлчилж, хууль зөрчиж, хүчээр авч хоцорч сонгууль будилаантуулж, манай энд сууж байгаа 26 гишүүн олохгүй байна. Коридороор зугтчихлаа. Гараашаараа зугтчихлаа гээд бөөн юм болсон шүү дээ.

Энэ Сонгуулийн ерөнхий хорооныхоо удирдлагыг өөрчлөх болоогүй юм уу. Тэгээд энэ Содномцэрэн яасан ч одоо ичих нүүргүй нөхөр байдаг юм. Ичих булчирхай нь одоо хаачсан хүн байдаг юм. Өөдөөс харчхаад ингээд суугаад байх юм. Тэгэхээр одоо Сонгуулийн ерөнхий хорооныхоо даргын асуудлыг эхлээд шийдмээр байна шүү дээ.

Сонгуулийн ерөнхий хорооныхоо удирдлагыг сольж байж энэ шинэ хуулиараа шинэ хуулиа зохион байгуулъя гэсэн ийм санал хүсэлтэй байгаа. Үүнийг Төрийн байгуулалтын байнгын хороо, манай бүлэг ойрын хугацаанд хүлээж авч шийдэх ёстой байх аа гэж.

2 дахь асуудал нь хамгийн олон санал авсан тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож үнэмлэх олгоно оо гээд өмнөх хуульд ч ийм л байсан л даа.

Тэгээд тойргийн хороо нь хүлээн зөвшөөрөөд үнэмлэх олгосон хүнийг л энэ Содномцэрэн чинь авч хоцроод тэгээд л байхгүй болгочихсон шүү дээ. Тэгэхээр энэ одоо давтагдах уу, давтагдахгүй юу гэдгийг бид сайн бодох ёстой байна.

2 дахь асуудал нь нөгөө шүүх сонгуулийн маргаантай холбоотой асуудлыг хэрхэн яаж шийдэх юм бэ. Шүүх ямар үе шатанд нь шүүх оролцох юм бэ гэдгийг бас манай энэ ажлын хэсэг бодсон л байдаг байгаа даа.

1 тойрог олон мандаттай гэхээр сонгуулийн маргаантай холбоотой асуудал үүсэхээр нам нь энэ хууль зөрчсөн байна уу үгүй юу гэдгийг тогтоох асуудлыг жич авч үзэх ёстой. Нөгөө талаас энэ чинь олон мандаттай тойрог учраас 3 мандаттай, 2 мандаттай тойрог дээр сонгуулийн хууль зөрчсөн асуудал гарвал бөөнөөр нь бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөхгүй бариад байх уу. Үгүй бол 1 гишүүнтэй нь холбогдсон асуудал байна гэж үзээд бусдыг нь өргөн барих уу. Үгүй бол нам нь сонгуулийн хууль зөрчсөн байна уу гэдгийг ялгаж салгах уу.

Энэ асуудлуудыг манай ажлын хэсэг хэр бодсон бол доо. Тэгэхгүй бол энэ чинь 1 мандаттай тойрог биш, олон мандаттай тойрог учраас ингэж болохгүй шүү дээ.

Нам энэ хууль зөрчсөн бол нам нь яах юм. Олон мандаттай тойрог дээр 1 гишүүн нь нэр дэвшигч нь хууль зөрчсөн бол бөөнд нь нөгөө 2-ыг нь, нөгөө 3-ыг нь хүчингүй болгох асуудал ярих уу үгүй юу гээд нэлээн маргаантай асуудал гарна. Энэ бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөхтэй холбоотой асуудлыг манай ажлын хэсэг Байнгын хороон дээр нэлээн сайн ярьж, нягталсан байгаа даа гэж би бодож байна.

2012 оны хууль чинь холимог хуулиар явагдсан. Хэрвээ хууль зөрчсөн бол нам нь хууль зөрчсөн юм уу, нөгөө талаасаа олон мандаттай тойргоор бас явсан. Хууль зөрчсөн бол 2 нэр дэвшигчийн 3 нэр дэвшигчийн хэн нь хууль зөрчсөн юм

бэ гэдгийг тогтоохгүйгээр нийтэд нь хавтгайруулаад л сонгуульд хууль зөрчсөн байна аа гээд л баахан балбаад, сүүлдээ сонгогчдын эрх зөрчөөд хоцорсон шүү дээ.

Тэгэхээр олон мандаттай учраас энэ асуудлыг манай ажлын хэсэг, Байнгын хороо нэлээн нягталсан байгаадаа гэж би бодож байна. Хэрвээ энэ асуудлыг дахиж дараагийн хэлэлцүүлэг дээрээ, Байнгын хороон дээрээ ярьж олон мандаттай ийм асуудал гарахаар намтай нь холбоотой асуудлыг жич ярих юм уу.

Хэрвээ сонгуулийн хууль зөрчсөн асуудал гарвал хүн тус бүрээр нь ярих юм уу, бөөнд нь мандатаараа, тойргоор хууль зөрчсөн байна гээд аваад хоцрох уу. Хүлээн зөвшөөрөхгүй байх уу гэдэг нэлээн маргаантай асуудал гарна. Үүнийг дараа дараагийн хэлэлцүүлэг дээр манай ажлын хэсэг, Байнгын хороо нэлээн нухацтай авч үзэх байх аа гэсэн саналтай байгаа юм.

Г.Занданшатар: За, Сандагийн Бямбацогт дарга. Чинзориг гишүүний хэлж ярьж байгаа санал асуудлыг Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгтээ анхаарахыг чиглэл болгож байна. Шүүхээр сонгуулийн асуудлыг шийдэх асуудлыг нарийвчлан судалъя гээд байна шүү дээ.

За санал хураалт явуулъя. Санал хураалт.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.1.“18 нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн, он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;

3.1.2“25 нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

73,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “иргэний улсын бүртгэлийн биеийн давхцалгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэлд бүртгүүлж, иргэний бүртгэлийн дугаар авсан эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг;” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг;” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

Тогтохсүрэн гишүүн. Асуулт байхгүй. Дэгээрээ.

Д.Тогтохсүрэн: Саяны 7 дугаар санал дээр дарга аа, нэг, энэ дээр чиглэл өгчихмөөр байгаа юм. Төсвийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын гэсний дараа 18 насанд хүрсэн гэдэг орох юм шүү дарга аа. Таны уншсан дотор сая алдаа гаргаад орхигдсон байгаа юм. 18 насанд хүрсэн гэдэг орно. Эхэн дээр нь.

Г.Занданшатар: 18 насанд хүрсэн гэж орсон.

Д.Тогтохсүрэн: Байгаа. Ахиад дээр нь орох юм. Дээр нь орж 18 нас хасагдаад, доор нь ахиад 18 орно. Дээд талынхыг нь хасаад доод талынхыг нь

нэмж байгаа юм. Тэгэхээр цаана нь 18 нас үлдчихээд 2 18 болчих гээд байгаа учраас хоюуланг нь оруулж байгаа юм.

Г.Занданшатар: Редакц дээр иргэний бүртгэлийн дугаар авсан 18 нас хүрсэн эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг гэж залруулж бичих юм байна шүү. Байнгын хороо ийм алдаа гаргасан байна шүү гэж ойлголоо зөв үү. Энэ чинь эцсийн хэлэлцүүлэг дээр үүнийг авч үзэхгүй юм чинь, хасагдах учраас

Дараагийн асуудал.

8.Төсвийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8 дахь заалт нэмэх, хуулийн нэр томъёоны дарааллыг цагаан толгойн дараалалд оруулах:

“3.1.8.“Цахим хуудас” гэж бүх төрлийн контентыг интернэтийн домэйн нэр болон цахим орчин дахь олон нийтийн сүлжээг ашиглан хэрэглэгчид хүргэдэг программ хангамжийг;” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

За, Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Саяны санал дэмжигдсэнтэй холбоотойгоор дарга аа, 48.3 дахь хэсэгт чиглэл өгүүлэх хэрэгтэй байгаад байгаа юм. Давхцал үүсээд байгаа учраас та Зөрчлийн хуультай холбогдуулж, 48.3 дээр чиглэл өгөөдхөөрэй. Засах чиглэлийг.

Г.Занданшатар: 48.3 дээрээ ярьж болохгүй юм уу, наадахаа. За 48.3 дахь заалттай нь энэ заалт дэмжигдсэнтэй холбогдуулан гарсан зөрчлийг арилгах чиглэл өгч байна.

9.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.9 дэх заалт нэмэх, хуулийн нэр томъёоны дарааллыг цагаан толгойн дараалалд оруулах:

“3.1.9.“Ял эдэлж байгаа” гэж Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд заасан үндсэн болон нэмэгдэл ялыг эдэлж дуусаагүй, эсхүл торгох ялыг биелүүлээгүй байхыг ойлгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

63,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “аймгийн төвд 3000-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 4000-аас” гэснийг “аймгийн төв болон дүүрэгт 3000-аас дээшгүй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

11.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсгийн “талаар” гэсний ард “байр сууриа илэрхийлэх,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “хороог” гэсний дараа “тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “өмнө” гэсний дараа “тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсгийн “бөгөөд” гэсний дараа “нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Өнөөдөр 100 гаруй санал хураагдана. Түүн дээр та хэдийн ярих сэдвүүд байгаа. Тухайн сэдэв сэдэв дээрээ л гаргасан санал дээрээ Байнгын хороон дээрээ цөөнх болсон, гаргасан, дэмжсэн саналууд дээрээ ярих эрх нээлттэй.

14.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.16 дахь хэсгийн “журмыг” гэснийг “, сонгогч шилжих журам болон маягт, загварыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ дандаа техникийн шинж чанартай, тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбогдуулсан саналууд явж байгаа учраас.

Санал хураалтад 48 гишүүн оролцож, 34 гишүүн дэмжиж, 70,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийн “энэ хуулийн 23.2-т заасны дагуу цахим хуудаст байрлуулсан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16.Төслийн 26 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 26, 27 дугаар зүйл болгох:

“26 дугаар зүйл. Сонгогч шилжих

26.1.Сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж буй цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шийдвэрлэнэ.

26.2.Нэр дэвшигч болон энэ хуулийн 38.3-т заасан менежер, шадар туслагч сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих бол санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг хийлгэж болно.

26.3.Энэ хуулийн 26.1, 26.2-т заасан сонгогч санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг бүртгүүлнэ.

27 дугаар зүйл.Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох

27.1.Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 2 дугаар сарын 1-ний өдрөөс, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол уг шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн өдрийн дараах ажлын өдрөөс эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох, сэргээх тухай шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.

27.3.Нэмэлт болон дахин санал хураалт явагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ хуулийн 27.1, 27.2-т заасан иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг түр зогсоох хугацааг тухайн нэмэлт болон дахин санал хураалт явагдаж дуустал үргэлжлүүлж, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.

27.4.Ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулахаар товлон зарласан эрх бүхий байгууллага тухайн шийдвэрийг ажлын 3 өдрийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.” санал гаргасан ажлын хэсэг.

Раднаасэд гишүүн, Дамба-Очир гишүүн үг хэлнэ. Раднаасэд гишүүн үг хэлнэ.

Ш.Раднаасэд: Энэ 27 дугаар зүйл дээр ажлын хэсэг анхаарахгүй бол 1 зүйл гарна аа. Энэ хаана их санал хаягдах уу гэхээр одоо уурхай дагасан газрууд Өмнөговь, Говь-Алтайн зарим сумууд дээр байгаа, Ховдод байгаа. Өөр хаагуур байна, мэдэхгүй. Улаанбаатар хотоос очиж тэнд 7, 8 сараар ажилладаг, Улаанбаатар хотод оршин суух хаягтай боловч орон нутагт ажилладаг, сонгуулийн үеэр. Тэнд яг үндсэн уурхай ч гэдэг юм уу юу гэдгийн, түр ажлын байрууд дээр. Энэ хүмүүсийн санал өгөх эрх нь хаагдчихна аа. 2 сарын 1-ээс өмнө хийгдэхгүй бол үүнээс хойш тэр хүн санал өгөх ямар ч боломжгүй ийм нөхцөл байдал үүсэх гэж байна. Энэ өөрөө эргээд юу болох юм гэхээр за яах вэ бид нар өнөөдөр энд царцаа гээд янз янзын юм яриад ингээд хаачхаж болно. Дараа нь энэ хүмүүс чинь санал өгөөгүйнхээ төлөө жагсаал цуглаан хийх бусад хэлбэрээр ямар нэгэн эсэргүүцэл үзүүлэх юм гарна аа. Тэгэхээр энэ 27 дээр ялгавартай хандаж өгөхгүй бол тухайн үйлдвэрт гэдэг юм уу одоо хаана гэдгийн тэр ажлын байрууд дээр ажиллаж байгаа, тэндээ хуучин бол байнга болон түр оршин суугч гэж 2 ангилж байсан шүү дээ. Түүнийг чинь бүр байхгүй болгоод хаячхаж байгаа байхгүй юу. 2 сарын 1-ээс өмнө оршин сууж байгаа тухайн сум, дүүргээсээ өөр аймаг суманд ажиллаж байгаа болбол шилжүүл, тэндээ бүртгүүл, шилжиж оч. Очихгүй бол 2 сарын 1-ээс хойш очсон байвал тэнд бүртгэл хийгдэхгүй, сонгогчийн нэрсийн жагсаалтад нэр нь орохгүй гэдэг ийм юм руу явчхаж байна. Энэ маш их олон хүний санал хаягдана аа. Энэ 27 дугаар зүйл дээр. Тэгэхээр үүнийг бодвол ажлын хэсэг хоорондоо ярьсан байлгүй гэж бодож байна.

Г.Занданшатар: Дамба-Очир гишүүн үг хэлнэ

Д.Дамба-Очир: Би нэг зүйл хэлэх гээд байгаа юм. 2 сарын 1-ээс өмнө энэ шилжилт хөдөлгөөн гэж ярьж байна. Одоо жишээлбэл манай дээр миний одоо 20, 30-аад жил амьдарч байгаа газар манай 4 хүүхэд, манай гэр бүлийн хүн бид 6-аас гадна 3, 4 хүний нэр биччихсэн байдаг. Энэ хүмүүсээ зайлуулаач гэхээр ерөөсөө зайлуулдаггүй. Өмнө нь байгаагүй, өмнө нь хаана явж байсан нь бүү мэд, иймэрхүү бүртгэлийн юмнууд зөндөө байгаад байгаа юм. Үүнийг ерөөсөө цэгцэлж чадахгүй байгаа юм. Энэ одоо иргэний бүртгэл дээрээ үүнийг цэгцлэх ёстой юм уу. 2 сарын 1-ээс өмнө Баасандорж оо үүнийг чи цэгцлэхгүй бол болохгүй дээ.

Одоо нөгөө царцаа гээд баахан юм тийшээ зөөгөөд авааччихсан хүмүүсийг нь яах юм. Одоо хүртэл бүртгэлээсээ хасуулаагүй байж л байгаа шүү дээ. Энэ зүйлээ 2 сарын 1-ээс өмнө цэгцэлж авахгүй бол энэ бүртгэлээ цэгцэлж авахгүй бол үүнийг чинь дагаа будилаан гарна шүү. Маш их хэмжээний иргэний үнэмлэхүүдийг аваачаад хурааж авчирч байгаад л бүгдийг нь бүртгүүлээд явдаг шүү дээ, би бие дээрээ. Энэ 2 сарын 1-ээс энэ юмнууд чинь явна шүү. Тийм учраас улсын бүртгэлийн газрынхан, иргэний бүртгэлийнхэн. Энэ дээр онцгой анхаарахгүй бол ялангуяа энэ амьдардаггүй тэнд нь, зөөж аваачаад байгаа, өмнө нь авааччихсан байгаа, одоо хүртэл бидэн дээр амьдрахгүй байгаа мөртөө одоо хүртэл нэр нь байж байдаг. Тэгээд тэр хүмүүс нь ирж саналаа өгөөд байдаг, бүр. Өгөөд сурчихсан. 2, 3 газар очиж өгдөг, хуруундаа тэмдэглэгээ авахгүй болбол. Ийм юмнуудаа зогсоохгүй бол болохгүй шүү. Баасандорж оо үүнийг онцгой анхаарахгүй бол энэ дээр маш их будилаан гардаг. Үүнийг яагаад ч шийдэж чаддаггүй юм. Хэчнээн удаа яригддаг. Миний хувьд бол 2, 3 удаа сонгуульд орлоо. Үүнийг яриад яриад нэмэр байдаггүй юм. Үүнийг 2 сарын 1-ээс өмнө нэг талд нь гаргаж шийдэж аваач гэж би та бүхнээс хүсэх гэсэн юм.

Г.Занданшатар: Улсын Их хурлын гишүүн ийм зөрчил гарсаар байтал одоо хүртэл шийдвэрлээгүй явж байгаа нь хариуцлагагүй байна шүү. Өөрөө хөөцөлдөж, цагдаа, улсын бүртгэлийн газар шалгаж хэрэв үнэхээр тийм ноцтой зөрчлүүд байгаа бол мухарлах хэрэгтэй шүү дээ. За одоо санал хураалт явуулна.

Гишүүд суудалдаа суугаарай. Санал хураалт.

66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Төслийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийн “дараах” гэсний дараа “асуудлыг олонхоороо шийдвэрлэх” гэснийг нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

72,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.10.Эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглоно. Эвсэлд нэгдсэн нам эвслээс гарсан хэдий ч 51 хувиас дээш тооны гишүүд тухайн эвсэлд үлдсэн тохиолдолд уг эвсэл хэвээр хадгалагдана.” Санал гаргасан Улсын Их хурлын гишүүн Лувсанвандангийн Болд.

Баасанхүү, Чинзориг, Мөнх-оргил гишүүнээр тасаллаа.

О.Баасанхүү: За баярлалаа. Үг өгч боломж олгосонд. Миний хэлэх гээд байгаа санаа юу вэ гэх юм бол эвсэл магадгүй 2 байвал 1 нь гарчихвал эвсэл хүчингүй юм байна. 3 байвал нэг нь гараад 2 үлдвэл хэдэн хувь гэж үзэх вэ гэдэг ийм сонин байдал үүсээд байгаа юм. Дээрээс нь эвсэлд нэгдсэн мөртөө аль нэг нам нь дангаараа зардал гаргавал болохгүй гэсэн үг үү. Дээрээс нь дахиад хэлэхэд эвсэл гэдэг чинь нам эвсэж байгаа шүү дээ. Гэтэл эвслээс эвслийн 1 гишүүн, эвсэлд орсон намын гишүүн өөр нам руу орж болохгүй гэсэн үг үү. Би

үүнийг бүр ойлгохгүй болоод байна л даа. Энэ 28.10-ыг дахиж харах хэрэгтэй л гэж хэлмээр байна.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн

С.Чинзориг: Энэ 28.10-ыг Байнгын хороон дээр юу гэж ярьсан юм бол доо. Би бол сайн ойлгоогүй юм болов уу, дараагийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхэд бас анхаарах ёстой юм болов уу. Эвсэлд нэгдсэн нам, эвслээс гарсан хэдий ч 51 хувиас дээш тооны гишүүд тухайн эвсэлд үлдсэн тохиолдолд уг эвсэл хэвээр хадгалагдана гэж. Би эвсэл байгуулна аа гэдэг чинь намууд буюу субъектүүд нэгдэж эвсэж байгуулж байгаа. Энэ чинь бүтцээрээ дамжуулж шийдвэр гаргаж эвэл байгуулж байгаа. Тэгээд шийдвэр гаргаж эвсэл байгуулсан субъект нь эвслээс гарчихаар тэнд хэдэн гишүүн нь үлдчихээр тэр эвсэл хадгалагдана аа гэдэг чинь утгагүй шүү дээ. Зарчим нь буруу байна. Байнгын хороон дээр яг юу гэж ярьсан юм бол.

Би тэр шийдвэр гаргасан нам, субъект л эвслээс гарсан л бол тэр эвсэлд хэдэн гишүүн хашаандаа үлдсэн байна уу үлдээгүй байна уу гэдгээс үл хамаараад энэ эвсэл татан буугдах, байхгүй болох асуудал ярих ёстой шүү дээ, зарчим нь. Гэтэл эвслийн байгуулсан шийдвэр гаргаж, эвсэлд орсон нам нь шийдвэр гаргаад эвслээс гарчихлаа гэхээр тэнд хэдэн гишүүн нь үлдчихээр эвсэл хадгалагдана гэдэг чинь энэ болохгүй шүү дээ. Гишүүд саналаа нэгтгэ эвсэл байгуулаагүй шийдвэр гаргаагүй. Тэр бүтцээрээ дамжуулаад субъект буюу нам гэдэг субъектээрээ дамжуулж шийдвэр гаргаж эвсэлд орж байгаа. Эвслээсээ гарсан бол тэр эвсэл задарна, байхгүй болно, хэдэн гишүүн тэнд үлдсэн үү үлдээгүй юм гэдгээсээ үл хамаараад энэ эвсэл байхгүй болох тухай асуудал яригдана шүү дээ. Үүнийг юу гэж ойлгох юм бэ. Хэрвээ үүгээрээ ингээд гишүүд дэмжээд явчих юм уу. Эсвэл унагаад яах юм уу. Үгүй бол Байнгын хороо дахиж ярих юм уу. Энэ чинь эвсэл байгуулсан тэр бүтэц нь шийдвэр гаргасан бүтэц нь субъект нь гарч байхад хэдэн гишүүн үлдсэнээрээ гээд эвсэл хадгалагдаж байж болохгүй ээ.

Тийм учраас энэ зарчмыг дахиж ярих ёстой байх. Энэ санал хураах юм уу, үгүй бол санал хураагаад унагах юм уу. Эсвэл энэ чигээр нь санал хураахгүй үлдээгээд Байнгын хороо нь дахиж ярих юм уу. Зарчим нь болохгүй байна. Би бол бүтцийн баг бүтцээр нь дамжуулж нэгдэж байгуулж байгаа болохоос биш гишүүд нэгдэж эвсэл байгуулаагүй учраас энэ ойлгомжгүй заалт байна.

Г.Занданшатар: Мөнх-Оргил гишүүн

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Өргөн барьсан хуулийн төслийн 28.10 нь ойлгомжтой байгаа юм л даа. Эвслийн аль нэг нам нь дангаараа нэр дэвшүүлээд юм уу зардлаа дангаараа гаргаад эсвэл өөр эвсэлд нэгдээд ингээд явчих юм бол хориглоод ийм үйлдэл хийх юм бол эвсэл задарсанд тооцно гээд их ойлгомжтой заалт байгаа байхгүй юу.

Одоо ингээд өөрчлөн найруулаад ороод ирэхээр дангаараа дэвшүүлж болохгүй, дангаараа зардал гаргаж болохгүйг хориглоно гэххээд хэзээ үүний үр дагавар ойлгомжгүй байгаа юм. Хориглохгоод ямар санкцтай юм ойлгомжгүй, тэгээд эвсэл хэзээ задарсанд тоох вэ гэхээр нэг нь гараад явчихсан ч гэсэн эвсэлд үлдэж байгаа намуудын нийт гишүүдийн 51-ээс дээш нь үлдчихвэл гэхээр энэ их маргаан дагуулна аа. Үүнийг эцсийн хэлэлцүүлгээр өнөөдөр чиглэл авдаг юм уу яадаг юм эцсийн хэлэлцүүлэг янзлахгүй бол гишүүдийн тоо гээд хэн тэрийг нь

гаргаж ирэх юм, тэрийг нь тоолоод нэлээн ажил болох юм болов уу гэж бодоод байгаа юм. Би тэгээд Болд гишүүн ийм санал гаргаад байгааг санааг нь ойлгоод байгаа юм. Дэмжихэд ч бэлэн байгаа юм. Тэгэхдээ томьёолол нь биш байна аа. Гишүүдийн 51-ээс дээш гэдэг чинь бол ядаж намуудын 51 байдаг юм уу, иймэрхүү л юм бодохгүй бол хэдүүлээ сонгуулийн дараа нөгөө сонгуульд эвсэж орсон нам чинь хэдэн гишүүнтэй үлдчихэв, хэд байсан, гээд, тэр нь мөн ч юм уу, хэдийг дэвшүүлсэн юм гээд бөөн утга учиргүй төгсгөлгүй хэрүүл болох нь ээ.

2 дугаарт эвсэл болж орж байгаагийн ол ач холбогдол нь иргэд сонгогчид тэр эвсэлд санал өгч байгаа байхгүй юу. Тэр эвсэлд нэгдэж орсон намуудад. Хэн нэг нь байхгүй болчихоор тэр эвсэл байх уу үгүй юу гэдгийг бид нар бас бодож үзэх хэрэгтэй юм. Яагаад гэвэл сонгогчдод бид нар эвслийг л танилцуулсан байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлуудыг бодолцоод Их Хурлын дарга чиглэл өгвөл үүнийг эцсийн хэлэлцүүлэг дээр яримаар юм байна. Энэ ажлын хэсгийн санал биш шүү гэдгийг гишүүдэд анхааруулах гэсэн юм.

Г.Занданшатар: Лувсанвандангийн Болд гишүүн

Л.Болд: Санал болбол миний нэрээр байгаа. Гэхдээ энэ миний санал биш л дээ. Энэ бол ажлын хэсэгт нэг саналаар санал хураалт нь будилаантай явагдаад дараа нь яах вэ Байнгын хороон дээр зөвшилцөөд энэ саналыг оруулсан юм. Энэ санал хэний санал гэхээр энэ чинь улс төрийн бүртгэлтэй 23 нам бүх саналуудаа нэгтгэж байгаад 5 санал өгсөн юм.

Ер нь сонгуульд оролцох, намуудад эвсэх бололцоог нь олгох, намууд энэ сонгуульд тэгш эрхтэй бололцоотой оролцох гээд олон санал өгсөн. Хяналтын тооллого хийх гээд. Бүгдийг нь унагаасан. Бүгдийг унагаагаад ганцхан энэ саналыг авъя гээд ингээд Байнгын хороон дээр шийдсэн юм. Тэгээд яах вэ та нар өөрсдөө л мэд. Та нар дангаараа гаргасан хууль боллоо шүү. Уул нь улс төрийн намууд нийлээд 23 нам тамга тэмдгээ дараад хамт хуралдаад ажлын хэсэг гаргаад яах вэ энэ саналыг дэмжээд ямар ч байсан энэ хуульд намуудын санал тусч байгаа. Энэ бол зүгээр нэг эрх баригч нам дангаараа өөрсдөө хүчээр түрж бүгдийг мэдэж, бүхнийг захирч эрдэж бардаж хийсэн ийм хууль биш ээ. Улс төрийн намуудтай зөвшилцөж, уулзаж ярилцсан юм. Тэгээд 20 гаруй саналаасаа бүгдийг нь татаад ерөөсөө олон санал хэрэггүй, ерөнхийдөө зарчмын гээд 5 санал гаргасан. Түүний 4-ийг нь унагаасан. Ганцхан энэ санал Байнгын хороон дээр дараа нь ярьж байгаад авч үлдсэн юм аа.

Та нар улс төрийн өндөр соёл гаргаад би бол үнэхээр 100 жилийнхээ ой дээр 30 хүрэхгүй настай 20 гаруй намуудыг үгүй хийгээд байх хэрэггүй байх гэж бодож байна. Тэд нарыг зүгээр эвсэх бололцоог нь олгоод тэртэй тэргүй тийм ээ, сонгогчид л саналаа гаргана. Өнөөдрийг хүртэл заавал энэ эвслийг хориглосон тийм заалттай сонгууль чинь сайн зөв сонгууль биш, их бутарсан үнэхээр ард түмэн сонголтоо хийх, маш их будилаантай. Энэ дээр би улс төрийн соёл гаргаасай л гэж бодож байна. Бүгд харж байгаа. Телевизээр харж байгаа. Үнэхээр 64 суудалтай 100 жил болсон том нам өнөөдөр нам дээрээ яриад зохицсон хэлсэн амандаа хүрдэг юм уу үгүй юм уу гэдгийг л харж байгаа. Энэ бол тийм хортой юм биш, тэр гишүүд гэдэг гишүүд биш шүү намууд гэж байсныг ажлын хэсэг Тамгын газар буруу болгосон байна. Намууд шүү, Мөнх-оргил гишүүн ээ. Таны хэлж байгаа маш зөв. Гишүүдийн асуудал биш, үндсэн томьёоллыг нь үз. Эцсийн хэлэлцүүлэг дээр Их Хурлын дарга ч хэлчих. Тэр үндсэн томьёоллыг нь үзээрэй. Үндсэн томьёолол дээр нь бүр гараараа биччихсэн намууд гэж байгаа шүү. Энэ

бол сонгуульд оролцох намуудын эвслүүдийн л асуудал байгаа. Түүнээс бол сонгуулийн дараах гишүүд гэдэг асуудал байхгүй. Гишүүд гэдэг бол тусдаа хуулиараа тусдаа зохицуулагдаад явдаг. Тийм учраас сонгуулийн хууль ярьж байгаа учраас ажлын хэсэг дээр эргээд нягталж болно.

Г.Занданшатар: Болд гишүүн өөрөө л бичиж өгсөн санал байгаа л даа. Тэгэхээр намууд гэж ойлгоорой л гэж бид ойлгох юм уу. Хэрвээ дэмжигдвэл эцсийн хэлэлцүүлэг дээр Болд гишүүний саналаар нь найруулахыг анхаарах юм байна.

Тэгэхдээ энэ найруулгыг нь сайн анхаарах хэрэгтэй юм байна. Санал хураалт. Гишүүд суудалдаа суугаарай. Санал хураалт. Нямбаатар, Мөнх-Оргил гишүүн 2 суудалдаа суучих. Санал хураалт.

Эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай. Найруулга. Иргэдийн эвлэлдэн нэгдэх, эвсэх, сонгох, сонгогдох Үндсэн хуулийн эрх чөлөөнд хөндөхгүйгээр энэ заалтыг эргэж харахыг чиглэл болгоё.

19.Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.1 дэх заалтын “шүүхийн” гэснийг “шүүх болон арбитрын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Баасанхүү гишүүн дэмжсэн дэмжээгүй үг хэлнэ.

О.Баасанхүү: За баярлалаа. Хэдийгээр би ажлын хэсэгт орсон ч гэсэн тэр арбитр гэдэг үгийг би бол дэмжээгүй юм аа. 1 дүгээрт. 2 дугаарт гэвэл үнэхээр та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Эвсэнэ гэдэг бол 50-аас дээш хувь нийлээд эвсэх байсан. Гэтэл одоо яах вэ дээ ингээд эвсэж нийлээд бөөнөөрөө нэг баг болчих вий гэдэгт үхтлээ айж байгаа юм байна л даа. Тийм учраас би Их Хурлын даргаас 1 л хүсэлт байна. Тэр нь юу вэ гэх юм бол ядаж 51 нь үлдвэл эвсэл хүчинтэй гэхгүй бол төрөөр тоглодогтой л адил болно шүү гэдгийг би онцолж хэлэх гэсэн юм. Барлалаа.

Г.Занданшатар: Тэр заалт өнгөрсөн. Тэр заалтыг эцсийн хэлэлцүүлэг дээр Үндсэн хуулийн тэр эвлэлдэн нэгдэх, сонгох сонгогдох эрхийг хязгаарлахгүйгээр 51 хувиас дээш гэнэ үү түүгээрээ анхаараарай гэж чиглэл өгчихсөн шүү дээ. Санал хураалт явуулъя.

Санал хураалтдаа хариуцлагатай оролцоно шүү.

Энэ санал уналаа. Санал хураалтдаа идэвхтэй оролцоцгоо. Хэдхэн санал дээр суугаад хариуцлагатай оролцчихооч, гарч орж гүйцгээгээд байх юм.

Эцсийн хэлэлцүүлэг дээр шүүх, арбитрын агуулгыг судалж үзэхийг чиглэл болгож байна.

20.Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.3, 30.4.4 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.2.6, 33.3.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Төслийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.7.Гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

58,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 30 дугаар зүйлийн 30.8 дахь хэсгийг нэмэх:

“30.8.Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, О.Баасанхүү.

За Аюурсайхан, Баасанхүү гишүүн үг хэлнэ.

Т.Аюурсайхан: Өмнө нь сонгуулийн тухай хуульд ялгүй байх гэж байгаа юм, нэр дэвших шаардлага нь. Одоогийн Эрүүгийн хуулиар ялтай гэдэг ойлголт бас ялгүй байх, ялтай байх ийм ойлголт байхгүй болсон. Тийм учраас энэ гэмт хэрэг үйлдсэн хүмүүс дээр нэн ялангуяа авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, тэр нь шүүхээр тогтоогдсон хүмүүсийн хувьд нэр дэвших хязгаарлалт байх ёстой гэж үзэж байгаа юм. Үүнийг бол үндсэн хууль зөрчихгүй гэж үзэж байгаа юм. Хуульчид бас ингэж тайлбарлаж байгаа юм.

Аливаа эрх, үүргийг эдлэхдээ тэр эрх эдэлж байгаа хүмүүс үүргээ хүлээдэг байх хэрэгтэй. Төрийн албан хаагчдыг сонгуульд оролцуулахын тулд тодорхой хугацааны өмнө ажлаас нь чөлөөлүүлдэг нөхцөл байдал чинь бас сонгох, сонгогдох эрхийн асуудал байгаа боловч энэ төрийн албыг улс төржилтөөс ангижруулахын тулд төрийн албаны тухай хуульд заасан шаардлага үндэслэл байгаа юм аа. Нэр дэвшигч өргүй байх ёстой. Гэтэл сонгох, сонгогдох эрх ярих ёстой байтал мөн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байж, эрхээ эдлэх ийм зарчим бас үйлчлэх ёстой.

Нэн ялангуяа авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон хүний нэр дэвшихийг хориглох ёстой. Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой шүүхээр маш олон хүмүүс ял завшаад байгаа юм. Би түрүүн хэлж байсан. ЖАСТ-ын Батхүү, Бат-Үүл гуайн хувьд асуудал яригдаад байна. Хөгжлийн банк, бондын Гарамгайбаатар, Нямжавын Батбаяр, Дэнзэн, Дорлигжав, цаашлаад Золжаргал, Баярцогт, Элбэгдорж, Баяр, Сайханбилэг гээд явах нь л дээ. Хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан гэдэг асуудлыг бид нар өнөө маргаашгүй хуулийн өөрчлөлтөөрөө засна аа.

Хөөн хэлэлцэх хугацааны тоолуурыг дахин 2017 оноос эхлээд тоолох энэ асуудлыг хуулийг хэрэгжүүлэх журмын тухай хуулиараа шинэчлэн тогтоож өгнө өө гэдгийг манай Хууль зүйн байнгын хорооны дарга маань санаачлаад явж байгаа. Үүнийг шийднэ.

Шүүх дээр энэ хөөн хэлэлцэх хугацааны улмаас энэ хүмүүсийг зөвхөн эрүүгийн хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэсэн байгаа юм. Харин гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд нь тооцсон ийм шийдвэр гаргасан байгаа юм. Тэгэхээр шүүхээр ял авсан гэх юм бол хөөн хэлэлцэх хугацаагаар завшсан хүмүүс нь завших гээд байгаа учраас шүүхээр тогтоосон байхад бол хангалттай гэж үзэж байгаа юм.

Зарим хүмүүс болохоор надаас айгаад ийм заалт оруулах гээд байна аа гэдэг юм яриад байгаа. Хэн нэгэн хүн зориулахгүй ээ энэ хуулийг. Зөвхөн урд өмнө нь шүүхээр шийдэгдсэн ял авсан хүмүүс байж болно, дээрээс нь хөөн хэлэлцэх хугацаагаар ял завшсан боловч гэм буруутайг нь шүүхээр тооцсон хүмүүсийг бас нэр дэвшүүлэх ёсгүй ээ гэж үзэж байгаа юм аа.

Энэ улс төрийн өөрийнхөө нам дотроо байгаа ч гэсэн энэ парламентын суудалд байгаа ч гэсэн хэн нэгнээс нь бяртай чадалтай гэдгээр нь айгаагүй мөртөө парламентын гадна бусад нам байгаа энэ хүмүүсээс айгаад нэг хүнийг оруулахгүй байхын тулд ингэж заалт оруулж байгаа юм огт байхгүй ээ. Энэ бол зарчим байх ёстой. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдээд шүүхээр тогтоосон мөртөө заавал яагаад төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоох цорын ганц байгууллагадаа яагаад заавал орох гээд байгаа юм. Бусад ажил албан тушаал эрхлэх зөндөө боломж байгаа. Хуулийн эрх нь байгаа. Үндсэн хуульд заасан эрх нь байгаа. Тийм учраас Байнгын хороон дээр дэмжигдсэн саналаа бас гишүүд дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Би төрийн албаны тухай хууль дээр байдаг зарчмаар өнөөдөр Монгол Улсын төрийг тэр дундаа хууль тогтоох байгууллагыг цэвэр ариун байлгах ёстой гэж боддог. Хуулиа биелүүлэхийн тулд эмэгтэйчүүд эрхээ эдэлье гэвэл 20 байна уу 30 байна уу түүнийгээ аваг. Эрхээ эдлэхийн тулд өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 25-аас дээшгүй бол ядаж 2 юм уу 3 байг гэвэл ядаж тэр хэлбэрийг нь тогтоогоод 3 юм уу 4 хүн нэр дэвшиг. Түүн шиг өнөөдөр юу вэ гэх юм бол төрийн албаны тухай хууль дээр авлига, албан тушаалын хэргээр ял эдэлбэл оруулахгүй гэдэг заалтыг би сонгосон.

Харамсалтай нь үүнийг улс төржиж миний яриад байгаа заалтыг тухайлбал Нямбаатараас эхлээд Баасанхүү гишүүн намын даргынхаа эсрэг энэ тэрээ гэдэг мессежийг Оюунбаатарт өгсөн байна лээ. Тэгэхдээ би нэг л зүйлийг баталгаатай хэлье.

Хувь хүнд зориулж би юу ч хандаагүй ээ. Эрдэнэ гээд одоо энэ хүнд зориулж хүртэл хүн амины хэрэг гээд зөвтгүүлж байгааг ч гэсэн би эсэргүүцэж байгаа. Яагаад гэвэл зарчим бол хүнд зориулдаггүй. Зарчим бол үйл ажиллагаанд зориулдаг. Тэгээд би юу гэж хэлж байгаа гэвэл Оюунбаатар байна уу Нямбаатар байна уу Эрдэнээ байна уу хамаагүй. Өнөөдөр нэг л зарчим үйлчлэх ёстой. Хууль хүн болгонд тэгш үйлчлэх ёстой. Тэр утгаараа өнөөдөр төрийн албаны тухай хууль үйлчилж байна уу үгүй юу гэсэн Аюурсайхан ийм хуулийг биелүүлье гээд санал оруулсан бол би саналаа татсан. Протоколд удаа дараа байсан. Харамсалтай нь Их Хурлын дарга, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд 3 нийлээд зориуд миний нэрийг хутган үймүүлж оруулж байгаа. Би өөрийнхөө саналыг татлаа гэж хэлээд байхад Аюурсайхантай хамт. Одоо Аюурсайханаас асуу та нар. Аюурсайхантай хамт өргөн барьсан уу үгүй юу гэж. Би тэгж өргөн бариагүй. Би хувиараа төрийн албаны тухай хуулийн зарчмыг биелүүлье гэдэг санал тавьсан. Тэгээд өнөөдөр Аюурсайхан санал тавьсан. Тэгээд Аюурсайханы санал дэмжигдэж байвал Аюурсайханаараа явуул аа. Би бол саналаа татаж байна. Ийм л зүйл хэлэх гэсэн юм.

Г.Занданшатар: За одоо санал хураалт явуулна аа. Пүрэвдорж гишүүн үг хэлнэ

Б.Пүрэвдорж: Аюурсайхан гишүүн ээ. Нямбаатарт ч гэсэн хэлчихье. Ер нь бол аль аль нам дотор нь бол бүтэлгүй улсууд маш их бий. Би бол энэ Их хурал дээр та бүхний энэ ёс зүйгүй увайгүй ийм үйлдлийг шүүмжилдэг. Энэ бол миний тэмцлийн 50 хувь гэж ойлго. 50 хувь нь би тэр нам дотроо бас болохгүй бүтэхгүй манай намыг бас асуудалтай болгож байгаа тэр хүмүүстэй тэмцдэг. Тэр хүмүүс хэрвээ асуудал гаргаад хэрэг зөрчил хийсэн бол тэр хүмүүс явах газраа явах ёстой байсан. Харамсалтай нь та нар өнөөдөр хөөн хэлэлцэх хугацаа гэж яриад, түүгээрээ баахан Ардчилсан намын хүн гарчихлаа гэж ярьж байна. Үүнийг та нар өөрсдөө хийчхээд

Г.Занданшатар: Хөөн хэлэлцэх хугацаа эрүүгийн хууль дараа хэлэлцэнэ. Тэр үеэр ярь.

Санал хураалт явуулна. Санал хураалт.

54,5 хувин саналаар энэ санал дэмжигдлээ.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсан, гараагүй гэсэн маргаан байгаа учраас цэцийн дүгнэлтийг тулгаж эцсийн хэлэлцүүлэгтээ шалгаарай гэсэн чиглэл өгч байна.

23 дугаар зүйлээр санал хураалт явуулна.

23.Төслийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “маягтад” гэсний дараа “тухайн сонгуулийн тойргийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

65,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2.9, 33.3.11 дэх заалтын “эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх талаарх Цагдаагийн ерөнхий газрын” гэснийг “ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Пүрэвдорж, Баасанхүү гишүүнээр тасаллаа. Түрүүний заалт дээр бол эрүүгийн хариуцлага хүлээж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно гэсэн хуучин төслийн заалт нь. Түүгээрээ үлдчихээд байгаа юм.

Б.Пүрэвдорж: Түрүүний тэр авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийг нэр дэвшүүлэхийг хориглоно гэдэг заалт дээр би хэлье гэж бодож байна.

Г.Занданшатар: Түрүүний заалтаар үг хэлэхгүй. Одоо энэ заалтаар л үг хэлнэ. Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Би нэг юм ойлгохгүй байна аа. Занданшатар гишүүн ээ. Шулуухан хэлье л дээ. Та ингээд үг хэлэхээр таслаад, битгий тэг л дээ, тэгэх үү. Бас 5-хан минут шүү дээ. Та нар 5, 5-аар авахад 50 минут шүү дээ. Яах вэ дээ 5 минут тэс л дээ. Манай ардчилалд 1 дүрэм байдаг. Ямар дүрэм байдаг гэвэл танд таалагдахгүй үг хэлж болно. Тэгэхдээ таны үгийг нээснээр би ардчилагч гэдэг юм. Танд таалагдахгүй үг хэлж болно. Гэхдээ ард түмэн түүнийг сонсож байгаа шүү дээ. Энэ яриад байгаа асуудлаа та бод л доо. Миний яриад байгаа зарчмын

зөрүүтэй саналуудыг мушгин гуйвуулж улс төр хийхээ боль л доо. Би 3 санал тавьсан. Жишээлбэл энэ дээр эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх талаарх гэж байгаа бол сэтгэцийн эмгэгийг үзэх талаар яагаад байж болдоггүй юм. Яагаад гэвэл Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшиж байгаа хүний сэтгэцийг шалгадаг л юм байна лээ шүү дээ.

Тэгсэн хэр нь Их хурлын гишүүн яагаад болдоггүй юм. Өнөөдөр цагдаа дээр очоод та нар 65-уулаа гүйж очоод лавлагаа авах байх л даа. Би ял аваагүй, би шалгуулаагүй гээд. Угаасаа наад Оюун-Эрдэнийн чинь бууны нохой тэр АТГ-ийн дарга хийгээд сууж байгаа шүү дээ. Тийм учраас тийм ээ тийм ээ гээд л өгөх л байх л даа. Түүнээс биш 49

Г.Занданшатар: Энэ заалтаа уншвал эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх талаарх цагдаагийн ерөнхий газрын гэсэн төслийн заалтыг ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гэж тус тус өөрчилж байна.

Чимэдийн Хүрэлбаатар гишүүн

Ч.Хүрэлбаатар: Би саналаа хэлчихмээр байна. Энэ сонгуулийн ерөнхий хороо энэ мэдээллийг өөрсдөө авчхаж болдоггүй юм уу. 1 төрийн байгууллагаас нөгөө төрийн байгууллага руу мэдээлэл зөөдөг ийм ажлыг ер нь бүх газар дээр зогсоомоор байна шүү дээ. Иргэний мэдээлэлтэй холбоотой зүйлийг төрийн нөгөө байгууллага нь зайлшгүй нэхдэг, энэ баахан чирэгдэл авчирдаг. Тэгэхээр 1 төрийн байгууллага нь нөгөө төрийн байгууллагаасаа мэдээлэл шаардаж байгаа тохиолдолд түүнийг хоорондоо яриад авчихдаг ийм л баймаар байх юм. Нэг.

Хоёр дугаарт нь ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэж одоо 1 мэдээллийг бүр 2 байгууллагаас гүйж очиж авах болж байгаа юм уу. Тэгэхээр эрд нь 1 байгууллагаас авдаг байсныг бүр 2 болгоод хүндрүүлчхэж байна л даа, зүгээр төрийн байгууллага өөрөө өөрсдөө хоорондоо СЕХ нь мэдээллээ шалгаад авчхаж болдоггүй юм уу гэдэг ийм зүйлийг хэлж байна, асууя, тодруулъя.

Г.Занданшатар: Бүрдүүлэх материал дээр СЕХ өөрөө бүрдүүлчхэж. За санал хураалт. Гишүүд үг хэлж дууслаа.

Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа л гэж байгаа шүү дээ, уул нь төсөл дээрээ. Цагдаагийн төв байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын гэж. Үүнийг нягталж үзмээр байна. Хэлэлцүүлэг дээр чиглэл өгч байна. ЦЕГ-ын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа гэж байгаа байхгүй юу. Эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх талаарх ЦЕГ-ын мэдээллийн сан хариуцна гэж байгаа. Ажлын хэсэг.

Энэ заалтыг эцсийн хэлэлцүүлэг дээр СЕХ шууд жагсаалтыг нь гаргаад авчихдаг, өөрөө лавлагаа авах боломжийг, 2 дугаарт энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллага дээр лавлагааны нэгж байхгүй, мэдээллийн сан байхгүй гэж байна. Энэ бүхнийг нягтлахыг чиглэл болгож байна. Санал хураалт явуулъя.

Энэ дэмжигдчихлээ. Гэхдээ өмнөх заалтуудтай холбогдуулж үүнийг эцсийн хэлэлцүүлэг дээр хуульд нийцүүлж хянаж үзэхийг чиглэл болгож байна.

Дараагийн санал хураалт явна аа.

25.Төслийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “600” гэснийг “200” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 40.2.8 дахь заалт нэмэх:

“40.2.8. Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцъё. Хүчингүйд тооцлоо.

Баасанхүү гишүүн үг хэлнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай, заалттай холбогдуулж дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ шүү.

О.Баасанхүү: Энэ өдөр тутмын гэдэг дээр юу гэж хэлж байгаа вэ гэвэл сүүлийн 12 сар гэж байгаа юм. Өдөр бүр биш. Сүүлийн 12 сар тогтмол сард 1 байна уу, 2 сард 1 байна уу ойлгомжгүй байгаа байхгүй юу. 1 дүгээрт.

2 дугаарт би юу гэж хэлж байгаа вэ гэвэл, дахиад хэлэхэд дундаж мөнгөөд гээд удахгүй ороод ирнэ л дээ. Сайт нь бас ойлгомжгүй байгаа юм.

3 дугаарт нь би юу гэж хэлэх гээд байгаа вэ гэвэл өнөөдөр томсгосон тойргоор явж байгаа болохоор мэдээж ЖДҮ-чид, 60 тэрбумчид бол баярлаж байгаа байх л даа. Мань мэт шиг бол хэцүү. 70, 80 мянган хуудас тараагаад гаргахад маш хэцүү. Нямбаатар аа би чамд зориулж хэлж байгаа юм. Чи 2 байшин босгосон хүн шүү дээ. Тийм учраас би та нарт ганцхан зүйл хэлж байгаа юм.

Өнөөдөр хэзээ ч энэ гаргаж байгаа үнийн дүнг, жишээлбэл манай эрүүгийн хуульд байгаа шүү дээ. Юу гэж хэлж байгаа гэвэл үндэслэлгүй хөнгөжих гэж ойлголт байдаг шиг энэ гаргаж байгаа үнийн дүнгээ тодорхой болгох ямар нэгэн тайлан баталгаажуулах хэрэгтэй байна аа. Хэрвээ тэгэхгүй бол өдөр тутмын байна уу, эсхүл сайт байна уу энээ тэрээ сурталчилгааны материалаа хэвлүүлээ ч гэсэн авч байгаа санхүүжилт, өгч байгаа зардал ойлгомжгүй байхаар мөнгөтэй нь мөнгөгүй рүүгээ яваад энэ томсгосон тойрог дээр зөвхөн мөнгөтэй хүмүүс өрсөлдөх болчих гээд байна. 70 мянган хүнд, жишээлбэл та нар бод доо, 1000 төгрөгөөр юм тараая. Тэгээд 70 мянгаар үрж дээ. Хэд байх уу. Аймшигтай тоо гарна шүү дээ. Тэгээд өнөөдөр цаашаагаа явна.

Зөвхөн 1 уучлаарай, би энд нэр дэвшиж байна аа гээд хэлэх үг шүү дээ. Тэгэхээр сонинд хэдийг өгөх үү. 1000 төгрөгөөр биш өөр тоо гарна. Энэ тоогоо дахиад 70 мянгаараа үржүүлнэ. Яагаад гэвэл томсгосон тойрог дээр 1 хүн байна уу 2 хүн байна уу 10 хүн байна уу өрсөлдлөө гэж байгаа бол дахиад би дэвшиж байна аа гэхгүй бол жишээлбэл ялангуяа манай Ардын намын нөгөө гарууд чинь юу гэвэл өө, Баасанхүү чинь дэвшээгүй шүү дээ, больчихсон шүү дээ, өөрөө татгалзсан шүү дээ гээд материал ирээгүй газрууд дээр тоглолт хийх боломж байж байгаа байхгүй юу. Би ямар бүх хүн дээр очиж чадахгүй шүү дээ. Тийм учраас энэ

өдөр тутмын болон сонин сэтгүүлд юм өгөх гэдэг ойлголтыг бид дахиад эргээд харах ёстой.

Тийм учраас битгий ах дүүгээрээ бөөрөлхөөд байгаарай. Нямбаатар аа, би чамд хэлж байна шүү.

Г.Занданшатар: Энэ 40.2.1 дээрээ тодорхойлсон 40.2.1-тээ багтаж байгаа шүү дээ, уг нь энэ. Сонгуулийн сурталчилгааг дараах арга хэлбэрээр явуулна гэдэг дээр. Орхиогүй ээ, 40.2.1-ээ харахгүй юу даа. Сонин тараах, сонин сэтгүүл, ухуулах хуудас гэж байгаа. Санал хураалт явуулъя.

60,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “хоёроос” гэснийг “дөрвөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

28.Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.3.Ухуулах хуудас болон зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт үнэ төлбөргүйгээр байрлуулах байршлыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

29.Төслийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийг “Энэ хуулийн 42.3-т заасны дагуу тогтоосон байршлаас өөр газарт зурагт самбар болон ухуулах хуудас байршуулахыг хориглоно.” Гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Хүрэлбаатар гишүүн үг хэлнэ.

Ч.Хүрэлбаатар: Сая бид нар санал хураагаад санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тогтоож нийтэд мэдээлнэ гэсэн байж байгаа. Тэгэхээр хэн нь гэсэн нэр дэвших нь тодорхойгүй байх үед энэ шийдвэр гарах нь байна шүү дээ. Үүний дараагаар яг нэр дэвшилт явагдаад эхлэхэд аль түрүүлж хандсан хүмүүс нь түүгээ аваад явчих байх. Гэтэл ямар нэгэн шалтгаанаар хамгийн сүүлд нэр дэвших боломж нь шүүхээр ч юм уу СЕХ-оос шийдвэр гараад ороод ирсэн хүнд бол самбар олдохгүй. Тэгээд жигд бус нөхцөлд орчих юм биш үү. Тэгэхээр ингэж хориглох нь зөв үү гэдэг л ийм асуудал байна.

Г.Занданшатар: Энэ чинь нөгөө хашаа байшин, хашаа хайс гэрлийн шонд үнэ төлбөргүй байршуулж болно гэсэн заалтыг л. За, санал хураалт явуулъя.

68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

30.Төслийн 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсгийн “Ухуулах” гэснийг “Нэр дэвшигч нь ухуулах” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

31.Төслийн 42 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 42.14 дэх хэсэг нэмэх:

“42.14.Энэ хуулийн 40.2.8-д заасан сонин, сэтгүүл нь сүүлийн 12 сарын турш тогтмол гарсан байх бөгөөд түүнд нийтлүүлэх сурталчилгааны төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн үнийн дунджаас хэтрэхгүй байна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

70,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төслийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.8, 43.9 дэх хэсгийн “самбарыг” гэснийг “самбар, дэлгэцийг” гэж өөрчлөх Санал гаргасан ажлын хэсэг.

72,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

33.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн "ухуулах байр," гэсний дараа “сонгогчидтой хийх уулзалт, хурал цуглааны танхимд,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

70,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

34.Төслийн 45 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.6 дахь хэсэг нэмэх:

“45.6.Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт, арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Арга хэмжээ гэдгийг эцсийн хэлэлцүүлэг дээр хасах хэлэлцэх чиглэл өгөөд явуулчих уу. Тэгээд санал хураалт.

Арга хэмжээ гэдгээ тодотгож, сонгуулийн хуулиар хориглоогүй арга хэмжээ гэж зааж өгөхгүй бол ийм санал бас Ардчилсан намаас яриад байна лээ. Түүнийг харгалзан үзэх нь зүйтэй гэж байна. Сонгуулийн хуулиар хориглоогүй арга хэмжээ гэж найруулах чиглэл өгье.

35.Төслийн 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.8.Сурталчилгааны нэвтрүүлгийн төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна. Үүнтэй холбогдуулан төслийн 47 дугаар зүйлийн 47.9.2 дахь заалтын “сүүлийн зургаан сарын” гэснийг “ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

69,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энэ санцгүй гэдгийг хэн тогтоох юм, яаж хянах юм, өндөр нам гэдгийг нь

яаж нотлох юм. Тэгээд хариуцлагаа яаж тооцох юм гэдэг л байх.

Энэ санал 69,4 хувиар дэмжигдсэн. Одоо 36 дугаар санал.

36.Төслийн 47 дугаар зүйлийн 25 дахь хэсгийн “47.2,47.5-47.8, 47.11-47.19-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

37.Төслийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“48.5.Энэ хуулийн 48.1.3-т заасан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт.

75,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

38. Төслийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.7.Энэ хуулийн 36.3, 48.4-т заасныг зөрчсөн талаарх гомдлын дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн дараах арга хэмжээг нэн даруй авна:” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

77,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

39.Төслийн 48 дугаар зүйлийн 48.8 дахь хэсгийн “Интернетийн” гэсний өмнө “Үүрэн холбооны болон” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт.

75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

40.Төслийн 48 дугаар зүйлийн 48.9 дэх хэсгийн “хороо” гэснийг “хорооны саналыг үндэслэн Сонгуулийн Ерөнхий хороо” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

70,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41. Төслийн 48 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 11 дэх хэсэг нэмэх:

“48.11.Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл авч болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

42.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “аливаа этгээд” гэсний дараа “өөрөө болон бусдаар дамжуулж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Энэ 49 дүгээр зүйлтэй заалттай холбоотой би хэлэх гэсэн юм аа. Энэ ажлын хэсгийнхэн анхаараадхаач. Энд маш ноцтой 1 өгүүлбэр миний бодлоор орчхоод байх шиг байх юм. Засахгүй бол болохгүй. 49.1 гэж байгаа юм. Одоо сонсож байгаарай. Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал гэж байгаа. Нөхөн ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гаргаснаас хойш санал авах өдрийг дуустал гэж байгаа. Аливаа этгээд сонгуулийн сурталчилгаа хийх, сонгогчдын саналыг татах зорилгоор дараа дараа гээд дараах хуралд явуулахыг хориглоно гэж байгаа юм.

Сонгогчдын саналыг татах зорилгоор үйлдвэл ойлгомжтой, биччихсэн. Сонгуулийн сурталчилгаа хийх гэдэг наад өгүүлбэр чинь шал утгагүй юм болгоод хаячихлаа. Өөрөөр хэлбэл дараа жил эхлэнгүүт сонгуулийн санал авах өдөр хүртэл сонгуулийн сурталчилгааг хийх гэдгийг чинь хаагаад хаячихлаа шүү дээ. Ажлын хэсэг дээр ч бид нар анзаарсангүй. Тэгэхээр энэ дээрээс тэр сонгуулийн сурталчилгаа хийх гэдэг үгийг аваад сонгогчдын санал татах зорилгоор ийм ийм үйл ажиллагаа гэдгийг нь үлдээгээд тэр сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно гэдэг бол сонгуулийн үеэр сонгуулийн сурталчилгаа хийж болохоо больчихлоо шүү дээ. Тийм байгаа биз.

Одоо энэ чинь бол би та нарт хэлье. 49.1 тэгэхээр үүнийг хасахгүй бол болохгүй. Энэ үгийг. Наад чинь буруу болчихлоо. Сонгогчдын саналыг татах зорилгоор үйлдүүлбэл хориглох нь ойлгомжтой. Жагсаасан. Тэгэхээр би хурлын даргыг үүнийг анхаарч үзээд энэ дээр Байнгын хорооны хуралдаан дээр энэ зүйлийг засаж найруулгын хувьд зөв болгохгүй бол наадах чинь ерөөсөө сурталчилгаагүй сонгууль болно гэсэн үг байхгүй юу. Баярлалаа.

Г.Занданшатар: Аливаа этгээд гэдгийг өөрөө болон бусдаар дамжуулж гэдгийг бол дэмжиж байгаа. Тэгээд сонгуулийн сурталчилгаа хийх гэдэг үг санал авах өдөр хүртэл сурталчилгаа хийхийг хориглоод хаячхаж байна шүү дээ. Найруулж үнийг сонгуулийн сурталчилгаанаас бусад хугацаанд ч гэдэг юм уу найруулахгүй бол ноцтой алдаа байна шүү. Сонгуулийн ерөнхий хороо. Чиглэл өгч байна аа. Эрдэнэбат гишүүний саналыг харгалзан үзэж найруулахыг чиглэл өгч байна. Санал хураалт.

67,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

43.Төслийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “гурван сая” гэснийг “таван сая” гэж, “арван таван сая” гэснийг “хорин сая” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

68,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

44.Төслийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“55.2.Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан энэ хуулийн 55.1-т заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хандив өгч болно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

70,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45. Төслийн 57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

71,7 хувиар санал дэмжигдлээ.

46. Төслийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.1.Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

46 гишүүн оролцож 30 гишүүн зөвшөөрч 65,2 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

47.Төслийн 63 дугаар зүйлийн 63.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“63.13.Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байруудад хяналтын камер байрлуулж болно. Хяналтын камерыг сонгогчийн саналаа нууцаар гаргах эрхэд саад учруулахгүйгээр байрлуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Батзандан гишүүн.

Ж.Батзандан: Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байруудад хяналтын камер байрлуулж болно гэсэн заалт байгаа юм. Тэгээд байрлуулахгүй байж болно гэсэн санаа бас гарч ирээд байгаа юм аа. Хяналтын камерыг бүх санал авах байруудад байрлуулна гэдэг заалтыг тодорхой тусгавал яасан юм бэ. Надад ийм санал байна. Байрлуулж болно биш байрлуулна гээд л заачихъя.

Одоо байрлуулж болно оо гэдэг чинь байрлуулахгүй байж бас болно гэсэн үг яригдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийгээ шууд байрлуулна гэдэг үгээр сольё оо гэдэг санал гаргаж байна.

Л.Энх-Амгалан: тэгвэл үүнийг хэлэлцүүлгийн үеэр, за ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүн

Д.Тогтохсүрэн: За баярлалаа. Энэ 63.13 бол камер байрлуулж болно гэдгээр орохгүй бол болохгүй байгаа юм аа. Улсын хэмжээнд 2100 хэсгийн хороо байгаа юм. Энэ 2100 хэсгийн хорооны 1000 гаруй нь яг баг дээр байгаад байгаа юм аа. Хөдөөгийн баг дээр байгаа багийн төвүүдийг камержуулах боломж байхгүй гэж СЕХ тэгж байгаа юм. Цахилгаан байхгүй ээ, түр мотор л тавьдаг юм чинь. Тийм учраас энэ байрлуулж болно гэдгийг. Нийслэлийнх бол ямар ч асуудал байхгүй камертай байлгана аа гэж байгаа юм. СЕХ. Хөдөөгийн багууд дээр бол камер тавих боломж, санхүүгийн боломж байхгүй ээ, төсөвт нь энэ талаар хөрөнгө тусгагдаагүй юм байна лээ. Байрлуулна гээд тавьчих юм бол манайх одоо баталж өгсөн төсвийн хүрээнд СЕХ чадахгүй гэж байгаа юм аа. Тийм учраас байрлуулж болно гээд харин зүгээр дараа нь СЕХ-нд Төрийн байгуулалтын байнгын хорооноос нийслэл, аймгийн төвүүд гэдэг юм уу олон сонгогчидтой газрууд дээр бол камер тавь гэдэг юмыг өгөөд ингээд явж болох юм байна лээ. Түүнээс тавина гээд оруулчихаар ерөөсөө болохгүй болчихоод байгаа юм аа. Нэг.

Тэгэхдээ энэ дээр харин хяналтын камер нь сонгогчийн саналаа нууцаар гарах эрхэд саад учруулахгүй гэдгээр томьёолж оруулж байгаа юм аа, нэмэгдлээр. Тийм учраас би гишүүдийг энэ томьёоллыг дэмжиж өгөөч ээ, энэ томьёолол дэмжихгүй бол үндсэн орж ирсэн томьёолол чинь байрлуулна гээд оруулчихсан юм. Тийм. Тийм учраас би энэ томьёоллыг дэмжиж өгөөрэй. Нөгөөдөх чинь байрлуулахгүй байж болно гээд биччихсэн юм. Тэгэхээр нь бид нар байрлуулахгүй, байрлуулж болно оо гээд харин жоохон дэвшил гаргаж оруулсан заалт байгаа юм шүү.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр ингэвэл яасан юм, СЕХ энэ дээр хариулчих уу. Одоо нийт Монгол Улсын хэмжээнд бол 2400 хэдэн санал авах байр гэж байна шүү дээ. Тэгэхэд одоогийн боломжоороо дэд бүтцийн хувьд боломжоороо нийт хэдэн хувьд нь энэ камер байрлуулж болох юм. Үүнийг тодруулчихаач, тэгэх үү. Тодруулж хэлж болно шүү дээ. Ажлын хэсгийн дарга тэгвэл тодруулаад хэлчих юм уу. Энэ уг нь тодорхой болчихвол уг нь амар байхгүй юу. Бараг 80 хувьд нь юм уу 90 хувьд нь юм уу. За Содномцэрэн дарга энэ дээр тодруулга өгөөч.

Ч.Содномцэрэн: За үүнийг ажлын хэсэг дээр ярьсан. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ярьсан юм аа. 2020 оны сонгуулийн төсөв батлагдсан. 1 ширхэг камер авах төсөв баталж өгөөгүй ээ. Тийм учраас төсвийнхөө хуулийн дагуу л явна. Тийм учраас үүнийг боломжгүй л гэж үзэж байгаа юм. Хэрвээ 2021 оны сонгуульд камержуулна аа гэвэл 2021 оны төсөвт бид санал оруулж ирж болно оо. Тийм.

Л.Энх-Амгалан: Үүнийг ямар ч байсан олон сонгогчидтой, нийслэл, дүүрэг, аймаг, сумдын санал авах байр дээр камер байрлуулж болно гэсэн ийм заалтаар нь дэмжье тэгэх үү. Санал хураалт.

45 гишүүн оролцож, 32 гишүүн зөвшөөрч, 71,1 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

48.Төслийн 64 дүгээр зүйлийн 64.1.5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

45 гишүүн оролцож, 28 гишүүн зөвшөөрч, 62,2 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

49.Төслийн 67 дугаар зүйлийн 67.9 дэх хэсгийн "Бие эрхтний согог, хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдал," гэснийг "Эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон" гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

45 гишүүн оролцож, 29 гишүүн зөвшөөрч, 64,4 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

50.Төслийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийн "гурав хүртэл" гэснийг "дөрөв хүртэл" гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт.

46 гишүүн оролцож, 34 гишүүн зөвшөөрч, 73,9 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

51.Төслийн 69 дүгээр зүйлийн 69.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“69.2.5.сонгогчийн саналаа нууцаар гаргах эрх болон сонгуулийн хорооны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах;” санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

46 гишүүн оролцож, 33 гишүүн зөвшөөрч, 71,7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

52.Төслийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсгийн “сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.” гэсний дараа “Мэдээлэл, технологийн багийн гишүүн, даамал нь санал авах, тоолох төхөөрөмжөөс дөрвөн метрээс багагүй зайд байрлаж, төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хянаж ажиллана.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх. Санал гаргасан Улсын Их хурлын гишүүн Пүрэвдорж. Байнгын хороо дэмжсэн юм байна, тийм ээ.Санал хураалт.

46 гишүүн оролцож 29 гишүүн зөвшөөрч, 63 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

53. Төслийн 72 дугаар зүйлийн 72.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“72.11.Энэ хуулийн 72.5.3-т заасны дагуу саналын хуудсыг дахин тоолоход сонгогчдын саналыг тоолохгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

46 гишүүн оролцож, 26 гишүүн зөвшөөрч, 56,5 хувиар энэ санал дэмжигдэж байна.

54-өөр санал хураалт хийхгүй юм байна. Өмнө нь санал хураалт хийчихсэн юм байна. 54 түрүүн босчихсон байхгүй юу. За Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Энэ 75 дугаар зүйл дээр 75.2.1 дээр байгаа юм. СЕХ нь санал хураалтын дүнг үндэслэн нам, эвсэл тус бүрээр нь тухайн нам эвслээс нэр дэвшигчдийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана гэж байгаа юм. Энэ дээр бие даан нэр дэвшигчээ хаячихсан байна шүү дээ.

75.2.2 бас адилхан. Бие даан нэр дэвшигчээ хаячихсан. Өөрөөр хэлбэл энэ бие даан нэр дэвшигч гэдгийг заавал оруулахгүй бол нөгөө бие даан нэр дэвшигчийнхээ жагсаалтыг гаргахгүйгээр хаягдах нь байна шүү дээ. Байнгын хороон дээр найруулга дээр нь хараарай гэж хэлмээр байна.

Энх-Амгалан даргыг айж байгаа дээр нь хэлье. Түрүүний тэр авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон хүнийг, ял эдэлсэн хүнийг нэр дэвшүүлэхгүй гэж заасан заалт бол үнэхээр та нар нэг Энхбаярын эсрэг л бүх юмыг хийх юм. Энэ чинь танай намыг удирдаж байсан л хүн шүү дээ. Тэгээд л нэг

Л.Энх-Амгалан: Саяын Пүрэвдорж гишүүний хэлсэн түрүүний 54 дүгээр заалт. Нэр дэвшигч чинь ерөнхийдөө хасагдчихаж байгаа юм биш үү. 2 дугаар хэлэлцүүлэг дээр үүнийг Байнгын хороон дээр хараарай. Тэгэх үү. Санал хураалт.

55 дугаар зүйл. Төслийн 79 дугаар зүйлийн 79.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“79.3.Энэ хуулийн 9.11-т заасны дагуу дахин сонгууль явуулахад улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээс ээлжит, ээлжит бус, нөхөн сонгуулиар гаргаж хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг ашиглана.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

49 гишүүн оролцож 32 гишүүн зөвшөөрч 65,3 хувиар энэ санал дэмжигдэж байна.

56.Төслийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн дараа доор дурдсан агуулга бүхий хэсэг нэмэх, үүнтэй холбоотойгоор 80.3 дахь хэсгийг “ирцийг” гэснийг “ирц, саналын тоог” гэж, “ирц” гэснийг “ирц, саналын тоо” гэж, 4 дүгээр зүйлийн 4.5.1 дэх хэсгийг “Нэмэлт санал хураалт гэж энэ хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу явагдах санал хураалтыг,” гэж тус тус өөрчлөх:

“Сонгуулийн тойрогт хамаарах сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын тавь буюу түүнээс дээш хувь нь санал хураалтад оролцоогүй бол тавин хувь нь оролцоогүй хэсэг тус бүрд нэмэлт санал хураалт явуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Хэсэг тус бүрд. За Баасанхүү гишүүн. Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа.

О.Баасанхүү: Уг нь бол хуучин хуулиар бол нийт сонгогчдын 50-аас дээш хувь гэдэг үг байсан юм. Тэгсэн чинь одоо бол хэсэг гэдэг үг ороод ирж байгаа юм л даа. Мэдээж өнөөдөр 60 тэрбумтай, ЖДҮ-тэй, концесстой одоо юм юмтай хүмүүст гомдоод нөгөө цагаан сонгууль гэдэг шиг хүмүүс ирэхгүй байх магадлалтай. Тэгэхээр хүчээр ирцийг бүрдүүлэх гээд байна л даа.

Өөрөөр хэлэх юм бол зориуд зохион байгуулалттайгаар хэсэг гэдэг ойлголт, одоо томсгосон тойрогт аваад үзэх юм бол нийт тойргийн 50 хувийн дотор дахиад 50 хувь нь үгүй ээ гээд ирцэд ороогүй байхад бол тэр үгүй гэдэг хариулт нь нийлээд нийт сонгогчдын 50 хувт болох магадлал байгаад байгаа юм. Гэтэл харамсалтай нь өнөөдөр юу вэ гэх юм бол нөгөө хэсэг гэдэг юм уу тийм байдлаар л хандаад байгаа байхгүй юу. Тийм болохоор үүнийг бол дэмжиж болохгүй ээ.

Нийт сонгогчдын гэдгээр явахгүй бол өнөөдөр сонгогчдын санал хүргэхгүй байх зохион байгуулалттай тоглолт хийхийг үгүйсгэхгүй. Өөрөөр хэлэх юм бол сонгуульд нэр дэвшээд ялсан хүмүүст бол зовлонгүй байх. Сонгуульд нэр дэвшээд ялахааргүй магадлалтай ЖДҮ-чдийн хувьд бол зовлонтой байх аа. Тэр хүмүүс бол сонгуулийг дахиулахын тулд нөгөө цагаан сонгууль гэдэг шиг янз бүрийн байдлаар ирцийг хүргэхгүй байдлаар тоглох бололцоог үүсгэх гээд байна аа. Тийм учраас үүнийг анхаарч, үүнийг хаах хэрэгтэй гэж хэлмээр байна. Баярлалаа.

Л.Энх-Амгалан: Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүн талбар хийх үү.

Д.Тогтохсүрэн: Энэ ийм байгаа юм Баасанхүү гишүүн ээ. 56 дахь санал бол орж ирсэн төслийг дээрдүүлж байгаа санал. Орж ирсэн төсөл дээр бол 50 хувийн босго байхгүй. Харин бид ажлын хэсэг дээр ярьж байгаад ирцийг 50 хувийн босготой болгож байгаа заалт байгаа юм, энэ 56 дахь санал. 50 хувийн босгоо хүрээгүй тойрог байх юм бол тэр тойргийн 50 хувь дээр 50 хувийн босгоо хүрээгүй хэсэг дээр нэмэлт санал хураалгана гэдэг хэлбэрээр орж байгаа томъёолол байгаа юм. 2 дахь санал хураалт болно оо гэсэн үг шүү дээ, нэмэлт санал хураалт. Тийм учраас бол энэ харин бид нар 50 хувийн босгогүй юмыг босготой болгож өгч байгаагаараа энэ заалт чухал заалт учраас би гишүүдийг дэмжээрэй гэж хэлэх гээд байгаа юм.

Л.Энх-Амгалан: Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Тогтохсүрэн дарга сая миний хэлэх гэж байсан зүйлийг хэлчихлээ дээ. Тэгэхдээ бас нэг нюанс байгаа шүү. Тойргийн хэмжээнд 50 хувь хүрээгүй тохиолдолд 50 хувь нь хүрээгүй хэсгийн хороод дээр нэмэлт санал хураалт явуулна. Тэр хэсгийн хороод дээр нь хэсгүүд дээр нь нэмэлт санал хураалт явуулаад тэр дүнгээр нь сонгуулийн эцсийн дүн гарна. Тэр нь 49,7 ч хүрнэ үү, 44 ч хүрнэ үү хамаагүй. Тэр нь эцсийн лүн гарах юм шүү. Ер нь бол хууль тогтоогч юу шаардаж байгаа гэвэл 50 хувийн босгыг шаардаж байгаа, нэмэлт сонгууль санал хураалт явуулна тэр нь хүрээгүй бол эцсийн дүнгээрээ явна шүү гэдэг тэр хүрсэн хүрээгүй дүнгээрээ шууд сонгуулийн эцсийн дүн гарах юм шүү гэдэг тодотголыг хийж өгч байгаа шүү. Үүнийг протоколд тэмдэглүүлэхгүй бол болохгүй.

Л.Энх-Амгалан: Үг хэлчихлээ. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Энэ ирц дээр тодорхой асуудлууд гарч байна л даа. Одоо тэгээд жишээ нь түрүүний оруулж ирсэн саналаар жишээ нь Монгол Ардын Хувьсгалт намын дарга Энхбаярыг хасаад хаячихлаа л даа. Тэгэх дээр Монгол ардын хувьсгалт намын гишүүд чинь энэ сонгуульд ерөөсөө орохгүй болчихож байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл ямар ч хүчгүй болгож хаяад тэгэх дээр энэ Монгол ардын хувьсгалт нам чинь сонгуульд идэвхгүй оролцоод цагаан хуудас өгч таараа шүү дээ. Ийм нөхцөл байна. Та нар одоо нэг үхсэн буурын юунаас айна гэдэг бил ээ нэг юмнаас айгаад байх шиг байгаа юм. Яасан

Л.Энх-Амгалан: За санал хураалт. Саяын гишүүдийн хэлсэн, Мөнх-Оргил гишүүний хэлснийг бас 2 дахь хэлэлцүүлгийн үеэр Байнгын хороон дээр. За тэр хуулиараа л байх юм байна шүү дээ, за. Санал хураалт.

51 гишүүн оролцож 32 гишүүн зөвшөөрч 62,7 хувиар энэ санал дэмжигдэж байна.

57.Төслийн 81 дүгээр зүйлийн 81.5 дахь хэсгийн “81.5.” гэснийг “Тайлбар:” гэж, “их” гэснийг “илүү” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

51 гишүүн оролцож, 31 гишүүн зөвшөөрч 60,8 хувиар энэ санал дэмжигдэж байна.

найруулгын санал.

1. За Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: За энэ ажлын хэсгээс гаргасан саналуудын төгсгөл дээр нэг ийм хурал даргалагчийн зүгээс нэг чиглэл өгүүлэх асуудал байна аа. Хуулийн төслийн 21.6.4, 21.6.5, 21.6.6 дээр байгаа төрийн тусгай албан хаагч байгаа юм, эдгээрийн гэр бүлийн талаарх мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад ирүүлнэ гэсэн юм байгаад байгаа юм аа. Тэрийг бол бид нар өчигдөр бас ярьж байгаад, тэгэхээ санал хураалтын дараа ярьсан юм аа. Байнгын хорооны үйл ажиллагаа явагдсаны дараа ярьсан юм. Тэгэхээр энэ 21.6.4, 21.6.5, 21.6.6 дээр найруулга гэх юм уу өөрчлөлт хийх асуудлыг 3 дугаар хэлэлцүүлгийн үед шийдээрэй гээд чиглэл өгчихвөл энд бид нар 21.6.4, 21.6.5, 21.6.6.

Л.Энх-Амгалан: Саяын Тогтохсүрэн гишүүний хэлсэн 21.6.4, 21.6.5, 21.6.6-тай холбоотой энэ заалтуудыг 2 дугаар хэлэлцүүлгийн үеэр Байнгын хороон дээр

ажлын хэсэг засаж янзлах ёстой чиглэл өгч байна. За, Найруулгын санал 1.

1. Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “заасны” гэсний дараа “дагуу” гэж, “хангасан” гэсний дараа “Монгол Улсын” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

49 гишүүн оролцож, 34 гишүүн зөвшөөрч, 69,4 хувиар энэ санал дэмжигдэж байна.

Найруулгын 2 дахь санал.

2. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурлын /цаашид “Улсын Их Хурлын” гэх/ сонгууль нь” гэснийг “Монгол Улсын Их Хурлын сонгууль нь /цаашид “сонгууль” гэх/” гэж, мөн зүйлийн 4.2 дахь хэсгийн “Улсын Их Хуралд” гэснийг “Монгол Улсын Их Хурал /цаашид Улсын Их Хурал гэх/-д” гэж, мөн зүйлийн “4.4.1, 4.4.2, 4.4.3, 4.4.4” гэснийг “4.5, 4.6, 4.7, 4.8” гэж, мөн заалтуудын “сонгуулийг,” гэснийг “сонгуулийг ойлгоно.” гэж, 21 дүгээр зүйлийн 21.9.2 дахь заалтын “26.6” гэснийг “26.3” гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “24.1” гэснийг “24.2” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “21.1” гэснийг “25.1” гэж, мөн зүйлийн 25.6 дахь хэсгийн “21.5” гэснийг “25.5” гэж, 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн “нь” гэснийг “тус бүр” гэж, 72 дугаар зүйлийн 72.1.2 дахь заалтын “78.5” гэснийг “72.5” гэж тус тус өөрчлөх.

3. Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “холбогдох” гэснийг хасах.

4. Төсөлд зүйл, хэсэг, заалт нэмж, хассантай холбогдуулан төслийн дугаар, ишлэлийг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

47 гишүүн оролцож, 34 гишүүн зөвшөөрч, 72,3 хувиар энэ санал дэмжигдэж байна.

Хоёр. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал.

1. Төслийн 63 дугаар зүйлийн 63.1, 66 дугаар зүйлийн 66.15 дахь хэсгийн “22:00” гэснийг “21:00” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт

47 гишүүн оролцож, 29 гишүүн зөвшөөрч, 61,7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

2. Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 21.7 дахь хэсгийг нэмж, дугаар өөрчлөх:

"21.7. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчийн эцэг(эх)-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг бүхий хэсгийг зөвхөн цахим хэлбэрээр нэг удаа олгоно." Санал гаргасан Улсын Их хурлын гишүүн Пүрэвдорж.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал байна. Нямбаатар гишүүнээр тасаллаа.

О.Баасанхүү: Би ингэж бодохгүй юу. Шулуухан хэлэхэд тэр нэг улсын бүртгэлийн газарт байгаа хүний овог нэр, регистрийн дугаар, хаяг ямар хамаатай

юм бэ, хэн нэгэнд өгөхгүй байвал бана л биз дээ. Өгөхгүй байвал байя л даа гэсэн чинь үгүй юм аа.

Манай Ардын нам CD-ээр хүмүүст тарааж байсан юм байна. Тарааж байсан олон хүмүүсийн жишээ баримттай нь мэдэж байна. Тэгээд би асуухгүй юу, яагаад тараасан юм бэ, та нарт ямар хэрэгтэй юм бэ, зачем гэж асуухгүй юу тэгсэн чинь ганцхан үг хэлж байна. Ерөөсөө улаан, ногоон, цэнхрээр нь дугуйлдаг юм. Овог нэрээр нь хайж байгаад танай аав чинь манай нам. Должингийн гэдэг юм уу Доржийн гэдэг юм уу, тэгэнгүүт тань дээр гүйж очоод хүүе аав чинь манай нам учраас тань дээр очъё гээд нөлөөлөл өгдөг юм байна.

Тийм учраас үүнийг зүгээр л 2 дугаарт нь мөнгө тараадаг юм байна. Тийм учраас өнөөдөр манай Ардын намынхан дангаараа үүнийг авч байгаа юм байна. Авах гэж байгаа юм байна. Авъя гээд бүр хуульчилж байгаа юм байна. Ийм бузар булай байж болохгүй ээ. Ийм утгагүй тэгш бус байж болохгүй. Та нар 65-уулаа бүх юмыг хүчиндлээ шүү дээ. Бүх юмыг хүчиндлээ. Би та нараас гуйж байна. Бүр хичээнгүйлэн гуйж байна. Битгий хулгай хийгээч, битгий худлаа яриач, битгий хүн алаач, битгий концессдооч гээд. Үгэнд ордоггүй. Одоо эцэст нь сонгуулийг будилаантуулъя аа. Будилаантуулахын тулд нэрсээр нь очоод хүнтэй нь уулзъя аа гэж байгаа юм байна.

Тийм учраас ийм утгагүй байж болохгүй. Тийм учраас үүнийг бид бас хянамаар байна аа. Дорж дээр очлоо гэвэл бид нар энэ жагсаалтыг нь авъя. Аваад бид нар Дорж дээр очлоо гэдгийг мэдээллийг авангуут Дорж гуайтай уулзангуут Дорж гуай надад мөнгө өгөөгүй ээ мэдэхгүй гэвэл би Доржийн Бат, Доржийн Дулмаа дээр очоод тань дээр мөнгө өгсөн үү, яасан бэ гэж асуумаар байна. Тэд нар тийм ээ тийм аав маань манай, одоо юу гэдгийн жанжин шугамаараа бол жинхэнэ намын гишүүн гэж хэлээд элссэн гээд надад мөнгө өгсөн. Би санал өгөх гэж байсан гээд ярих боломжтой. Тийм учраас энэ хавтгайг бид авъя аа.

Гомдол гаргасан, ба ба гэдэг юм уу 9 шидийн юм ярьдаг ч гэсэн харамсалтай нь 65-уулаа нэртэйгээр нь хаант засгийг тогтоож чадаагүй, та нар. Та нар хаант засгийг тогтоож чадаагүй. Та нар хууль хүчний бүх байгууллагыг авсан. Хувийнхаа карманд хийсэн. Шоронд орохынхоо өмнө АТГ-ын өмнө очоод мэдэгдэл хийсэн. Тэгээд кармандаа хийсэн. Өөрийнхөө хүмүүсийг аваад хулгайч байхаа больсон. Эрдэнэтийг Хятадад өгсөн.

Л.Энх-Амгалан: Зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлмээр байх юм. Тийм. Ү г хэлэх гишүүд байгаа юм байна. Пүрэвдорж гишүүн

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2008 оны 7 сарын 1-нд босон энэ их асуудал сонгуулийн олон будилаанаас болсон л доо. Тэгээд 7 сарын 1-ээс сургамж аваад бүхэл бүтэн 3 жил, 2008, 2009, 2010, 2011 гээд 3, 4 жил дамжуулаад энэ сонгуулийн хуулийг ер нь бол жоохон гайгүй болгочихъё гээд ажлын хэсэг ажиллаад, сонгуулиар гарсан будилаануудыг ерөнхийдөө цэгцлээд ингээд явсан байгаа юм.

Үүний үр дүнд орж ирсэн 1 зүйл бол сонгогчдын нэрсийн жагсаалтыг нам, эвслүүдэд өгье өө гэдэг ийм шийдвэр гараад энэ нь бол хэд хэдэн сонгуулиар явсан байгаа. Тэгэхээр ер нь бол яах вэ энэ том намууд бол өөрсдийнхөө намын бүтцээрээ дамжуулаад тэр сонгогчдынхоо бүх жагсаалтыг гаргаад, өөрсдөө авах боломжтой. Ер нь энэ бол бүх түвшинд сум, баг бүрд ажилладаг тэр үйл

ажиллагаа явуулдаг намуудад бол энэ бол амархан. Хамгийн гол нь жижиг бага намууд гээд, эвслүүд, бие даагч нарт бол их хүнд л дээ. Өөрөөр хэлбэл тэд нар чинь хүн хүч муутай, тэгээд ямар хүн орж ирээд санал өгч байгааг нь мэдэх арга байхгүй. Тэр жагсаалтыг нь харж байгаад бас ямар хүн ирснийг нь бас тэмдэглээд авчих бололцоотой л болгох гэж байгаа гол зүйл юм л даа. Тэгээд энэ дээр, мэдээж тэр хар, ногоон, улаанаар нь дугуйлдаг бол тэртэй тэргүй аль хэдийн томоохон намууд бол хийчихсэн байж байгаа.

Тэгэхээр үүнийг болохоор энэ УБЕГ-ынхан болохоор хуульд өөрөөр заагаагүй бол нууцална гэж байгаа юм. Хуульд өөрөөр заагаагүй гэдэг дээрээ прокурорын хууль ч юм уу, шүүхийн ч юм уу аль эсвэл эрүүгийн байцаан шийтгэх хууль ч юм уу энэ хуулиудаараа тэр хүний мэдээллийг ил болгочхож байгаа юм. Гэтэл бид нар энэ дээр сонгуулийн хууль дээр заагаад өгчих юм бол хуульд өөрөөр заагаагүй бол хориглоно гэдэг тэр заалт нь байхгүй болчих байхгүй юу.

Тийм учраас энэ улсын бүртгэлийн газраас гаргаж байгаа нууц байна гэдэг энэ зүйл бол буруу. Энэ бол буруу тайлбар гэж хэлмээр байна. Тэгэхээр ер нь бол энэ жагсаалтыг тэртэй тэргүй МАН тэр хаагуураа, юугаар байдаг юм авчих байх л даа. Тэгээд тэд нар өөрсдөө ашиглана. Сая Баасанхүүгийн хэлдэг зөв.

Тэгэхээр үүнийг Их Хурлын гишүүд дэмжиж өгөөч ээ. Дэмжихгүй бол бид нар энэ дээр цааш цаашдаа Ерөнхийлөгчийн хориг тавиулах, одоо юу байдаг юм, тэр арга хэмжээнүүдийг шат дараалан авах болно гэдгийг хэлье.

Л.Энх-Амгалан: Нямбаатар гишүүн

Х.Нямбаатар: Их Хурлын дэд дарга аа. Сая Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналын 14 дээр байсан төслийн 63 дугаар зүйлийн 63.1, 66 дугаар зүйлийн 66.15 дахь хэсгийн 22 гэснийг 21 гэж өөрчлөх саналыг би гаргасан юм аа. Сая энэ бас санал хураалтын явцад дэмжигдээгүй санал дэмжигдсэнгүй. Энэ манайд хөдөө орон нутаг, хотод санал хураалтын цагийг хаахад ялгамжтай зүйл байхыг үгүйсгэхийн аргагүй.

2016 оны сонгууль бол 20 цагт дуусгавар болсон. СЕХ-оос бусад улс орнуудад сонгууль хаадаг цаг хугацааг харьцуулан судалж үзэхээр манай улсын хувьд харьцангуй хамгийн орой санал хураалт хаадаг ийм жишигтэй юм байна лээ. Тэгээд хэдий чинээ санал хураалт орой 22 цаг хүртэл явагдана, төдийн чинээ сонгуулийн үеэр будилаан үүсдэг, мөнгө төгрөг тараадаг, архи дарс асуудлууд их гардаг. Тийм учраас үүнийг эцсийн хэлэлцүүлэг дээр Байнгын хороон дээр бас эргэж харах талаар та нэг чиглэл өгөөч.

Л.Энх-Амгалан: За, Нямаагийн Энхболд гишүүн

Н.Энхболд: Баярлалаа. Энэ сонгогчдын хаяг, адрес, тэр хамаг мэдээллүүдийг нь өгөх асуудлыг үүний түрүүчийн Улсын Их хурлыг зохион байгуулсан хууль буюу 2015 онд хууль яригдсан үеэр бас их дэлгэрэнгүй ярьж байсан юм аа. Бас 2 тал болоод л баахан ярьж ярьж байгаад тухайн үед нь олонх байсан улс төрийн нам олонх байсан тэр хүчээрээ үүнийг өгнө өө гээд хуульчлаад оруулчихсан юм. Тэгээд үүнээс үүдэлтэй бас олон асуудал үүсэж байсан. Хувь хүний нууцтай, орон байрны заавал би тэнд амьдардаг гэдгээ хүн болгонд дэлхийгээр нэг зарах алба байхгүй шүү дээ.

Олон янз бүрийн шалтгаан гардаг юм байна лээ. Цагдаагийн байгууллагын

зүгээс ч гэсэн, хууль хяналтын байгууллагуудын зүгээс энэ бол хувийн нууцад хамаарах асуудал шүү. Ингэж хамаагүй хандвал асуудал гарна шүү гэж. Тэр хуулийг ярьж байх үеэр ярьж байсныг би санаж байна. Би ажлын хэсэг ахалж байсан. Үнэхээр сүүлд нь тийм юмнууд гарсан. 1 дүгээрт.

2 дугаарт бол одоо дахиад улсын бүртгэлийн ерөнхий хууль шинэчлэгдсэн. Бид нар хуулиа яг энэ одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиудынхаа хүрээнд л хийх ёстой шүү дээ. Тэр хуулийн 12.6 дээр хувь хүний саян энэ нийтэд тараана, зарлана гээд байгаа мэдээллүүдийг хязгаартай тарааж болно оо гэсэн ийм хуулийн заалттай. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр хувийн нууцтай холбоотой асуудал. Тухайлбал орон гэрийн хаяг, бусад зүйлүүдийг шүүх, прокурорын зөвшөөрлөөр эсвэл зөвхөн тэр хувь хүн өөрөө зөвшөөрсөн тохиолдолд олон нийтэд түгээж болно оо гээд хууль бас гарчихсан юм аа.

Энэ юмнуудыг харгалзаж үзээд ажлын хэсэг дээр хууль санаачлагчид ийм байр суурьтай байгаа шүү гэдгийг 1 дүгээрт хэлье. Ингээд энэ байгаагаараа цахим хэлбэрээр 1 удаа олгоно гээд орчихъё гэж бодъё л доо. Тэгэхдээ энэ бол ганцхан Монгол Ардын намд өг гэсэн үг биш шүү дээ. Тийм үг биш ээ. Энэ дээр нь тийм үг байгаа бол зарим гишүүний хэлсэн шиг энэ бол Ардын намынхан л авах гэж байна гэж бас ярьж болох сон. Тэгэхээр ингээд батлагдсан ч энэ ганц намын тухай, улс төржүүлж байгаа асуудал биш хуультай, угаасаа болдоггүй, олон нийт хүлээж авдаггүй ийм заалт шүү гэдгийг л хэлэх гэсэн юм.

Л.Энх-Амгалан: Гишүүд үг хэлж дууслаа. Түрүүний Нямбаатар гишүүний гаргасан тэр төслийн 63 дугаар зүйлийн 63.1, 66 дугаар зүйлийн 66.15 энэ унасан. Гэхдээ эцсийн хэлэлцүүлэг дээр нийт Байнгын хороон дээр нийт гишүүдийн 2/3-оор бас яах дэг байгаа шүү дээ. Түүнийгээ та нар яриарай. Түүнийгээ 3 дугаар хэлэлцүүлэг дээр, тийм ээ. За, санал хураалт.

Одоо бол 2 дугаар зүйлээр санал хураалт хийх гэж байгаа шүү дээ. Энэ бол Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал байна. Санал хураалт.

50 гишүүн оролцож, 30 гишүүн зөвшөөрч, 60 хувиар энэ санал, Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдэж байна гэсэн үг шүү дээ.

3.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн “аль нэг хүйсийнх” гэсний дараа “2-оос доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баасанхүү.

Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Би 1 зүйл бодож байгаа юм аа. Эмэгтэйчүүд маань өдөржингөө хурал хийлээ. Өдөржингөө утсаар мессеж явууллаа. 30 хувийг чинь л анхаараарай гэж. Би 30 байтугай 100 хувь болгомоор байгаа юм. Яах вэ дээр хөөрхий, өнөөдөр эрчүүд гэдэг чинь бас өөр л дөө. Зовлонтой. Тэр утгаараа манай эмэгтэйчүүд 30 хувь байтугай, 40 хувь авсан ч яадаг юм. Дэвшигдэх эрхийг л авъя гээд байна шүү дээ. Гишүүн болъё гэдэг эрхийг авъя гээгүй. Хэдийгээр 30 хувийг авсан ч гэсэн 30 хувь сонгогддоггүй биз дээ. Өмнө нь жишээлбэл 10 юм уу 5 байсан бол магадгүй одоо 20 байсан бол тэрний тал хувь нь орж ирдэг. Тэгэхээр тэр утгаараа бол би эмэгтэйчүүдийг намайг дэмжээч ээ гэж хүсэж байгаа юм. Монгол Улсын төрийн албаны тухай хууль дээр 20 хүн аливаа байгууллагад ажиллаж байгаа бол 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг заавал ажиллуулна аа гэж

байгаа юм.

Танай нам 100 мянган хүнтэй гээд томроод байдаг юм. 100 мянган хүнтэй гэж харьцуулах юм бол 76 хүнийг дэвшүүлэх гэж байгаа бол яах аргагүй ядаж 1нэг 3 хүнийг оруулаад өгөөч гэж байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй гэхээр та нар магадгүй сэтгэцийн эмнэлгийн газар эсхүл насаараа хэвтэрт байгаа хүнийг гээд ингээд хамгийн муугаараа л бодох байх.

Би хөгжлийн бэрхшээлтэй гэдэг нь магадгүй биднээс хөгжилдөө илүү, хөлгүй, гаргүй, таягтай, тэрэгтэй, янз бүрийн хүн байж болно. Одоо энэ сонгуулийн хууль дээр сэтгэцийн гэдэг үгийг хасаад хаячихсан шүү. Уул нь сэтгэцийн эмгэгийг гээд Ерөнхийлөгчид дэвшиж байгаа хүний сэтгэцийг шалгуулж байгаа мөртөө Их Хуралд сонгогдож байгаа хүмүүс сэтгэцээ шалгуулахгүй ээ гээд ямар ч утгагүйгээр тэр заалтыг аваад хаясан. Уул нь тэрийг шалгуулмаар байгаа юм.

Тэр чинь бас л хөгжлийн бэрхшээлийн нэг илрэл шүү дээ. Түүн шиг өнөөдөр яагаад бид нар, намайг өөрийнхөө эсрэг л гэж байгаа юм. Би та нараас өөр юм ярьж байгаа болохоор та нарын эсрэг байх л даа. Би хулгайч нарын эсрэг ярьж байгаа болохоор өнөөдөр өөр сонсогдож байж магадгүй. Яагаад гэхээр аливаа шударга ёс өөр болчихсон. Аливаа зүй зохицолтой зарчим ярьдаг нь өөр болсон учраас сэтгэцийн эмгэг гэдгийг магадгүй зарим хүн өөр юм ярихаар тэнэг, мангар гэж дууддагийг би ойлгож байна. Гэхдээ миний яриад байгаа юм болохоор хөгжлийн бэрхшээлтэй гэдэг хүнийг нам болгон яагаад 1, 2 хүнийг дэвшүүлж болдоггүй юм бэ. Ард түмэн сонгоё л доо.

Японд хараагүй Их Хурлын гишүүн байдаг. Солонгост хүн байдаг. Дэлхий даяар байдаг аа. Яагаад Монголд байж болдоггүй юм бэ. Сонгох эрх нь ард түмэнд. Би эмэгтэйчүүдийн юмыг яагаад одоо би энд тоолно, миний харж байгаагаар 1, 2, 3, 4, 5, 6, 7 гээд бараг бүх эмэгтэйчүүд сууж байна. Та нар чинь багаар бодоход дэмжээд өгөөч. Би хэлж байна шүү дээ, эмэгтэй хүн юугаараа дутуу юм, юугаар ч дутуу биш. Тэгсэн хэр нь 30 хувиа нэхэж байгаа мөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг оруулъя гэхээр яагаад босохгүй байгаа юм.

Төрийн албаны тухай хууль дээр хөдөлмөрийн хууль дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулна, оруулна гэсэн мөртөө Улсын Их Хурлын тухай хуульд яагаад оруулж болдоггүй юм бэ. Яагаад болохгүй гэж улайраад байгаа юм бэ. Яагаад үүнийг эсэргүүцээд байгаа юм бэ. Нэг хуруугүй хүн хөгжлийн бэрхшээлтэй гэж хэлж болно шүү дээ. Яагаад өнөөдөр хорт хавдартай хүн группт орчхоод сонгуульд орж болдоггүй юм. Группт орсон гэдэг чинь бас л хөгжлийн бэрхшээл гэсэн үг.

Өрөөсөн нүдтэй хүн яагаад нэр дэвшиж болдоггүй юм. Ийм утгаараа өнөөдөр би юу гэж хэлж байгаа вэ гэвэл хөгжлийн бэрхшээлтэй гэхээр өөрсдөө агуу болоод зарим нь намайг доромжлоод өөрийнхөө тухай ярилаа гэж битгий намайг шоолооч ээ. Би өөрийнхөө тухай яриагүй.

Л.Энх-Амгалан: Оюунхорол гишүүн

Д.Оюунхорол: За, би одоо сонгуулийн хуулийн ажлын хэсэг дээр энэ саналыг би гаргаад дэмжлэг аваагүй. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр манай Амарзаяа гишүүн санал гаргаад бас за уучлаарай, би дараагийнх дээр нь авъя аа, дарга аа

Л.Энх-Амгалан: За, гишүүд ээ санал хураалт. Энэ Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал.

49 гишүүн оролцож, 24 гишүүн зөвшөөрч, 49 хувийн саналаар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй, тэгэхээр энэ санал дэмжигдэж байна гэсэн үг шүү дээ.

Содбаатар гишүүн.

Я.Содбаатар: Бид нар нэг зүйлийг ойлгох хэрэгтэй л дээ. Сонгуулийн хуульд бид нар ямар нэгэн хүмүүсийг нэр дэвшихийг ерөөсөө хориглосон заалт байхгүй шүү дээ. Хориглоон юм шиг яриад байх юм. Тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна уу, өвчтэй иргэн байна уу, ямар нэгэн хүнийг хориглосон заалт байхгүй. Тэгээд сая миний карт ажилласангүй, энэ тоног төхөөрөмж ажилласангүй.

Л.Энх-Амгалан: Тэгэх юм бол санал хураалтын дүн чинь өөрчлөгдөх нь байна шүү дээ. Содбаатар гишүүний тийм байна. Эмэгтэйчүүдийн квоттой андуурч дарсан юм байна. Содбаатар гишүүн горимын санал гаргачих уу. Тийм. Горимын санал гаргачих.

Я.Содбаатар: Дахин санал хураалгаж өгнө үү, карт ажиллахгүй байна.

Л.Энх-Амгалан: За, өмнөх саналыг хүчингүй болгоё. Саяын Содбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг дахин явуулъя. Одоо Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал. Санал хураалт.

Горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт байхгүй юу. Горимын гаргаж байгаа саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Дэмжиж байж хүчингүй болгоно шүү дээ.

48 гишүүн оролцож, 29 гишүүн зөвшөөрч, энэ горимын санал дэмжигдэж байгаа учраас санал хураалтыг дахин явуулъя.

3 дугаар зүйлээр санал хураалтыг дахин явуулна. Төрийн байгуулалтын байнгын хороон дэмжээгүй саналаар санал хураалт.

47 гишүүн оролцож, 28 гишүүн зөвшөөрч, 59,6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

4.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн “20-оос доошгүй” гэснийг “30-аас доошгүй” гэж өөрчлөх: Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Амарзаяа, Билэгт, Гарамжав, Мөнхцэцэг, Оюундарь, Оюунчимэг, Оюунхорол, Саранчимэг, Цогзолмаа, Ундармаа, Ундраа, Сарангэрэл. Дэмжсэн дэмжээгүй 3, 3 гишүүн. Ж.Энхбаяр гишүүнээр тасаллаа. За, Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Би дэмжиж байна аа. Хөөрхий муусайн эмэгтэйчүүдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс долоон дор үздэг гэж би ойлголоо. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуульд оруулахгүй гэж горимын санал гаргасан Содбаатарыг хэлгүй, дүлий, саажилттай тэд нарыг харж байсан эцэг эхүүд сайн хараад аваасай гэж би хүсэж байна. Ямар бузар юм бэ. Ямар муухай юм бэ. Хөдөлмөрийн тухай хуулиар байж байгаа. Өнөөдөр ЖДҮ-тэй хүн томорч болно. Гэхдээ өнөөдөр ингэж болохгүй ээ. Би эмэгтэйчүүдээ ганцхан зүйлд л уриалж байна. Хайраар хандаач ээ.

Би өнөөдөр юу вэ гэвэл хэрвээ өмнөх сонгуульд би 2012-2016 онд Их Хурлын гишүүн байсан. Би Батчимэг шиг ч юм уу, Оюун эгч шиг ч юм уу, Эрдэнэчимэг шиг ч юм уу сүрхий эмэгтэйчүүд байвал 100 байгаасай гэж хүсэж байна. Би өнөөдөр энэ талбай дээр уйлаад сууж байсан Болороо гэдэг эмэгтэйг хараад би өмнөөс нь уйлж байлаа. Би 13-тай охиныг хүчиндсэн хүн дээр ямар ч эмэгтэй очоогүйд би бухимдаж байлаа. Би өнөөдөр юу гэх юм бол эмэгтэй, эрэгтэй гэж ялгахаасаа илүү сонгуульд орох эрхийг тэгш олгоосой гэж бодохын төлөө та нар саналаа өгсөн гэж би ойлгож байна.

Та өнөөдөр сонгуульд оролцохын тулд намдаа жийгдэж мөнгөгүй, төгрөггүй, магадгүй чи эмэгтэй юм чинь цаашаа бай даа гэж бүдүүлгээр хэлэх юм бол ажлын байрны дарамтад орж, намын даргын лантуу дор орж дарамтлуулдаг гэж би ойлгосон учраас дэмжиж байна. Түүнээс биш уг нь бол хүн л бол хүн шүү дээ. Саяхан нэг хошин шог хууль гарсан шүү дээ. Морь морьтойгоо эвцэлдвэл эрлийз үү эрлийз биш үү гэдгийг ялгая гэхийн тулд өндөр, намхныг нь олъё гэж. Ийм аймшигтай хууль гарсан байхгүй юу. Уул нь морь морь л байхгүй юу даа.

Морь нохойтой юм уу морь илжигтэй биш шүү дээ. Гэтэл өнөөдөр илжигтэй байвал луус байж болно, Тэгтэл өнөөдөр ийм хууль гаргачхаад эсвэл өнөөдөр ву гэдгийн чи заавал ямар ч шашин шүтсэн шүтээгүй хамаагүй ажил хийж болохгүй гэдэг хуулийг өнөөдөр та нар баталсан. Тэр нь чи буддын шашин шүтсэн, шүтээгүй ч хамаагүй заавал амар гэж. Тэгээд амраад заавал очоод тэр буддын сүм, дуганд очиж мөргө гэж ийм хууль гаргасан.

Тэгэхээр үүний хажууд бол энэ эрүүл санал юм аа. Хүмүүн төрөлхтний дотроос хөөрхий ядарсан эмэгтэйчүүдээ Ардын нам дэмжихгүй байгаа учраас би дэмжье ээ. Та нарыг үл тоож байгаа үл бүтэх тэр намын даргаас чинь хамгаалъя аа. Үүний төлөө бүгдээрээ саналаа өгье өө. Түүнээс биш та нар хөгжлийн бэршээлтэй иргэдийг доромжилсон шүү. Өрөөсөн гаргүй, өрөөсөн хөлгүй, өрөөсөн нүдгүй хүмүүсийг та нар доромжилсон. Больё оо биш, та нар доромжилсон. Та нар гутаасан. Та нар өнөөдөр жинхэнэ

Л.Энх-Амгалан: Яг хэлэлцэж байгаа асуудал дээрээ үг хэл, тэгэх үү. Билэгт гишүүн

М.Билэгт: Эрхэм гишүүдийнхээ амрыг эрье ээ. Манай Монголчууд эрт дээр үеэсээ эрийн хийморь гэрийн хийморь гэж эрчүүдээ хүндэлж, цай хоолныхоо дээжийг гэрийн эзэндээ өргөн барьдаг. Эрчүүдээ дээш нь суулгадаг. Энэ мэтчилэн ахуй амьдралдаа эрчүүдийг хүндэтгэж дээдэлсээр ирсэн. Малгай бүсийг нь хүртэл, гэрийнхээ тэргүүний малгай бүсийг нь хүртэл эмэгтэйчүүд маань дээш нь хүндэлж тавьж байдаг аа.

Гэтэл одоо бол дэлхий нийтийн хөгжилтэй зэрэгцэж алхах хэрэгтэй байна аа. Өөрөөр хэлбэл 2015 онд сонгуулийн хууль батлагдаж байхад эмэгтэйчүүдийг 30 хувь гэж оруулж байсан юм аа. Гэтэл 2016 онд сонгуулийн урдхан талд сонгуулийн хуулийг өөрчлөхдөө 30 хувьд дэвших эмэгтэй олдохгүй нь ээ гэж хэлээд 20 хувь болгоод бууруулчихсан юм аа. Тийм учраас бид эмэгтэйчүүд ээ, манайх дамаа хамгийн том нам, одоо 100 жилээ хоёрхон жилийн дараа, жилийн дараа тэмдэглэх гэж байна. Тийм учраас бид намын дүрэмдээ байгаа 30 хувь гэснийгээ сонгуулиар 30 хувь нь эмэгтэйчүүд дэвшүүлье гэдгийг оруулж өгөх ёстой гэж бодож байна.

Өөрөөр хэлбэл ер нь дэлхий нийт эмэгтэй удирдагчдын уян хатан бодлогын ачаар хүнд байдлаас аврагддаг юм байна аа гэдгийг 1990 оны хямралаас хойш дэлхий нийтээр эмэгтэйчүүдийн хатан ухаан, удирдах авьяас чадварыг үнэлж эхэлсэн. Одоогоос 6 жилийн өмнө дэлхийн эдийн засгийн форумд эмэгтэйчүүд, эмэгтэй лидерүүд, бизнес, улс төрд олноор орох тусам дэлхий аврагдана гэж тунхаглаж байсан. Тэгэхээр энэ нь эмэгтэйчүүд удирдлагыг гартаа авах тусам дэлхийд энх тайван тогтож, энэрэнгүй нийгэм бий болно гэдэгтэй санал нэгдсэн хэрэг юм аа.

Түүнчлэн одоогоос 6 жилийн өмнө дэлхийн эдийн засгийн форумд эмэгтэй лидерүүд дэлхийг аврахад тус болох юм аа гэдгийг тунхагласныг дахин тэмдэглэж хэлье. Мөн Японд, Солонгост, Азийн орнуудад эмэгтэйчүүдээ удирдах түвшинд олноор гаргаж байгаа. Жишээ нь Японы Ерөнхий сайд Шин Зоо Абэ гэртээ хүүхдээ харж буй нуугдмал чадварлаг эмэгтэй боловсон хүчнээ дэмжих бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Үүнийгээ тэр хүн алдагдсан боломжийн цоожийг нээх гэсэн ийм нэр өгсөн. Тийм учраас эрчүүд ээ, та бүхэн маань өнөөдөр эмэгтэйчүүдийг 30 хувийн квоттой болгоод 2020 оны сонгуульд бүх намаас 30 хувь нь ямар ч байсан эмэгтэйчүүд дэвшихээр болгож энэ саналыг босгож өгч дэмжиж өгөөч ээ гэдгийг хэлмээр байна.

Эмэгтэй хүн бол өөрийнхөө асуудлыг ярьж байхдаа ч нийгмийн асуудлыг хөнддөг. Байгалиасаа ийм өгөгдөлтэй гэдгийг эрдэмтэн судлаачид хэлж байгаа. Тийм учраас та бүхэн энэ 30 хувийн унасан квотыг кнопоо дарахгүйгээр дэмжиж босгож өгөөрэй гэж эрчүүдээсээ гуйя. Монгол эмэгтэйчүүдийн угаасаа уламжлагдаж ирсэн эрчүүдээ хүндэлдэг тэр хүндлэл бол мэдээж алдагдахгүй.

Л.Энх-Амгалан: За, Пүрэвдорж гишүүн

Б.Пүрэвдорж: Яг энэ 31.2-ыг уншихаар ийм байна л даа. Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна аа гэж байгаа. Тэгэхээр манай МАН 30 хувийг дэмждэггүй нам л даа. Тэгэхээр энэ дээр болохоор аль нэг нь 20-оос доошгүй гэж байгаа юм. Эрчүүдийгээ 90 хувь болгочоод, аль нэг нь юм чинь эрчүүдийгээ 90 хувь болгосон, эмэгтэйчүүдээ 10 хувь болгож болно гэж уншигдахаар байгаа байхгүй юу. Тийм байгаа биз дээ, аль нэг хүйс нь 20-оос доошгүй гэхээр эрчүүд нь 90 байж болно, эмэгтэйчүүд нь 10 байж болно.

Бид нар хуулийнхаа заалтын дагуу аль нэгийг нь л 20-оос дээш гаргачихсан шүү дээ. Тийм 20-оос доошгүй гэж байгаа. Тэгэхээр шууд ингэж уншигдахаар байгаа биз дээ. Тэгэхээр эмэгтэйчүүдээ дэмждэггүй МАН яг энэ заалтын дагуу 10 хувийн эмэгтэйг оруулж ирнэ л дээ. Та нар яаж байгаа гэхээр 2020 оны сонгуульд манай ЖДҮ-чид багтахгүй, манай бөөн асуудал болно, тэгээд эмэгтэйчүүд орж ирнэ, манай нам навс ялагдана гэж үзээд энэ эмэгтэйчүүдийн квотыг хасах гээд л үзээд байгаа л даа.

Л.Энх-Амгалан: Пүрэвдорж гишүүн ээ буруу тайлбарлаж болохгүй шүү. 20-оос доошгүй гэж цагаан дээр хараар биччихсэн байгаа шүү дээ. Ингээд улс төрийн өнцгөөс битгий тайлбар хэлээд бай. Оюунхорол гишүүн

Д.Оюунхорол: Баярлалаа. Эмэгтэйчүүдийн квотыг дэмжиж зарчмын бодлогын шинж чанартай өгүүлбэр хэлж, саналаа хэлж, бодлоо хэлж байгаа бас Их Хурлын гишүүддээ талархлаа. Өнөөдөр улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог

нэмэгдүүлэх дэлхий нийтийн хандлага байгаа гэдгийг манай улс төрд байгаа бүх эрчүүд ойлгож байгаа. Өнөөдрийн энэ парламентын зааланд 83 хувь нь шийдвэр гаргаж, бодлого боловсруулдаг ийм эрчүүдийн төлөөлөл сууж байгаа. Бид бол цөөнх. Тийм учраас цөөнхөд хүндэтгэлтэй хандаж, зарчмын хувьд бид нарын дуу хоолой үгийг сонсоосой. Шийдэх эсэх кнопоо дарах нь та бүхний эрхийн асуудал аа.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлдэг олон хөшүүрэг аргууд байдаг. Бид нар үндсэн хууль хэлэлцэж байх үед сонгуулийн пропорциональ системийг аваач ээ, эмэгтэйчүүдийн квотыг энэ сонгуулийн пропорциональ системээр дэмжээд оруулчих боломжтой гэж үзэн, МАН-ын хувьд бас ийм саналыг, бодлогыг бол дэмжиж оруулж ирсэн. МАН-ын дарга Хүрэлсүхийн хувьд бол пропорциональ системийг оруулж байж улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог пропорциональ системээр дэмжиж өгье өө гэсэн ийм бодлого, зарчмыг барьсан гэдгийг энд бас онцлон хэлэхийг хүсэж байна.

Өнөөдөр олон улс орнууд хууль тогтоох байгууллагадаа эмэгтэйчүүддээ тусгай суудал хуваарилдаг. Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудаараа улс орнууд олон эмэгтэйчүүдийн квотоо дэмжиж оруулж ирдэг ийм бодлого явж байгаа юм аа. Тийм учраас бид нар эмэгтэйчүүдийн квотыг 20-ийг 30 хувьд хүргэх юм сан. Энэ бол өнөөдөр олон улсын гэрээ конвенцуудаар хүлээсэн Монгол Улсын үүрэг байгаа гэдэг талаас нь илэрхийлж байгаа.

2 дугаарт өнөөдөр дэлхийн 192 улсаас 120 улс нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх квот тогтоосон сонгуулийн систем хуулийг бол хэрэглэж байгаа юм аа. Нөгөө талаас энэ олон улсын байгууллагуудын туршлагыг бид нар судалж нэлээн харж байгаа. Тэгээд энэ дээр олон чухал бодлого шийдвэр санаанууд гарсан байдаг юм аа. Тийм учраас манай эрчүүд энэ дээр анхаарч өгмөөр байна.

НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилтуудын Womans энд politics гэсэн 2017 оны судалгаанаас 2016 оны байдлаар 193 эмэгтэй НҮБ-д өөрийнхөө улсыг төлөөлөн сууж байна. 25 улс эмэгтэй төрийн тэргүүн болон Ерөнхий сайдтайгаар өнөөдөр үйл ажиллагаагаа явуулж байна. Дани, Их Британи гэсэн 2 улс хатан хаантай байна аа. 11 улс эмэгтэй Ерөнхийлөгчтэй байна. 12 улс эмэгтэй Ерөнхий сайдтай болсон байна. Норвегийн парламентын гишүүдийн 50 хувь нь , засгийн газрын гишүүдийн 50 хувь нь эмэгтэй гишүүд ажиллаж байна. Канадын Ерөнхий сайд Засгийн газраа эрэгтэй, эмэгтэй сайдуудаар тэнцүү бүрдүүлсэн ийм олон сайхан жишээ нөгөө талаас гэвэл нь хөгжил нь тогтвортой явах боломжийг жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиудаараа зохицуулаад явж байгаа олон арвин туршлагауд байгаа юм.

Тийм учраас бид Монгол Улсынхаа хөгжлийг өөрчлөхийн тулд урагшаа тэмүүлэн зүтгэж буй эмэгтэйчүүдийн нэгэн эсийн төлөөлөл болж Монгол улсын Их хуралд сууж байгаагийн хувьд та бүхнийгээ дэмжиж бидний санал дээр хамтран ажиллаж өгөөсэй гэж хүсэж. За гадна талд бас энэ улс төр дэх оролцоотой байгаа, оролцох төрийн бус байгууллагууд, эмэгтэйчүүд маань биднийг харж байгаа учраас бид өнөөдөр дуу хоолойгоо Монголын эмэгтэйчүүдийг төлөөлж, Монголын Их хуралд сууж байгаа эмэгтэй гишүүд энэ саналыг бүгдээрээ гаргаж оролцож байгаа юм аа гэдгийг та бүхэндээ хэлж уламжилж энэ саналыг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Л.Энх-Амгалан: Одоо дэмжсэн 3, дэмжээгүй 3. Тэгэхээр дэмжээгүй л хүмүүс үг хэлнэ гэсэн үг шүү дээ. Тэгэхээр Цогзолмаа гишүүн дэмжиж байгаа юм байгаа биз дээ, тийм ээ. Энхбаяр гишүүн дэмжиж байгаа биз дээ, тийм. Ингээд санал хураалт хийх үү. Ганцхан дэмжихгүй квотоор л үг хэлнэ шүү дээ. Энхбаяр гишүүн.

Ж.Энхбаяр: Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийг дэмжиж байгаа. Ялангуяа 30 хувийг би бага байна гэж үзэж байгаа болохоор үг хэлж байгаа юм. Өнөөдөр дэлхий ертөнцөд олон улсад эмэгтэйчүүд сурахын төлөө, мэргэжил эзэмшихийн төлөө, бичиг үсэг

Л.Энх-Амгалан: Дэгээ сахиулъя тэгэх үү. Бусад чинь барьцаад байна шүү дээ. Бусад дэмжихгүй гэж үг хэлэх квот аваагүй гишүүд чинь өөртэй чинь барьцаж байна, өөрөө дэмжиж хэлээд байна шүү дээ. Тийм. За, санал хураалт. Би дэг сахиулах ёстой биз дээ. Тийм. Санал хураалт хийх үү. Санал хураалт.

44 гишүүн оролцож, 23 гишүүн зөвшөөрч, энэ санал унаж байна. Тийм учраас 20 хувийн босготой болж байна гэсэн үг. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүйг дэмжсэн байхгүй юу. Тийм.

5.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн "аль нэг хүйсийнх" гэсний дараа "5-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн" гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их хурлын гишүүн Батзандан, Л.Болд. Энэ чинь ижил утгатай юм байна шүү дээ. Сая унасан шүү дээ. За, Батзандан гишүүн.

Ж.Батзандан: За, Баасанхүү гишүүн бол түрүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг нэр дэвшигчийн 2-оос доошгүй хувь нь байлгах нь зүйтэй гэдэг санал гаргасан юм. ШИНЭ намын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн квотыг 5-аас доошгүй хувь нь байлгая гэдэг саналыг гаргасан боловч Байнгын хороон дээр өчигдөр дэмжлэг авч чадаагүй. Улсын Их Хурлын гишүүдээсээ хүсэх нэг зүйл байна.

Монгол Улсад 150 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Идэвхтэй сонгогчдын маань 10 орчим хувь гэсэн үг. Тэгэхээр Япон, Солонгос, Европын орнуудын нэгэн адил улс төрийн намууд нэр дэвшигчдийнхээ 5-аас доошгүй хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөл болгож оруулж ирээч ээ гэдэг саналыг хуулийн төсөлд тусгуулмаар байна. Бид дэлхийн хөгжлийн чиг хандлагаар урагшилъя. Олон жил хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн бодлогын анхаарлын гадна орхилоо. Шийдвэр гаргах түвшнээс үргэлж гадна орхилоо. Ийм учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн энэ квотыг тогтоосон заалтыг ШИНЭ намын санаачилгыг дэмжиж өгөөч ээ гэж хүсэлт гаргаж байна. Баярлалаа, та бүхэнд.

Л.Энх-Амгалан: Санал хураалт.

45 гишүүн оролцож, 29 гишүүн зөвшөөрч, 64,4 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

6.Төслийн 34 дүгээр зүйлд 34.10 дахь хэсгийг нэмэх:

"34.10.Эрүүгийн хуульд заасан охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, хүнийг алах, тагнуулын, эх орноосоо урвах, авлига, албан тушаалын эсрэг гэмт

хэрэг үйлдсэн хүнийг нэр дэвшүүлэхийг хориглоно." Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батзандан. За Батзандан гишүүн

Ж.Батзандан: Аюурсайхан гишүүний гаргасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, хуулийн хүчин төгөлдөр шийдвэрээр ял шийтгэл авч байсан хүнийг нэр дэвших эрхийг нь хязгаарлах тухай Аюурсайхан гишүүний санал, Баасанхүү гишүүний санал дэмжигдсэн гэж би сонссон.

Миний хувьд бол энэ санал дээр нэмж, эрүүгийн хуульд заасан охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, хүн амины гэмт хэргийг санаатай үйлдсэн, эх орноосоо урвах, эх орныхоо эсрэг тагнуул хийх гэх гэмт хэргийг бас нэмж оруулах саналтай байгаа юм.

Улсын Их хурал бол гэмт хэрэгтнүүдийн цугладаг үүр байж болохгүй. ийм учраас эдгээр гэмт хэргийг нэмж оруулах нь зүйтэй гэдэг гэмт хэрэг үйлдсэн эдгээр нөхдүүдийг Улсын Их хуралд нэр дэвших эрхийг нь хязгаарлах нь зүйтэй гэдэг саналыг ШИНЭ намын зүгээс оруулж байна. Та бүхэн дэмжиж өгнө гэдэгт итгэж байгаагаа илэрхийлье.

Л.Энх-Амгалан: Баасанхүү гишүүн

О.Баасанхүү: Би шулуухан хэлэхэд энэ Монгол Улсын хуулийг баримаар байгаа юм. Монгол Улсын хууль дээр төрийн албаны тухай хууль бас бус хууль байгаа юм. Нэг талаасаа хүнийг насаар нь гэмт хэрэгтэн гээд залуудаа хүүхэд байхдаа санаатай санамсаргүй үйлдэл хийсэн байж болзошгүй тийм зүйлүүдээр хүнийг насан туршид нь яллаж болохгүй ээ. 1 дүгээрт.

2 дугаарт гэвэл би боол биш. Оюун-Эрдэнэ мессеж бичихээр Нямдорж нүд ирмэхээ сандарч тэвддэг тийм нохой биш. Шулуухан хэлчихье. Би тэр Аюурсайханы санал дээр давхар санал гаргаагүй ээ. Би үүнийг бол маш олон удаа хэлсэн. Харамсалтай нь нөгөө хэн нэгний нохойн баас шиг ингэж ханддагаа боль. Би маш тодорхой ганцхан зүйл хэлж байгаа юм. Тэр нь ямар зүйл хэлж байгаа вэ гэвэл 3 санал гаргасан, одоо миний саналын 2 нь одоо ороод ирнэ. Түүнийгээ би тайлбарлана аа.

Миний хэлээд байгаа санал бол мэдээж хүн хүчиндсэн хүн юу гэж орох юм. Тэр баталгаатай, тагнуул бол юу гэж орох юм. Авлига бол юу гэж орох юм. Зүгээр манай Ерөнхийлөгч бол хүн амины гээд Эрдэнээгийн эсрэг явж байгааг бид бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Тэр нь бол хувь хүнд зориулж байгаа гэдгийг нь мэдчихээд өнөөдөр сандарч тэвдээд, Эрдэнээ гэдэг үгийг л оруулчих л даа. Тэгээд л тэгвэл Эрдэнээд дуртай дургүйгээрээ хуваагдчихъя л даа. Тийм учраас ийм хошин санал гаргааа боль оо. Миний найз. Би бас зарчимтай хүн шүү. Шулуухан хэлчихье. Би бүх хүнд хэлж байна. Зарим нэгэн нөхдүүдийн ямар нэг юм дуугараад байгаа бол түүнийг чинь би бас тодорхой хэлье.

Л.Энх-Амгалан: За санал хураалт.

Дэмжиж байж энэ санал дэмжигдэхгүй гэсэн үг шүү дээ.

45 гишүүн оролцож, 23 гишүүн зөвшөөрч, 51,1 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

7. Төслийн 34 дүгээр зүйлд 34.1.10 дахь хэсгийг нэмж, дугаарыг өөрчлөх:

“34.1.Бүх шатны сонгуульд оролцоход өөрөө болон тухайн үед сонгуулийн штабт ажиллаж байсан этгээд нь сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн талаарх шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч байсан бол.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баасанхүү. Санал хураалт. За, Баасанхүү гишүүн. Санал хураалтыг цуцалж байгаа шүү. Баасанхүү гишүүн

О.Баасанхүү: Би ингэж бодож байна. Шулуухан хэлчихье. Бүх шатны сонгуульд оролцохдоо хүн мөнгө өгөхөө больё оо, хүний өмнөөс очиж янз бүрийн сонгуулийн хууль зөрчихөө больё оо, шүүхийн шийдвэрээр тэр нь асуудал үүсгэх юм бол дараагийн сонгуульд орохоо больё оо гэдэг ийм л заалт байгаа юм. За энэ дээр штабт ажиллаж байсан гэсэн юм байсан. Тэрийг нь хасаж болно. Дэмжчихээд бүгдээрээ үүнийг шийдье. Энд байгаа хэд байдаг юм, 65 байна уу, 76 байна уу хэдэн хүн байгаа юм. Тэд нар дэмжчихээд засаж болохгүй юу. Тэгэхгүй болохоор сонгуулийн үед хууль зөрчихөөд дараагийн сонгууль дээрээ орёо л гэдэг шүү дээ. Хонгил гэж баахан хуцчихаад яг цагаа тулахад дандаа хулгайч нарыг суулгаад л өнөөдөр ний нуугүй хэлэхэд надад нэг шүүгч хэлж байсан. Одоо алуурчныг шоронд хийхээсээ айж байна. Яагаад гэвэл маргааш нь гарч ирээд намайг шүүх вий дээ гэж.

Төрийн ордонд орж ирээд хэвлэлийн хурал хийгээд солиорох вий дээ гэж. Үгүй юм аа гэхэд буланд очоод хутга шаах вий дээ гэж. Түүн шиг өнөөдөр юу гэдгийн сонгуулийн хуулиа ноцтой зөрчсөн бол болчихъё л доо. Зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон болчихъё л доо. Би ийм л юм ярьж байгаа, ийм л юм хүсэж байгаа юм. Би өөр юу хүссэн юм. Энэ зүйлийг өнөөдөр дэмжихгүй ээ гэж байгаа хүмүүсийг би ойлгохгүй байна. Өөрөөр хэлэхийн бол Их Хурлын гишүүн байх уу, байхгүй юу гэдэг өмнөх хууль дээр байсан.

Одоогийн хууль дээр 1 дүрэм үйлчилмээр байна. Тэр нь юу вэ гэвэл шүүхээр мөнгө тараасан, хууль зөрчсөн, бусдыгаа гүтгэсэн 9 шидийн юм болсон нь шүүхээр тогтоогдсон бол сонгуульд орохоо больчихъё л доо. Улс төрөөс хол амьдар л даа. Сайхан амьдар л даа. Гос амьдар л даа. Улс төрд заавал орох ёстой юм шиг миний эрх л байх ёстой, би залуудаа хулгай хийсэн юм, одоо хулгай хиймээргүй байна. Би одоо юу гэдгийн тэр үед төрийн албанд байсан, одоо би өөрт болсон ч гэдэг юм уу 9 шидээрээ баймааргүй байна.

Би дахиад хэлье. Би бол хэн нэгний дохиогоор явахгүй ээ. Тийм учраас та нар дохиогоор биш бол үүнийг дэмжээгүй саналыг дэмжихгүйгээр ороод өгөөч ээ гэж би хүсэж байна. Тэгээд найруулъя. Би бас санаа зовж байна. Би өнөөдөр 500 хүнийг хянаад хэн нь миний өмнөөс гэдэг нэрээр даргыгаа гараасай гэж одоо мөнгө тараахыг би мэдэхгүй. Миний даргыг дэмжээрэй гээд мөнгө өгөхийг мэдэхгүй. Би ямар ч үүрэг чиглэл өгөөгүй. Тэгсэн гайтай юм шиг тэр нь баригдсан бол би яах юм. Нөгөө хүн нь би дарга гарвал төрийн албанд орчих болов уу, би ингэчих болов уу энээ тэрээ гэж бодсон юм аа уучлаарай л биз дээ.

Тэгэхээр бусдын гайг өөртөө үүрэхээ больё. Өөрсдөөрөө гэдгээ тогтоочихъё. Үүнийг дэмжээд өгөөч ээ, босгоод өгөөч ээ. Энэ дээр бүгдээрээ саналаа нэгтгэе ээ гэж байгаа юм. Тэгээд бид нар гэмт хэрэг хийхгүй, бид нар хууль зөрчихгүй, хийвэл дахиж сонгуульд орохгүй гэдгээ нотлоод өгвөл амар юм биш үү. Үгүй юу. Би ийм л юм ярьж байгаа юм. Болох уу болохгүй юу.

Л.Энх-Амгалан: За, Баасанхүү гишүүн үг хэллээ. Санал хураалт. Дэмжээгүй саналыг дэмжиж байж. Дэмжихгүй бол босгоно гэсэн үг шүү дээ, тийм ээ. Тийм.

44 гишүүн оролцож, 27 гишүүн оролцож 61,4 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Одоо цөөхөн санал үлдлээ. Шууд санал хураалт хийгээд дуусгая. 10 хүрэхгүй санал л үлдэж байна. Яах вэ дагасан хулиуд байгаа шүү дээ. Түүн дээр 14 л байгаа юм байна. Тогтохсүрэн гишүүн ээ.

8.Төслийн 34 дүгээр зүйлд 34.10 дахь хэсгийг нэмж, дугаарыг өөрчлөх:

“34.10.Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар яллагдагчаар тогтоогдсон нөхцөл байдал нь Улсын ерөнхий прокурорын зүгээс сонгуульд нэр дэвшихэд саад учруулна гэсэн албан бичиг Сонгуулийн Ерөнхий хороонд ирсэн бол.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баасанхүү.

О.Баасанхүү: За, одоо үүнийг бол ёстой дэмжмээр байна аа. Өнөөдөр АТГ ажил хийхгүй байгааг бид ойлгож байгаа. МАНАН мафитай тэмцээд бид нар ерөнхий прокурор, авлигатай тэмцэхээ сольсон ч гэсэн харамсалтай нь карманы хүнээ тавьсан. Өчигдөрхөн миний санаж байгаагаар бол ерөнхий прокурор ажлаа хийхгүй байна аа гээд орилж байсан. За авлигатай тэмцэхийн дарга ч ажлаа хийхгүй байгааг би ойлгож байгаа. Бүх авлигачдыг оруулж ирэхгүй байгаа. Тийм учраас тайван байж болно. Гэхдээ магадгүй гэгээрээд ухаараад гэнэтхэн авлига албан тушаалын хэргээ шалгаад шүүх рүү яг орох гэж байсан чинь энэ хүн чинь Их Хуралд ороод хөөн хэлэлцэх хугацааныхаа хамгаалалтад орох гээд байна аа гээд. Та нарын нөгөө хэлдэг хадны мангаанууд.

Баярцогт, Сайханбилэг, Элбэгдорж өөр хэн хэн ч билээ гээд Монгол чинь бүх хүн хулгайч биш, хэдэн хүн хулгайч байгаа шүү дээ. Тэгээд тэр хүмүүс чинь ороод ирнэ шүү. Тэгэхгүйн тулд та нарт өгсөн боломж. Ерөнхий прокурорт бичгээ өгье. Нөгөө цензургүй сурвалжлаг шиг. Тэгээд л түдгэлзүүлээд л тэр гэм буруутай, гэмт буруутайгаа тогтоогоод л дараа нь гарсан нь нөхөн төлбөрөө нэхье л дээ. Би сонгуульд орвол ийм байсан юм энээ тэрээ гээд л яваг л даа. Ерөнхий прокурорт бичиг өгөөд, уг нь бол би яагаад энэ АТГ-ыг буруутгаад байгаа вэ гэвэл энэ ажлын хэсэг чинь уг нь АТГ-ын ямар нэгэн хүн сууж байх ёстой шүү дээ.

Зурагтаар гараад нөгөө чүдэнз зурдаг Амараагаар юм ярьж ярьж байхынхаа оронд нөгөө Баярхүү ч билүү нэг нөхөр гарч ирээд хэвлэлийн хурал хийж байхынхаа оронд нөгөө мөнгө угаасан гэдгийг би угаагаагүй энэ бол хадгаламждаа хийсэн гэдэг тайлбар хийж байхынхаа оронд энд орж ирээд миний энэ яриад байгаа 3 саналыг өгсөн бол би өнөөдөр Намбарын Энхбаяр, Халтмаагийн Баттулга одоо хэн байдгийн тэр нөхдүүдэд адлагдахгүй байсан юм аа. Харамсалтай нь тэр хүмүүсийн өмнөөс би ажил хийснээс болоод тэр хүмүүс намайг буруутгаж байгаа юм. Яагаад гэвэл чи авлигатай тэмцэж байна, ямар муухай юм бэ гээд 9 шидээр нь ярьж утасдаж байгаа. Хэвлэлээр ярьж байгаа. Би юу хүсээд байгаа вэ гэвэл та нар зурагтаар гарахдаа хэрвээ үүнийг дэмжихгүй бол хулгайчийг дэмждэг хүмүүс шүү.

Би ийм л юм яримаар байна. Би ганцаараа байгаа. Хошин шогоо хий. Доромжил. Сая Оюун-Эрдэнэ намайг зодъё барья гээд л орилж байна лээ. Чадах ч үгүй, тэр нохой. Зүгээр би хэлж байна шүү дээ.

Л.Энх-Амгалан: За санал хураалт. Үг хэлж дууслаа.

44 гишүүн оролцож, 31 гишүүн зөвшөөрч, 70,5 хувиар энэ санал

дэмжигдсэнгүй.

9. Төслийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсгийн “хийсний дараа” гэсний дараа “баруун долоовор хуруун дээр санал өгсөн гэсэн тэмдэглэгээ хийлгэх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их хурлын гишүүн Пүрэвдорж. За Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: 2008 оны 7 сарын 1-нд болсон тэр их үймээн юунаас үүдэлтэй вэ гэхээр маш их олон хүмүүс иргэний үнэмлэх дээрээ наалт наагаад олон газар очиж сонгууль өгсөнтэй холбоотой. Энэ нь батлагдсан. Тийм учраас энэ тэмцэл гарч нэлээн асуудал болсныг бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр өнөөдөр та бүхэн энэ цахим хөгжсөн, ийм үед бол энэ хурууны хээний асуудал бол нэг тийм асуудал биш ээ. Албан газрын нэг жижүүр эмэгтэй бүх хуруун дээрээ бүх ажилчдынхаа хурууны хээг хийчихсэн тэгээд Дулмаа ирсэн, Дондог явсан гээд бүгдийг нь ингээд тэмдэглээд явж байдаг шиг нэг иргэний үнэмлэх барьж очоод түүнийгээ долоовор хуруугаараа нөгөө үнэмлэхийг барьж очоод ядам хуруугаараа, долоовор хуруугаараа хийгээд хэд хэдэн газар санал өгөөд түүнийгээ компьютер янз янзын программын тусламжтай хийж болох байхгүй юу.

Үүнийг Тагнуулын ерөнхий газар хянана гэж байгаа юм. Ер нь бол сонгуулийн будилаан янз бүрийн юмыг тагнуулынхаа байгууллагатай хамтраад хийгээд явдаг шүү дээ. Ийм зүйл байгаад байгаа юм. Тийм учраас энэ тэмдэглэгээг хийх нь бол маш чухал юм аа. Ялангуяа жижиг бага намууд энэ хүн хүч багатай намууд бол хурууны хээ дээр нь хуруун дээр нь түрхсэн түрхлэгийг нь үзээд энэ санал өгсөн нөхөр дахиж орох гэж байна гэдгийг нь харж хянаад явах ийм боломж нь бүрдэх юм л даа. Илүү хяналттай болно, санал хураалт илүү сайжирна гэж би харж байгаа. Тийм учраас энэ тэмдэглэгээ хийх энэ заалтыг дэмжиж өгөөч ээ гэж та бүхнээс хүсэж байна.

Л.Энх-Амгалан: Энэ өчигдөр Байнгын хороон дээр СЕХ тайлбарласан шүү дээ. Могол Улсад бол ингэх шаардлагагүй болсон. Энэ бол технологийн дэвшил, хурууны хээ, регистрийн дугаар, иргэний үнэмлэхээр санал өгч байгаа учраас ямар нэгэн эргэлзээ тээнэгэлзээ алга болсон. Тийм учраас бид нар ингэж тэмдэглэгээ хийх шаардлагагүй гэж хэлж байгаа. За санал хураалт.

44 гишүүн оролцож, 32 гишүүн зөвшөөрч, 72,7 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

Одоо хамт өргөн мэдүүлсэн хууль дээр цөөхөн хэдэн саналууд байна. Үүнийг цөмөөрөө санал хураалт хийчихье.

**Гурав. СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАПААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн "гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2.1 дэх заалтын “сонгуулийн тухай” гэсний дараа “болон Улсын Их Хурлын сонгуулийн тухай” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

44 гишүүн оролцож, 32 гишүүн зөвшөөрч, 72,7 хувийн саналаар энэ санал

дэмжигдэж байна.

**Дөрөв.ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн "8.3.8.Сонгууль" гэснийг "ээлжит бус, дахин, нөхөн сонгууль," гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

43 гишүүн оролцож, 32 гишүүн зөвшөөрч, 74,4 хувиар энэ санал дэмжигдэж байна.

**Тав.ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 46.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"46.4.Төрийн жинхэнэ албан хаагч нь Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн, дахин сонгуулийн тухайд энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө төрийн албанаас чөлөөлөгдсөн байна." Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

44 гишүүн оролцож, 33 гишүүн зөвшөөрч, 75 хувиар энэ санал дэмжигдэж байна.

**Зургаа. АВИЛГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ**

1.Төслийн 2 дугаар зүйлээс "11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн "11.2 дахь хэсгийн "Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална." гэж, мөн зүйлийн" гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулга бүхий 3 дугаар зүйл нэмэх:

3 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"11.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална." Санал гаргасан ажлын хэсэг.

За, Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: За баярлалаа. Нэр дэвших юм байна. 76 хүн. 34-өөр үржүүлбэл гурван долоо юу гэдгийн 21 гээд ойролцоогоор 2000 гаруй хүн дэвших

юм байна. Дэвшсэн бүх хүн АТГ хөрөнгө, орлогын мэдүүлгээ өгөх юм байна. Тэгээд хадгалах юм байна. Хадгалаад яах гэж байгаа юм. Асуулт нь энэ шүү дээ. 76 хүн гарна. Үлдсэн нь хадгална гэсэн нь юу гэсэн үг вэ. Асуулт нь энд л байхгүй юу. Хадгална гэдэг үг байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт нь авлигатай тэмцэх хадгалж байтугай бүртгэж яах гээд байгаа юм. Улсын Их хурлын гишүүд жил болгон бүртгүүлсэн, төрийн албан хаагч нар бүртгүүлсэн, дээрээс нь юу вэ гэх юм бол өнөөдөр нэр дэвшсэнийхээ төлөө хөрөнгөө мэдүүлэх ямар хэрэгтэй юм. Хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгэх. Та нар сая ганц юмыг бол эсэргүүцчихсэн шүү дээ.

ЖДҮ-цсэн, энээ тэрээ 9 шидийн юманд орооцолдсон хүмүүсийг Улсын ерөнхий прокурорт бичиг явуулаад шүүхэд орох гэж байгаа хүмүүс шүү болиод өгөөч ээ, би үүнийг шүүх хурлаар орох гэсэн чинь хөөн хэлэлцэх хугацааны хамгаалалтад орох гээд байна аа, үүнийг болиод өгөөч ээ гэхийг бол та нар дэмжээгүй, тэгсэн хэр нь бүртгэж яах гээд байгаа юм. Өө энэ ямар баян юм, энэ нь ямар ядуу юм, нээрээ энэ хошин шон юм даа, ялагдах нь аргагүй юм даа гээд шоолох гээд байгаа юм уу. Энэ бол маш хошин шог заалт шүү. Хэлбэрийн төдий.

Авлигатай тэмцэхийн хуульд ийм өөрчлөлт оруулах ямар хэрэгтэй юм. Гишүүн болбол автоматаар бүргүүлнэ. Гишүүн болоогүй бол больчихно. Тэгээд 25 насанд хүрсэн хазгар доголлон ч байсан хүн сонгуульд нэр дэвшинэ гэсэн. Харамсалтай эмэгтэй хүмүүсээ бол онцгойлоод 20 хувийг оруулъя, гаргүй, өрөөсөн хуруугүй, юу гэдгийн санамсаргүй юу гэхийн магадгүй саажилт авсан хүмүүс бол дэвшиж болохгүй гээд та нар сая баталлаа шүү дээ. Ингэж болох юм уу. Энэ бүртгэж байгаа гэдэг чинь бол зүгээр хэлбэр шүү.

Авлигатай тэмцье гэж байгаа бол Улсын ерөнхий прокурорын бичгийг та нар үндэслэж авах ёстой. Түүнээс би авлигатай тэмцэхийнхэн энэ бүртгэлийг хараад бид нар одоо юу гэхийн Монгол хүнийхээ хувьд хэлэхэд сая нөгөө тийм сайт дээр гарч байна лээ л дээ. Нэг жоохон охин 80 сая төгрөгийн хувцас өмсдөг гэж шоолдог шиг өө энэ нэр дэвшиж байгаа гарууд ёстой баян, ядуу юм байна даа гэж хэлэх гээгүй л юм бол ямар эрх зүйн үр дагавар, үндэслэл үүсэхгүй. Ямар ч шаардлага байхгүй.

Төрийн албанд ороод сонгогдсон бол болж байна. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулиар тийм л байгаа. Одоо бүртгүүлэх гээд бөөн очер болох нь л дээ. 2000 хүн АТГ-ын гадаа очоод Дашдаваатай уулзах юм байна л даа. Ах аа минийхийг эхэлж бүртгээрэй, тэгэхгүй бол очерын өмнө хойно оръё гэж. Тэгж болохгүй ээ. Тэр хүн завгүй, допингийн асуудал хөөцөлдөөд завгүй байгаа. Тэр хүн өнөөдөр авлигачидтай тэмцэхгүй. Тэмцэхийг хүсэх ч үгүй. Тэр хүн өнөөдөр Хэрэг эрхлэхийн сайдтай уулзаад завгүй байгаа. Тэр хүн Ерөнхийлөгчөөс ямар нэгэн добра аваагүй бол хөдлөхгүй, ийм л хүмүүсийг та нар тавьсан, тавьж байгаа. Тийм учраас хэзээ ч энэ явахгүй. Явах боломжгүй. Хатуу үг хүнд хэцүү ч гэсэн та нар ойлго. Тийм учраас нэр дэвшиж байгаа хүмүүсийн хөрөнгийг мэдэж яах гээд байгаа юм. Ядуу ч байна уу, гуйлгачин ч бана уу, баян ч байна уу, хулгай ч байна уу дэвшье л дээ. Хулгайч байсан ч гэсэн дэвшиж болно гээд хууль оруулчихаад одоо ийм нэг бүртгэлийн

Л.Энх-Амгалан: За, санал хураалт.

44 гишүүн оролцож, 28 гишүүн зөвшөөрч, 63,6 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Саяын санал хураалттай холбоотой сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэд нэр дэвшихгүй эрхийг нь хааччихаж байгаа юм шиг ийм буруу ойлголт бас энэ сошиалаар явж эхлээд байна л даа. Үгүй шүү дээ. Үндсэн хуулиар бол Монгол Улсын иргэн л бол сонгох сонгогдох нь бүрэн эрх нь байгаа шүү. Ингэж буруу мэдээлэл тарааж болохгүй шүү.

Долоо. ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Төсөлд "Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "заасан хэмжээгээр" гэсний дараа "шүүх," гэж нэмэх." гэсэн агуулга бүхий заалт нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

44 гишүүн оролцож, 32 гишүүн зөвшөөрч, 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 1,6, 11 дэх хэсгийн "учруулсан" гэсний дараа, 4 дэх хэсгийн "явуулсан" гэсний дараа, 15, 16 дахь хэсгийн "оруулсан" гэсний дараа, 23 дахь хэсгийн "тараасан" гэсний дараа, 31 дэх хэсгийн "устгасан" гэсний дараа, 47 дахь хэсгийн "хийсэн" гэсний дараа, 74 дэх хэсгийн "хэрэглэсэн" гэсний дараа "нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй" гэж, 30, 31, 32 дахь хэсгийн "бол" гэсний дараа "учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж" гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

43 гишүүн оролцож, 33 гишүүн зөвшөөрч, 76,7 хувиар энэ санал дэмжигдэж байна.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлд заасан зөрчилд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээг Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон зөрчлийн хуулийн шийтгэлийн бодлогыг зарчмын хүрээнд нийцүүлэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн харьцаанд нийцүүлэн хэмжээг өөрчлөх:

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "хоёр зуун" гэснийг "хоёр мянган" гэж, 3, 7, 8, 9, 51, 53, 59, 60, 61,62, 67 дахь хэсэгт "арван" гэснийг "дөрвөн" гэж, 5, 15 дахь хэсэгт "дөчин" гэснийг "нэг зуун" гэж, 6, 16, 50, 52, 78.3, 79, 80 дахь хэсэгт "дөчин" гэснийг "нэг зуун" гэж, 14 дэх хэсэгт "таван" гэснийг "нэг мянган" гэж, "дөчин" гэснийг "арван" гэж, 18, 27, 28, 31, 32, 33, 36 дахь хэсэгт "хорин" гэснийг "тавин" гэж, 19 дэх хэсгийн "таван" гэснийг "арван" гэж, "хорин" гэснийг "нэг зуун" гэж, 10, 11, 12, 13, 20, 21, 22, 72, 73, 74, 75, 76 дахь хэсгийн "дөчин" гэснийг "тавин" гэж, 23 дахь хэсгийн "хоёр" гэснийг "таван" гэж, "хорин" гэснийг "тавин" гэж, 29, 30, 34, 35 дахь хэсгийн "таван" гэснийг "хоёр" гэж, 37 дахь хэсгийн "хорин" гэснийг "нэг зуун" гэж, 41.7, 43.6, 44, 45, 46, 47 дахь хэсгийн "нэг" гэснийг "хоёр" гэж, 42 дахь хэсгийн "хорин" гэснийг "арван" гэж, 49 дэх хэсгийн "хорин" гэснийг "дөчин" гэж, 64, 69 дэх хэсгийн "арван" гэснийг "таван" гэж, 68 дахь хэсгийн "арван" гэснийг "хоёр" гэж, 71 дэх хэсгийн "тавин" гэснийг "нэг зуун" гэж, 81 дэх хэсгийн "гучин" гэснийг "нэг зуун" гэж, 82 дахь хэсгийн "дөчин" гэснийг "хоёр зуун" гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. За, Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 130 гээд нэг заалт байсан юм аа. 2005 онд хүчин төгөлдөр байж байгаад 2015 онд хүчингүй болсон. Тэр

заалт дээр сонгуулийн үйл ажиллагааг санаатай будилаантуулбал санаатайгаар гэдэг нь юу вэ гэвэл хоорондоо одоо юу гэдгийн 60 тэрбум авъя юу юу ч гэдгийн 9 шидийн балай юм ярих, үгүй бол хэнд мөнгө төгрөг өгөх, барих гэх юм бол 1-20 сараар ч билүү баривчлах тийм ялтай байсан юм.

Тэрийг манайхан бол террорист буюу төрийн эсрэг онц ноцтой гэмт хэрэг гэж одоогийн хуулиар бол 20 гэдэг заалт руу оруулсан юм. Өөрөөр хэлэхийн бол 16-20 жилийн ялтай болгосон.

Тэгсэн одоо энэ оруулж ирж байгаа хуулийн заалтыг харах юм бол 20-ийн хажууд бол хошин шог. Хошин шогийн хажууд бол бүр хошин шог болчихоод байна л даа. Өөрөөр хэлэхийн бол 20 саяар торгоё, 5 саяар торгоё, 8 саяар торгоё, 10 саяар торгоё, 1000 нэгж, 5 нэгж, 10 нэгж л гээд байгаа боловч, үржүүлэхийн бол 1000-ыг үржих нь 1000 10 сая төгрөг. Ийм л юм явж байгаа шүү дээ. Сонгуульд орох болохоороо торгууль. Сонгуулийн дараа ялах болохоороо шоронд хийе гээд та нар одоо Сандуй гэдэг нэг хөөрхий дөө буруу зөрүүгүй ярьсан ч гэсэн шоронд 4 жилийн ял авсан залуугаа бодоорой. Шившиг шүү дээ. Ардын нам өнөөдөр миний харж байгаагаар бол төрийн албыг наймаалсан уу үгүй юу би мэдэхгүй. Наймаалсан уу үгүй юу гээд дансыг нь шалгачих гэхээр шалгаагүй мөртөө улаан цайм

Л.Энх-Амгалан: Яг энэ хуулийнхаа заалттай холбож ярь л даа. Санал хураалт гишүүд ээ. Санал хураалт.

41 гишүүн оролцож, 26 гишүүн зөвшөөрч, 63,4 хувиар энэ санал дэмжигдэж байна. За одоо ерөөсөө 9-хөн санал гишүүд ээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 43.4 дэх заалтын “энэ” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

41 гишүүн оролцож, 27 гишүүн зөвшөөрч, 65,9 хувиар энэ санал дэмжигдэж байна.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 38 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.Нэр дэвшигч нь сонгуулийн хуульд заасан цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлээгүй, бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. За санал хураалтыг цуцалъя.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Баасанхүү гишүүн заалт бүр дээр хангалттай 5 минут өгч байна шүү дээ, тийм.

Б.Бат-Эрдэнэ: Ер нь хамаагүй яарч хэрэггүй байх аа. Цаг сунгаад орой болтол Их Хурал чинь хуралдаад байж болоод байсан санагдаад байх юм. Одоо нийгмийн хурд ийм болчихсон юм уу. Манай Их Хурлын ажил, гишүүдийн ажил ийм яаруу байна уу. Одоо хурдал, түргэл гээд ингээд шаардаад шахаад байх юм. Бушуу туулай борвиндоо юутай гэдэг билээ. Одоо энэ заалтыг бол би дэмжиж

байгаа. Гэхдээ түрүүн тэр төслийн 48.11-д бол цахим орчныг хязгаарлахтай холбоотой ийм заалт орчихлоо гэж ойлгоод байгаа шүү дээ. Сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш хязгаарлалт тавиад тэгээд сонгууль санал авсны маргааш өдрийг дуустал хязгаарлалт авна аа гэж.

Би түрүүн энэ хуулийн төсөл хэлэлцээд эхлээд Байнгын хорооны санал дүгнэлт уншсаны дараа би асуусан шүү дээ. Энэ одоо бол ерөөсөө энэ сошиал орчин цахим ертөнц гэдэг чинь бол ямар нэгэн байдлаар хамаагүй хязгаарлалт тавьж хориглолт хийж болохгүй шүү. Энэ чинь бол бид нар амьсгаа авч байгаатай адилхан агаар бидэнд хэрэгцээтэй адилхан ийм нөхцөл байдал шүү. Энэ олон мянган залуучууд, энэ чинь залуучуудын орон гэж ярьдаг. Энэ улс төрийн сонгуулиас чинь илүү тэр хүмүүсийн чинь өдөр тутмын ажил бизнес, энэ мэдээлэл авах эрхийг нь ингэж хааж болж байгаа юм уу гээд би үг хэлэх гээд надад олдохгүй байгаа юм л даа. Тэгэхээр зэрэг үүнийг хэлэлцүүлгийн явцад анхаарах юм байгаа биз. 1 дүгээрт.

2 дугаарт энэ оруулж ирж байгаа саналыг бол би дэмжиж байгаа. Яг өөрийнхөө нэрээр цахим хаягаа нээнэ ээ гэдэг. Энэ бол мэдээж ойлгомжтой асуудал. Нөгөө талд нь одоо улс төрийн намууд, энэ улс төрчид бол хэчнээн зуугаар нь нөгөө тролууд гэж нэрлэдэг хүмүүсээ одоо байшин хашаа нөгөө сая 800 Хятад орж ирээд баригдаад гарлаа гэж байгаатай адилхан энэ Монголын ирээдүй болсон залуучуудыг чинь хэдэн зуугаар нь суулгаад тэгээд өөрсдийгөө магтан дуулдаг, бусдыг гүжирдэн гүтгэдэг, тэр коментуудыг бичүүлээд л ингээд сууж байдаг энэ юм аа яах юм бэ. Энэ юм аа бас давхар бодохгүй бол болохгүй асуудал шүү.

Түрүүн би бас одоо үг хэлэх гэж байсан, надад үг хэлэх бололцоо олдсонгүй. Тэр шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр тогтоол шийдвэртэй ийм хүмүүсийг сонгуульд дэвшүүлэхгүй нь ойлгомжтой. Гэхдээ тэр Намбарын Энхбаяр гэж одоо ганц хүний эсрэг асуудал яриад байгаа бол энэ байж таарахгүй шүү. Өнөөдөр тухайн үедээ шийдэгдсэн нөгөө МАНАН бүлэглэл, хонгил, одоо нөгөө хонгилын удирдагч, нөгөө хүн чинь бол одоо бас асуудал яригдаад байгаа шүү дээ.

Тэгээд энэ чинь Зоригийн хэргээс өгсүүлээд ямар хэлмэгдэл явуулж байсан гэдэг чинь нийгэмд өнөөдөр ил тод болоод эхнээсээ асуудлууд нь эргэж буцаад байгаа шүү дээ. Тэгээд ийм нөхцөлд одоо МАХН-ын дарга тэр ганц хүний эсрэг ийм хуулийн заалт байх юм бол таарахгүй гэсэн зүйлийг би хэлье гэж бодоод байсан. Надад үг өгөөгүй л дээ.

Л.Энх-Амгалан: За одоо санал хураалт гишүүд ээ. Өөрөө кнопоо дар л даа. Би нэр хаачихсан шүү дээ. Би дэг сахиулах үүрэгтэй шүү дээ. За санал хураалт.

41 гишүүн оролцож, 25 гишүүн зөвшөөрч, 61 хувиар энэ санал дэмжигдэж байна.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 48 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг банканд нээлгэсэн сонгуулийн зардлын дансанд хуульд заасны дагуу төвлөрүүлж, зарцуулах талаар тогтоосон журмыг зөрчсөн хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,

хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно." Санал гаргасан ажлын хэсэг. За, Баасанхүү гишүүн. Зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж.

О.Баасанхүү: Миний юу ярихыг урьдчилж мэдэж байгаад баярлалаа. Өөрөөр хэлэх юм бол би мэдээж хэлэлцэж байгаа асуудалтай ярина л даа. Өөрөөр хэлэх юм бол би юу хэлэх гээд байгаа гэвэл дансанд хууль бусаар мөнгө оруулаад ирэхээр их зовлонтой л доо. Хэн оруулаад ирсэн нь мэдэхгүй. Сурталчилгаа хийж байгаад л мөнгөгүй болонгуутаа сандраад л түрийвчээ ухна гэдэг шиг дансанд юу байгаа бол гэсэн чинь үл таних, хайрын захиа гэдэг шиг мөнгө ороо ирдэг. Хаяг байхгүй, адрес байхгүй. Тэгээд сандраад наадахыг нь буцаач гээд бараг 2 өдрийн ажил болдог юм билээ. Нөгөөдхийг нь арай гэж буцаагаад, за буцааж чадахгүй бол мөнгийг нь аваад 4 саяар торгох юм байна л даа.

Хууль та нарт сайнаар үйлчилнэ ээ. Хууль надад муугаар үйлчилнэ. Нөгөө нэг таныг бол тэнгэр хаб гээд авна, манийг бол ингэнэ гээд хар тамхичин бол таныг гаргана гэдэг шиг л юм болж байна. Том даргын хар тамхичин байвал та гарна, жижиг даргын жирийн нөгөө нэг тэвнэ хулгайлсан хүмүүс шоронд орно гэдэг шиг л юм болж байна.

Тийм учраас энэ хуулийн заалтыг эргээд хараач ээ. 1 дүгээрт нь. Энэ бол та нар юу гэж бодож байгаа вэ гэвэл 1 дансны хэрүүл гэж л ойлгож байгаа боловч уг нь бол хуулиар ямар байх вэ гэвэл хүн хувийнхаа дансаа яагаад ашиглаж болдоггүй юм. Заавал банканд очоод л данс нээлгэх биш, би энэ дансыг сонгуулийн данс болгосон юм аа, хөөрхий би нөгөө Туулын голыг долоох шахаж байж хэдэн төгрөг олоод түүн дээрээ нэмэх нь гээд яагаад байж болдоггүй юм. Ингээд явж болдоггүй юм уу. Тэр нь боохоор байгаа нийт лимитийнхээ тэнд байж болдоггүй юм уу. Би ийм л юм бодоод байгаа юм. Тэгээд түрүүн тэр цахим дээр ч гэсэн би бас 1 үг хэлэхгүй бол болохгүй байна, дарга аа. Бас нөгөө яриагүй сэдэв гээд битгий миний кноп дарчхаарай.

Би 5-хан минут ярьдаг, та нар бол 50 минут ярьдаг шүү дээ. 10 хүн ярихад л 50 минут. Би бол 5-хан минут л ярьж байгаа шүү дээ.

Миний хэлээд байгаа зарчим бол энгийн шүү дээ. Маш энгийн. Тэр нь юу вэ гэвэл энэ сошиал орчин, энээ тэрээ гэдгээр хүнийг гүтгэн доромжилж болохгүй ээ. Гэхдээ захиалгатайгаар одоо ч гэсэн гүтгэж байгаа. Одоо ч гэсэн доромжилж байгаа. Тагнуул нь ч тэрийг хийхгүй байгаа. Шалгахгүй байгаа. Харахгүй байгаа. Ийм нөхцөлд одоо бид яах юм бэ. Финиш гараанаас гарч болохгүй юм уу. Тэгж зарчмаас гарч болохгүй юм уу. Би хулгайч биш, гэхдээ яах вэ намайг доромжил л доо. Нөгөө Баасанхүү гэдэг нэр нь баас юм аа гээд доромжил л доо. Болно. Миний эцэг, эхийг доромжилж байгаатай адил би ойлгож байна.

Баахан комментоо та нар тавь. Гэхдээ эцсийн эцэст үүний цаана ямар чухал коммент ямар чухал юм алга болж байгааг та нар ойлгохгүй. Сонгуулиар та нар өнөөдөр өөрсдөө 22-хон хоногт 70 мянган хуудас тараа гэдэг бололцоотой хууль баталчихлаа шүү дээ. 100 мянган хуудас тараа гэж. Би дэвшиж байгаа шүү гэдэг л мессеж өгч байгаа л тийм эрхийг өгч байна шүү дээ. 1 цаасыг та нар 1000-аар бод доо. 100 мянгаар бод доо. 1 ширхэг цаасыг.

Л.Энх-Амгалан: Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгө, дансны асуудал ярьж байна шүү дээ. За гишүүд ээ санал хураах уу. Санал хураалт.

41 гишүүн оролцож, 26 гишүүн зөвшөөрч, 63,4 хувиар энэ санал дэмжигдэж байна.

7. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 49 дэх хэсгийн “цуглуулах” гэснийг “цуглуулсан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

41 гишүүн оролцож, 25 гишүүн зөвшөөрч, 61 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 39 дэх хэсгийн “нийтэлсэн” гэсний дараа цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн” гэж, 40 дэх хэсгийн “Интернэтийн” гэсний өмнө “Үүрэн холбооны болон” гэж, 50 дахь хэсгийн “бол” гэсний дараа “хууль бусаар зарцуулсан хөрөнгө, орлогыг хурааж” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

41 гишүүн оролцож, 27 гишүүн зөвшөөрч, 65,9 хувиар энэ санал дэмжигдэж байна.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17.1 дүгээр зүйлийн 54, 55, 56, 58 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“54.Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан сонгуулийн тухай хуульд заасан хэмжээнээс хэтрүүлсэн хандив өгсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

55.Эвсэлд нэгдсэн намд сонгуульд зориулж хандив өгсөн бол тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгөхийг хориглох бөгөөд зөрчвөл хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж зөрчсөн хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

56.Хандив өгөхийг хориглосон этгээд хандив өгсөн, авсан, хандив өгөхийг хориглосон этгээд болон эрх зүйн байдал нь тодорхойгүй этгээдээс өгсөн хандивыг буцаан шилжүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

58.Мөнгөн бус хандив өгөх талаар хуулиар тогтоосон журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. За Баасанхүү гишүүн.

Түрүүн уг нь яг энэ дээр та санал хэлсэн шүү дээ.

О.Баасанхүү: Түрүүн та энэ саналыг уншаад санал хураалгасан бол дахин санал хураалгах хэрэггүй биз дээ. Би аягүй тодорхой юм асуумаар байна. Өгсөн хандив давтан өгөх гээд. Манай энэ үйлчилж байгаа хууль дээр хувь хүн 3 билүү 5 ч билүү нэг сая төгрөг, албан байгууллага 15 билүү 20 сая төгрөг 1 удаа өгнө гээд.

Ажлын хэсэг дээр бид нар юу гэж яриад байсан бэ гэвэл 3-ыгаа 100, 100-аар 30 удаа өгнө үү, 3-ыгаа 5 удаа, 10 удаа өгнө үү хамаагүй гэж.

Гэтэл одоо та нарын хувьд бол нам гээд нэг ийм сонин ойлголт оруулж байгаа нь Ардчилсан намд зориулсан. Яагаад Ардчилсан намд зориулсан гэвэл 100 сая төгрөгөө нөхдүүд аваад өөрийнхөө үйлчлүүлж, юу гэдгийн нэр дэвшигчдээ зориулаад 15-ыг л өгнө, бусдыг намдаа ашигла, хандивыг нөгөө дээд лимитийг дээшээ өгвөл энэ намыг торгоё оо л гэж байгаа юм. Өөрсдөө бол та нар Эрдэнэс Таван Толгой, Эрдэнэтийг бол хулгайлсан шүү дээ. Хятадуудад өнөөдөр 100 тэрбумаар бүх тендерийг нь өгснийг Монголын ард түмэн мэдэж л байна. Өнөөдөр Эрдэнэс таван Толгой юу болж байгааг та нарыг харж л байна. Ямар баярхуу байгааг бүгд мэдэж л байна. Бүх эмнэлгийн дарга нарыг Солонгост очоод 3 хоногоор жаргааж байгааг чинь харж л байна. Ямар баярхуу байгааг чинь мэдэж л байна.

Гэхдээ хүмүүс яагаад ил тодоор намд жишээлбэл авч байгаа хандиваа аваад, нэр дэвшигч рүү мөнгөө шилжүүлж болдоггүй юм. Би намдаа мөнгөө хадгалуулъя л даа, 100 саяа хадгалуулж байгаад сонгуулийн үед надад юу гэдгийн би мөнгөө төлж чадахгүй нь ээ гээд нам руугаа утасддаг юм уу яадаг юм, баларлаа энээ тэрээ гээд тэд нар өгнө л биз. Тэр намын л асуудал шүү дээ. Намын хөрөнгө, намын санхүүжилт шилэн биш мөртөө нэг нам ингэж дарангуйлал хийж болохгүй ээ. Өнөөдөр та нарын горьдож бараг хажуудаа бөгсийг нь долоох шахдаг 2 тэнэг чинь энд одоо байхгүй. Ардчилсан нам чинь алга болчихлоо бараг. За энд байсан бие даагч байхгүй. Тэгээд та нар энэ хуулийг ганцаараа баталж байна шүү дээ. Үндсэн хууль шиг ээ. Та яах вэ дээ мэдээж, би ойлгож байна. Гэхдээ тийм байхгүй юу даа.

Ер нь бол энэ 40-хөн хүнтэй сонгуулийн хуулийг явуулаад өөрсдийнхөө тоглоомын дүрмийг хийж байгаагаа анхаараач ээ. 7 удаа сонгууль хийхдээ арай ч ийм 40-хөн хүнтэй байдаггүй юм. Ерөнхийлөгчөөс авсан добро-оороо явж байгаа бол ойлгож байна. Миеэгомбын Энхболд ч байхгүй л байгаа биз дээ, та нарын нөгөө унагаадаг, МАНАН мафийг

Л.Энх-Амгалан: Хандивтай холбоотой санал хураалт хийгээд байгаа шүү дээ. Санал хураалт гишүүд ээ.

41 гишүүн оролцож, 28 гишүүн зөвшөөрч, 68,3 хувиар энэ санал дэмжигдэж байна.

Найм. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 6.6” гэснийг “мөн зүйлийн 6.8” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

42 гишүүн оролцож, 28 гишүүн зөвшөөрч, 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлд “1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт 17.1 дүгээр” гэж, төслийн 2 дугаар зүйлийн 17.1 дүгээр зүйлийн 42 дахь хэсгийг хасаж, төслийн 1 дүгээр зүйлийн “41” гэсний ард “42,” гэснийг нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

42 гишүүн оролцож, 28 гишүүн зөвшөөрч, 66,7 хувиар энэ санал дэмжигдэж байна.

3.Төсөлд дараах агуулгатай 3 дугаар зүйлийг нэмэх:

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1.8.9.Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу шүүгч харьяалан шийдвэрлэх Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг 8.6, 8.7, 10.5 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.3, 15.4, 15.5, 15.7, 15.12 дугаар зүйлд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаагийн байгууллага, 17.1 дүгээр зүйлд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаа, тагнуул, шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын эрх бүхий албан тушаалтан, улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, татварын улсын байцаагч гүйцэтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

42 гишүүн оролцож, 30 гишүүн зөвшөөрч, 71,4 хувиар энэ санал дэмжигдэж байна.

Ес. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

42 гишүүн оролцож, 30 гишүүн зөвшөөрч, 71,4 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Ингээд хуулийн төслийг буцсан учраас Монгол Улсын Их хурлын тогтоолыг уншиж танилцуулъя.

Хуулийн төсөл буцаах тухай.

Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүнээс 2019 оны 12 дугаар сарын 2-ний өдөр Улсын Их хуралд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх уг асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонслоо.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт хийж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн чуулган өндөрлөж байна. Гишүүдэд баярлалаа. Маргааш 11 цагаас Төрийн байгуулалтын байнгын хороо, тэгээд 15 цагаас Улсын Их хурлын чуулган хуралдана. Өнөөдрийн чуулган өндөрлөж байна.

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ